



ᠵᠡᠨᠳᠡᠷᠢᠶᠢᠨ ᠲᠡᠭᠰᠢ  
ᠪᠠᠶᠳᠠᠯ

# ЖЕНДЕРИЙН ТЭГШ БАЙДАЛ



1  
БОЛОВСРОЛ,  
БИЧИГ ҮСГИЙН  
МЭДЛЭГ



2  
ШИЛЖИХ-  
ХӨДӨЛГӨВН,  
СУҮРЬШИЛ



3  
ӨНДӨР  
НАСТАЙ



4  
ӨРХ-ГЭР  
БУЛИЙН БАЙДАЛ,  
ГЭРЛЭЛТ



5  
ХӨГЖЛИЙН  
БЭРХШЭЭЛТЭЙ  
ИРГЭД




7  
ОРОН СУУЦНЫ  
АХУЙН НӨХЦӨЛ



8  
ИНТЕРНЕТ,  
ГАР УТАСНЫ  
ХЭРЭГЛЭЭ



9  
ХҮҮХЭД  
ЗАЛУУЧУУД



10  
ЭДИЙН ЗАСЛИЙН  
ИДЭВХ



11  
ХҮН АМЫН ТОО  
ХҮН АМЫН  
ХЭТГИЙН ТООЦОО  
2010-2040



12  
МЯНГАНЫ  
ХӨГЖЛИЙН  
ЗӨРИЛГЭЙН  
ҮЗҮҮЛЭЛТҮҮД



МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

**ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2010 ОНЫ УЛСЫН ТООЛЛОГО**

**ЖЕНДЕРИЙН ТЭГШ БАЙДАЛ**

Улаанбаатар хот  
2011 он

DDC  
305.3'021'517  
Ж-51

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Монгол улс, Улаанбаатар хот  
Сүхбаатар дүүрэг, Бага тойруу,  
Засгийн газрын III байр  
<http://www.nso.mn>  
И-мэйл: [nso@magicnet.mn](mailto:nso@magicnet.mn)

Сэдэвчилсэн судалгаанд тусгасан дүгнэлт, зөвлөмж нь уг судалгааг бичиж  
боловсруулсан судлаачдын дүгнэлт, санал болно.

Энэхүү судалгаа нь англи хэл дээр хэвлэгдэж, хэрэглэгчдийн хүртээл болно.

 **BCI** "BCI" Хэвлэлийн компани  
Утас: 319032

ISBN 978-99929-64-71-5

## АГУУЛГА

Тайлан бичихэд оролцогчид .....	iv
Хүснэгт, зургийн жагсаалт .....	v
Хавсралт хүснэгтийн жагсаалт.....	vi
Товчилсон үгийн тайлбар .....	x
Өмнөх үг.....	1
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. Удиртгал .....	3
ХОЁРДУГААР БҮЛЭГ. Хүн амын нас, хүйсийн бүтцийн өөрчлөлт .....	13
ГУРАВДУГААР БҮЛЭГ. Өрх, гэр бүл дэх жендерийн ялгаатай байдал .....	25
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. Хүн амын дотоод шилжих хөдөлгөөн дэх жендерийн ялгаатай байдал .....	45
ТАВДУГААР БҮЛЭГ. Боловсрол, сургуульд хамрагдалт .....	61
Дүгнэлт, зөвлөмж.....	79
Хавсралт .....	83
Тооллогын асуулгын хуудас .....	108

## СЭДЭВЧИЛСЭН СУДАЛГАА БИЧИХЭД ОРОЛЦОГЧИД

### НЭГ. СУДАЛГААГ БИЧИЖ БОЛОВСРУУЛСАН

**Базаржавын Лхагвасүрэн**

Эдийн засагч - Хүн ам зүйч

М-Си-Эс Менежмент ХХК-ны Судалгааны албаны дарга

**Базарваанийн Туяацэцэг**

Социологич

Шинэ Болгарын их сургуулийн докторант

**Зундуйн Цолмонбаяр**

Эдийн засагч – Хүн ам зүйч

Олон улсын харилцааны магистр

“SICA” ХХК-ны судлаач

### ХОЁР. ХЯНАН ТОХИОЛДУУЛСАН

**Цэнджавын Бадрах**

Эдийн засагч

ҮСХ-ны MNG4P103 төслийн зөвлөх

**Жигжидсүрэнгийн Ядамсүрэн**

Санхүү - Эдийн засагч

Эдийн засгийн ухааны доктор, профессор

**Бямбын Саранчимэг**

Статистикч

Эдийн засгийн ухааны магистр

ҮСХ-ны ХАНСГ-ын орлогч дарга

### ГУРАВ. ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ

**Жүгдэрийн Мөнхбадар**

Эдийн засагч - Хүн ам зүйч

ҮСХ-ны Хүн ам, орон сууцны тооллогын товчооны ахлах шинжээч

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.1.	Жендер ба хүйс хоорондын ялгаа.....	4
Хүснэгт 2.1.	Хүн амын болон төрсөн, нас барсан хүний тоо, хүйсээр, тооллогын онуудаар.....	15
Хүснэгт 2.2.	Хүн амын нас, хүйсийн бүтцийн үндсэн үзүүлэлт, 2000, 2010 он.....	17
Хүснэгт 2.3.	Хүн амын тоо, аймаг, нийслэл, хүйсээр, хүйсийн харьцаа, 2000-2010 он .....	21
Хүснэгт 3.1.	Өрхийн тоо, өрхийн хэлбэр, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр, хувиар, 2000, 2010 он.....	27
Хүснэгт 3.2.	Өрхийн ам бүлийн дундаж тоо, өрхийн хэлбэр, өрхийн тэргүүлэгчийн хүйс, хот, хөдөөгөөр, 2010 он.....	28
Хүснэгт 3.3.	Өрхийн тэргүүлэгчийн болон эхнэр/нөхрийн боловсролын түвшин, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр, 2000, 2010 он .....	29
Хүснэгт 3.4.	Өрхийн тэргүүлэгчийн болон эхнэр/нөхрийн хөдөлмөр эрхлэлт, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр, 2000, 2010 он .....	31
Хүснэгт 3.5.	Өрхийн тоо, сууцны эзэмшлийн хэлбэр, сууцны төрөл, өрхийн тэргүүлэгчийн хүйс, хот, хөдөөгөөр, 2010 он .....	32
Хүснэгт 3.6.	Өрх толгойлсон эцэг, эхийн тоо, өрхийн хэлбэр, хот, хөдөө, хувиар, 2000, 2010 он .....	33
Хүснэгт 3.7.	Өрх толгойлсон эцэг, эхийн тоо, боловсролын түвшин, хувиар, 2000, 2010 он.....	36
Хүснэгт 3.8.	Хөдөлмөр эрхэлдэг өрх толгойлсон эцэг, эхийн тоо, ажил мэргэжлийн ангилал, хот, хөдөө, хувиар, 2010 он .....	39
Хүснэгт 3.9.	Хөдөлмөр эрхэлдэг өрх толгойлсон эцэг, эхийн тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал, хот, хөдөө, хувиар, 2010 он .....	41
Хүснэгт 3.10.	Өрх толгойлсон эцэг, эхийн тоо, ажил эрхлэхгүй байгаа шалтгаан, хувиар, 2000, 2010 он.....	42
Хүснэгт 3.11.	Өрх толгойлсон эцэг, эхийн тоо, сууцны эзэмшлийн хэлбэр, сууцны төрөл, хот, хөдөө, хувиар, 2010 он.....	43
Хүснэгт 4.1.	Хүн амын тоо, хүйсийн харьцаа, тухайн газарт суусан хугацаагаар, 2000, 2010 он .....	47
Хүснэгт 4.2.	Шилжигчдийн насны бүлэг дэх хүйсийн харьцаа, тухайн газарт суусан хугацаагаар, 2000, 2010 он.....	48
Хүснэгт 4.3.	Тухайн аймаг, нийслэлд төрсөн болон одоо амьдарч байгаа хүн амын хүйсийн харьцаа, төрснөөс хойш шилжих хөдөлгөөнд орсон эсэхээр, 2000, 2010 он.....	52
Хүснэгт 4.4.	Зургаа, түүнээс дээш насны хүн амын хүйсийн харьцаа, боловсролын түвшин, шилжих хөдөлгөөнд орсон эсэхээр, 2010 он .....	54
Хүснэгт 4.5.	Арван тав. түүнээс дээш насны хүн амын хүйсийн харьцаа, гэр бүлийн байдал, шилжих хөдөлгөөнд орсон эсэхээр, 2010 он .....	54
Хүснэгт 4.6.	Эдийн засгийн идэвхтэй хүн амын ажил мэргэжлийн ангилал, шилжих хөдөлгөөнд орсон эсэх, хүйс, хувиар, 2010 он.....	57
Хүснэгт 4.7.	Зургаа, түүнээс дээш насны хүн амын гар утас, интернетийн хэрэглээ, шилжих хөдөлгөөнд орсон эсэх, хүйс, хувиар, 2010 он.....	57
Хүснэгт 4.8.	Хүн амын хүйсийн харьцаа, шилжих хөдөлгөөнд орсон эсэх, хөгжлийн бэрхшээл, хүйс, хувиар, 2010 он.....	58



Хүснэгт 5.1.	Арван тав, түүнээс дээш насны хүн амын тоо, бичиг үсгийн мэдлэг, хувиар, 2000, 2010 он.....	62
Хүснэгт 5.2	Зургаа, түүнээс дээш насны хүн амын хувь, бичиг үсгийн мэдлэг, хот, хөдөө, хүйсээр, 2010 он.....	63
Хүснэгт 5.3.	Зургаа, түүнээс дээш насны хүн амын тоо, бичиг үсгийн мэдлэг, хүйс, бүс, аймаг, нийслэлээр, 2010 он.....	64
Хүснэгт 5.4.	Хоёроос таван насны хүн амын тоо, насны бүлэг, цэцэрлэгт хүмүүждэг эсэх, хүйсээр, 2010 он.....	65
Хүснэгт 5.5.	Цэцэрлэгт хүмүүждэг 2-5 насны хүүхдийн тоо, нас, хүйс, хот, хөдөөгөөр, 2010 он.....	66
Хүснэгт 5.6.	Цэцэрлэгт хүмүүждэггүй 2-5 насны хүүхдийн тоо, нас, хүйс, хот, хөдөөгөөр, 2010 он.....	67
Хүснэгт 5.7.	Сургуульд суралцдаг 6-15 насны хүн амын тоо, нас, хүйс, хот, хөдөөгөөр, 2010 он.....	67
Хүснэгт 5.8.	Долоогоос хорин есөн насны хүн амын сургуульд хамрагдалт, нас, хүйс, хот, хөдөө, хувиар, 2000, 2010 он.....	68
Хүснэгт 5.9.	Зургаагаас арван таван насны хүн амын сургууль завсардалт, нас, хүйс, бүс, аймаг, нийслэлээр, 2010 он.....	73
Хүснэгт 5.10.	Арав, түүнээс дээш насны боловсролтой хүн амын эзлэх хувь, хүйс, насны бүлгээр, 2000, 2010 он.....	74
Хүснэгт 5.11.	Багшийн ажил эрхэлдэг хүн амын хүйсийн харьцаа, насны бүлэг, боловсролын шатлалаар, 2010 он.....	78

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 2.1.	Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогоор нас, хүйсийг тодорхойлсон үзүүлэлт.....	14
Зураг 2.3.	Хүн амын нас, хүйсийн суварга, 2000, 2010 он.....	16
Зураг 2.2.	Хүн амын хүйсийн харьцаа, 2000, 2010 он.....	16
Зураг 2.4.	Эрэгтэй, эмэгтэй хүний тооны зөрүү, насны бүлгээр, 2000, 2010 он.....	17
Зураг 2.5.	Хот, хөдөөгийн хүн амын нас, хүйсийн суварга, 2000, 2010 он.....	18
Зураг 2.6.	Хот, хөдөөгийн хүн амын хүйсийн харьцаа, 2000, 2010 он.....	18
Зураг 2.7.	Хот, хөдөөгийн эрэгтэй, эмэгтэйчүүдийн тооны зөрүү, насны бүлгээр, 2000, 2010 он.....	19
Зураг 2.8.	Нийслэл, зарим аймгийн нас, хүйсийн суварга, 2000, 2010 он.....	20
Зураг 2.9.	Зуун эмэгтэйд ногдох эрэгтэй хүн амын тоо, зөрүүгээр, 2000, 2010 он.....	22
Зураг 2.10.	Эрэгтэй, эмэгтэйчүүдийн тооны зөрүү, насны бүлэг, аймаг, нийслэлээр, 2000, 2010 он.....	23
Зураг 3.1.	Хот, хөдөөгийн өрхийн өсөлт, өрхийн тэргүүлэгчийн хүйс, өрхийн хэлбэр, хувиар, 2000-2010 он.....	27
Зураг 3.2.	Өрхийн тэргүүлэгчийн нас, хүйсийн суварга, хот, хөдөө, хувиар, 2000, 2010 он.....	28
Зураг 3.3.	Эхнэр/нөхрийн хамт тоологдсон өрхийн тэргүүлэгчийн боловсролын түвшин, өрхийн тэргүүлэгчийн хүйс, хувиар, 2000, 2010 он.....	30

Зураг 3.4.	Өрх толгойлсон эцэг, эхийн хувь, насны бүлгээр, 2000, 2010 он .....	34
Зураг 3.3.	Салсан өрх толгойлсон эцэг, эхийн хувь, насны бүлгээр, 2000, 2010 он.....	34
Зураг 3.5.	Өрх толгойлсон эцэг, эхийн нас, хүйсийн суварга, байршлаар, 2000, 2010 он.....	35
Зураг 3.6.	Өрх толгойлсон эцэг, эхийн хувь, Гэр бүлийн байдлаар, 2000, 2010 он.....	35
Зураг 3.7.	Хүүхдийн дундаж тоо, өрх толгойлсон эцэг, эхийн хөдөлмөр эрхэлдэг эсэхээр, 2000, 2010 он .....	37
Зураг 3.8.	Өрх толгойлсон эцэг, эхийн хувь, хөдөлмөр эрхэлдэг эсэх, хот, хөдөөгөөр, 2000, 2010 он.....	38
Зураг 4.1.	Шилжигчдийн тоо, хүйсийн харьцаа, шилжих хөдөлгөөнд оролцсон хугацаа, мянган хүнээр, 2000, 2010 он.....	46
Зураг 4.2.	Шилжигч, шилжигч бус хүн амын нас, хүйсийн суварга, мянган хүнээр, 2000, 2010 он.....	47
Зураг 4.3.	Шилжигч, шилжигч бус хүн амын насны бүлэг дэх хүйсийн харьцаа, 2000, 2010 он .....	48
Зураг 4.4.	Шилжигч, шилжигч бус хүн амын хувь, насны бүлгээр, 2000, 2010 он.....	49
Зураг 4.5.	Хот, хөдөөгийн хүн амын хүйсийн харьцаа, шилжих хөдөлгөөнд оролцсон байдлаар, 2000, 2010 он .....	49
Зураг 4.6.	Хот, хөдөөгийн хүн амын нас, хүйсийн суварга, төрснөөс хойш шилжих хөдөлгөөнд орсон эсэхээр, 2010 он .....	50
Зураг 4.7.	Сүүлчийн 1 жилд шилжих хөдөлгөөнд орсон хот, хөдөөгийн эрэгтэй, эмэгтэй хүний тооны зөрүү, насны бүлгээр, 2010 он .....	51
Зураг 4.8.	Сүүлчийн 5 жилд шилжих хөдөлгөөнд орсон эрэгтэй, эмэгтэйчүүдийн хамгийн сүүлд шилжин суурьшсан байршил, хувиар, 2010 он .....	51
Зураг 4.9.	Тухайн аймаг, нийслэлд төрсөн болон одоо амьдарч байгаа эрэгтэй, эмэгтэй хүний тооны зөрүү, 2000, 2010 он .....	53
Зураг 4.10.	Арван тав, түүнээс дээш насны хүн амын эдийн засгийн идэвх, шилжих хөдөлгөөнд орсон эсэх, хүйс, хувиар, 2010 он .....	55
Зураг 4.11.	Эдийн засгийн идэвхгүй хүн амын хөдөлмөр эрхлэхгүй байгаа шалтгаан, шилжих хөдөлгөөнд орсон эсэх, хүйс, хувиар, 2010 он .....	55
Зураг 4.12.	Эдийн засгийн идэвхтэй хүн амын хөдөлмөр эрхлэлт, шилжих хөдөлгөөнд орсон эсэх, хүйс, хувиар, 2010 он .....	56
Зураг 4.13.	Өрхийн сууцны төрөл, шилжих хөдөлгөөнд орсон өрхийн тэргүүлэгчийн хүйс, хувиар, 2010 он.....	58
Зураг 4.14.	Өрхийн сууцны эзэмшлийн хэлбэр, өрхийн тэргүүлэгчийн шилжих хөдөлгөөнд орсон эсэх, хүйс, хувиар, 2010 он.....	59
Зураг 5.1.	Зургаа, түүнээс дээш насны боловсролгүй хүн амын нас, хүйсийн суварга, 2010 он .....	63
Зураг 5.2.	Хоёроос таван насны хүүхдийн тоо, цэцэрлэгт хүмүүждэг эсэх, хүйс, хувиар, 2010 он.....	66
Зураг 5.3.	Зургаагаас арван нэгэн насны хүүхдийн сургуульд хамрагдалт, хүйс, хот, хөдөө, хувиар, 2010 он.....	69
Зураг 5.4.	Зургаагаас арван нэгэн насны хүүхдийн сургуульд хамрагдалт, хүйс, хувиар, 2010 он.....	70



Зураг 5.5.	Арван хоёроос арван таван насны хүн амын суурь боловсролд хамрагдалт, хүйс, хот, хөдөө, хувиар, 2010 он.....	70
Зураг 5.6.	Сургууль завсардсан хүн амын нас, хүйсийн суварга, 2010 он .....	71
Зураг 5.7.	Сургууль завсардсан 6-15 насны хүн амын тоо, хүйс, бүсээр, 2010 он .....	72
Зураг 5.8.	Арван тав, түүнээс дээш насны хүн амын боловсролын түвшин, хүйс, хувиар, 2010 он.....	75
Зураг 5.9.	Дээд болон тусгай мэргэжлийн дунд боловсролтой хүн амын нас, хүйсийн суварга, 2000, 2010 он .....	75
Зураг 5.10.	Арван тав, түүнээс дээш насны тусгай мэргэжлийн дундаас дээш боловсролтой хүн ам, насны бүлэг, хүйс, хувиар, 2000, 2010 он.....	76
Зураг 5.11.	Багшийн ажил эрхэлдэг хүн ам, боловсролын шатлал, хүйс, хот, хөдөө, хувиар, 2010 он.....	77

## ХАВСРАЛТ ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	Өрхийн тоо, өрхийн тэргүүлэгчийн насны бүлэг, өрхийн хэлбэр, өрхийн тэргүүлэгчийн хүйс, хот, хөдөөгөөр, 2010 он .....	84
Хүснэгт 2.	Өрхийн тоо, ам бүлийн тоо, өрхийн хэлбэр, тэргүүлэгчийн хүйс, хот, хөдөөгөөр, 2010 он.....	85
Хүснэгт 3.	Өрхийн тоо, өрхийн тэргүүлэгчийн насны бүлэг, гэр бүлийн байдал, өрхийн тэргүүлэгчийн хүйс, хот, хөдөөгөөр, 2010 он .....	86
Хүснэгт 4.	Өрх толгойлсон эцэг, эхийн тоо, насны бүлэг, гэрлэлтийн байдал, хот, хөдөөгөөр, 2010 он.....	87
Хүснэгт 5.	Өрх толгойлсон эцэг, эхийн тоо, насны бүлэг, өрхийн хэлбэр, хот, хөдөөгөөр, 2010 он.....	88
Хүснэгт 6.	Өрх толгойлсон эцэг, эхийн тоо, аймаг, нийслэл, өрхийн хэлбэрээр, 2010 он .....	89
Хүснэгт 7.	Өрх толгойлсон эцэг, эхийн тоо, хүүхдийн тоо, хөдөлмөр эрхэлдэг эсэх, хот, хөдөөгөөр, 2010 он.....	89
Хүснэгт 8.	Өрх толгойлсон эцэг, эхийн тоо, ам бүлийн тоо, сууцны төрөл, хот, хөдөөгөөр, 2010 он.....	90
Хүснэгт 9.	Хөдөлмөр эрхэлдэг өрх толгойлсон эцэг, эхийн тоо, ЭЗ-ийн үйл ажиллагааны салбар, ажил мэргэжлийн ангилал, хот, хөдөөгөөр, 2010 он.....	91
Хүснэгт 10.	Тав, түүнээс дээш насны хүн амын төрснөөс хойш шилжих хөдөлгөөнд орсон байдал, хүйс, насны бүлэг, хот, хөдөөгөөр, 2010 он.....	94
Хүснэгт 11.	Арван тав, түүнээс дээш насны хүн амын төрснөөс хойш шилжих хөдөлгөөнд орсон байдал, шилжин суурьшсан хугацаа, хүйс, гэр бүлийн байдлаар, 2010 он ....	95
Хүснэгт 12.	Зургаа, түүнээс дээш насны хүн амын шилжих хөдөлгөөнд орсон байдал, шилжин суурьшсан хугацаа, хүйс, боловсролын түвшингээр, 2010 он.....	96
Хүснэгт 13.	Арван тав, түүнээс дээш насны хүн амын эдийн засгийн идэвх, төрснөөс хойш шилжих хөдөлгөөнд орсон байдал, шилжин суурьшсан хугацаа, хүйсээр, 2010 он .	97
Хүснэгт 14.	Зургаа, түүнээс дээш насны хүн амын төрснөөс хойш шилжих хөдөлгөөнд орсон байдал, шилжин суурьшсан хугацаа, гар утасны хэрэглээ, хүйсээр, 2010 он.....	98

Хүснэгт 15.	Зургаа, түүнээс дээш насны хүн амын төрснөөс хойш шилжих хөдөлгөөнд орсон байдал, шилжин суурьшсан хугацаа, интернетийн хэрэглээ, хүйсээр, 2010 он .....	98
Хүснэгт 16.	Хүн амын төрснөөс хойш шилжих хөдөлгөөнд орсон байдал, шилжин суурьшсан хугацаа, хөгжлийн бэрхшээлтэй эсэх, хүйсээр, 2010 он .....	99
Хүснэгт 17.	Өрхийн тэргүүлэгч шилжих хөдөлгөөнд орсон байдал, сууцны төрөл, эзэмшлийн хэлбэр, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр, 2010 он .....	99
Хүснэгт 18.	Хүн амын төрснөөс хойш шилжих хөдөлгөөнд орсон байдал одоо амьдарч байгаа аймаг, нийслэл, хүйсээр, 2010 он .....	100
Хүснэгт 19.	Зургаа, түүнээс дээш насны боловсролгүй хүн ам, насны бүлэг, хүйс, бичиг үсгийн мэдлэгээр, 2010 он .....	101
Хүснэгт 20.	Зургаа, түүнээс дээш насны боловсролтой хүн ам, насны бүлэг, хүйс, боловсролын түвшингээр, 2010 он .....	102
Хүснэгт 21.	Хоёроос гучин есөн насны хүн ам, насны бүлэг, хүйс, СӨБ, сургуульд хамрагддаг эсэхээр, 2010 он .....	103
Хүснэгт 22.	Бага боловсролын шатны сургуульд хамрагддаг 6-11 насны хүн ам, аймаг, нийслэл, хот, хөдөө, хүйсээр, 2010 он .....	104
Хүснэгт 23.	Суурь, бүрэн дунд боловсрол, МСҮТ-д хамрагддаг хүн ам, аймаг, нийслэл, хот, хөдөө, хүйсээр, 2010 он .....	105
Хүснэгт 24.	Сургууль завсардсан 6-15 насны хүүхдийн тоо, насны бүлэг, хүйс, аймаг, нийслэлээр, 2010 он .....	107

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

БНХАУ	Бүгд найрамдах Хятад ард улс
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗТБХБЯ	Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам
МАХН	Монгол ардын хувьсгалт нам
МСҮТ	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ХАА	Хөдөө аж ахуй
ХХ	Хүйсийн харьцаа

## ӨМНӨХ ҮГ



Хүн ам, орон сууцны тооллого бол хүн ам зүй, нийгэм, эдийн засаг, орон сууцны нөхцөлийн талаарх суурь мэдээллийг агуулсан, дүнг нь нутаг дэвсгэрийн нэгжийн хамгийн бага түвшинд гаргах боломжтой цорын ганц мэдээллийн эх үүсвэр юм. 2010 оны улсын тооллогын дүнд үндэслэн 13 төрлийн сэдэвчилсэн судалгааг богино хугацаанд хийж гүйцэтгэсний нэг болох “Жендерийн тэгш байдал” судалгааг хэрэглэгч Та бүхний хүртээл болгож байгаадаа таатай байна.

Албан ёсны болон захиргааны статистикийн тоо мэдээллийг хүйсээр ангилах, жендерийн мэдрэмжтэй болгох болон аль болох анхдагч түвшний задаргаатайгаар хэрэглэгчдэд хүргэх нь статистикийн салбарын тэргүүлэх зорилтуудын нэг билээ. Тиймээс тооллогын дүнгээр боловсруулан гаргаж байгаа бусад сэдэвчилсэн судалгааны зохих тоо мэдээллийг хүйсээр ангилж, хэрэглэгчдэд хүргэхийг зорьсон.

“Жендерийн тэгш байдал” нэгэн сэдэвт бүтээл нь 2000 оны тооллогын дүнгээр боловсруулсан “Монгол Улс дахь хүйсийн ялгаатай байдал” сэдэвчилсэн судалгаагаар дүйцэхүйц юм. Энэхүү судалгаа нь Монгол Улсын сүүлчийн 11 жил орчмын хугацааны эдийн засаг, нийгмийн салбарын хөгжил, өөрчлөлт эрэгтэй, эмэгтэйчүүдийн амьдралд хэрхэн ялгаатайгаар туссаныг харуулснаараа онцлог юм. Жендер нь зөвхөн нэг салбарт хамаатай бус, бүхий л салбарыг хамарсан өргөн хүрээтэй асуудал учраас энэхүү судалгааны агуулгыг боловсрол, эдийн засгийн идэвх, өрх, гэр бүлийн байдал зэрэг бусад сэдэвчилсэн судалгаагаар давхцуулахгүй байхаар боловсруулсныг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Боловсрол дахь жендерийн тэгш бус байдал улс орны нийгэм, эдийн засаг төдийгүй өрх, гэр бүлийн түвшинд нөлөөлж эхэлсэн байна. Мөн уул уурхайн үйлдвэрлэлтэй холбоотой бүтээн байгуулалт зарим аймгийн хүн амын нас, хүйсийн бүтцэд тэнцвэрт бус харьцааг бий болгож, шилжих хөдөлгөөнд оролцогч эрэгтэй, эмэгтэйчүүдийн уламжлалт шинж байдал өөрчлөгдөж байгааг Та бүхэн судалгааны үр дүнгээс харах боломжтой.

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын дүнд үндэслэн боловсруулсан энэхүү сэдэвчилсэн судалгаа нь жендерийн талаар бодлого боловсруулагч, эрдэмтэн, судлаачдад үнэтэй мэдээлэл болно гэдэгт итгэлтэй байна.

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА,  
ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2010 ОНЫ ТООЛЛОГЫН  
УЛСЫН КОМИССЫН ОРЛОГЧ ДАРГА

 С.МЭНДСАЙХАН



# НЭГЛҮГЭЭР БҮЛЭГ

УДИРТГАЛ



## ЖЕНДЕР, ЖЕНДЕРИЙН СТАТИСТИКИЙН ТАЛААРХ НИЙТЛЭГ ОЙЛГОЛТ

Хүний нийгмийн хөгжлийн орчин цагийн хэрэгцээ нь хувь хүний эрхийг хүндэтгэх, ялангуяа хүнийг аливаа хэлбэрээр ялгаварлах, түүний дотор хүйсээр ялгаварлан гадуурхах явдлыг арилгах буюу эрэгтэй, эмэгтэйчүүдийн жендерийн тэгш эрх, тэгш байдлыг тогтоохыг шаардаж байна.

Жендер гэдэг нь англи хэлээр илэрхийлсэн агуулга юм. Олон улсад хэрэглэдэг нийтлэг ойлголтоор жендер нь тодорхой нэг соёл, иргэншил, газар нутаг, нийгэм, цаг хугацаанд эмэгтэй, эрэгтэйчүүдэд нийгмийн зүгээс оноосон үүрэг, хариуцлага юм. Хүйс гэдэг нэр томъёо нь хүний биологийн шинж чанаруудтай холбоотой учир тэдгээр шинж нь төрөлхийн уг чанарт хамаардаг, өөрчлөх боломжгүй байдаг.

Жендерийн тэгш байдал гэдэг нь тухайн нийгэмд тодорхой үнэ цэнэ бүхий бүтээгдэхүүн, боломж, нөөц урамшууллыг эрэгтэй, эмэгтэй хүмүүс тэгш эдлэх эрхтэйг илэрхийлдэг.

Монгол Улсын “Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай” хуульд “жендер” гэж улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, тэдний нийгэмд эзлэх байр суурийн талаар уламжлагдан тогтсон, түүхэн явцад хувьсан өөрчлөгддөг ойлголт, үзэл, хандлагыг; “жендерийн эрх тэгш байдал” гэж эрэгтэй, эмэгтэй хүн улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцож, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн үр шимээс тэгш хүртэж, хөгжилд эрх тэгш хувь нэмрээ оруулснаар жендерийн ялгаварлан гадуурхалтаас ангид байхыг хэлнэ” гэж заажээ.

Хүйс болон жендер хоёрын хоорондын зарим ялгааг Хүснэгт 1-т харууллаа.

### ХҮСНЭГТ 1.1. ЖЕНДЕР БА ХҮЙС ХООРОНДЫН ЯЛГАА

Жендер	Хүйс
<ul style="list-style-type: none"> <li>Эмэгтэй, эрэгтэй хүнд нийгмээс оноосон үүрэг хариуцлага</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Эрэгтэй, эмэгтэй хүний биологийн шинжүүд</li> </ul>
<ul style="list-style-type: none"> <li>Цаг хугацаанаас шалтгаалан өөрчлөгдөнө.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Байнгын/тогтсон шинжтэй, цаг хугацааны явцад өөрчлөгдөхгүй.</li> </ul>
<ul style="list-style-type: none"> <li>Өөр өөр соёл иргэншлийн хувьд ялгаатай.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Өөр соёл иргэншлийн хувьд ч ялгаагүй.</li> </ul>
<ul style="list-style-type: none"> <li>Боловсрол, орлогын түвшин, нас, нийгмийн гарал үүсэл, шашин болон бусад хүчин зүйлд нөлөөлдөг.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Эдийн засгийн, нийгмийн хүчин зүйл нөлөөлөхгүй.</li> </ul>
<ul style="list-style-type: none"> <li>Зөвхөн эмэгтэйчүүдийн болон эрэгтэйчүүдийн дунд ч гэсэн тэдний нас, үндэс угсаа, орлогын түвшин, соёл, уламжлал болон бусад хүчин зүйлээс шалтгаалан ялгаатай байдаг.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хувьд ижил.</li> </ul>

Гэр бүл нь хүний амьдралын анхдагч орчин, нийгэм, биологийн нэлээд тогтвортой бичил хамтлаг учир хүний нийгмийн түүхэн явцад бүрэлдэн тогтож, түүний нөлөөнд автагдан бас түүний хөгжилд хүчтэй нөлөөгөө үзүүлсээр ирсэн бөгөөд энэ нь жендерийн хэвшмэл ойлголт хандлага хүчтэй илэрч, олон үр дагавар бий болгож байдаг орчин юм.

Жендерийн статистик нь статистикийн бүх салбартай хамааралтай. Тэр нь жендерийн асуудалд чиглэсэн шаардлагатай өөрчлөлтийг дэмжих хэрэгсэл юм. Жендерийн мэдрэмжтэй мэдээлэл нь зөвхөн хүйсээр ялгасан тоо гаргахын нэр биш, жендерийн статистик нь жендерийн ялгаа болон түүний асуудлын талаар системтэй судлах боломж олгодог. Хүйсээр ялган гаргасан тоо нь жендерийн мэдрэмжтэй мэдээллийн нэг бүрэлдэхүүн хэсэг юм. Жендерийн статистик нь нотолгоо/баримтад тулгуурласан судалгаа, бодлогын шийдлээр хангах, эрэгтэй, эмэгтэйчүүдийн ялгаатай нөхцөл байдлыг үнэлэх, түүнд гарч байгаа өөрчлөлтийг хянах, ахиц дэвшил, өөрчлөлтийг олон нийт, хэрэглэгчдэд мэдээлэхэд чухал бөгөөд статистикийн системийг бүхэлд нь боловсронгуй болгоход чухал үүрэг гүйцэтгэдэг. Өөрөөр хэлбэл, хүн амын үйл ажиллагаа, онцлог шинжийг илүү бодитой, бүрэн илэрхийлж харуулахад түлхэх хүч болдог<sup>1</sup>.

Жендерийн статистикийн түүхээс сөхвөл, НҮБ-аас 1975 оныг “Олон улсын эмэгтэйчүүдийн жил” болгон зарлахын зэрэгцээ Мексикийн Мехико хотноо Дэлхийн эмэгтэйчүүдийн анхдугаар бага хурлыг зохион байгуулж, энэхүү анхдугаар чуулган эмэгтэйчүүдийн талаарх статистик мэдээлэл гаргах нь маш чухал ач холбогдолтой гэдгийг онцлон тэмдэглэж байжээ. Энэ хурлаас хойш статистикийн байгууллагууд эмэгтэйчүүдийн талаарх мэдээллийг цуглуулж эхэлсэн. НҮБ 1980 онд Дани улсын нийслэл Копенгаген хотноо дэлхийн эмэгтэйчүүдийн хоёрдугаар бага хурлыг, 1985 онд Кени улсын нийслэл Найробид дэлхийн эмэгтэйчүүдийн гуравдугаар бага хурлыг тус тус зохион байгуулж, гуравдугаар бага хурлын үеэр олон улсын статистикийн систем жендерийн статистикийн мэдээлэл гаргах чиглэлээр илүү анхаарч ажиллах, тоо мэдээлэл гаргагч, бодлого боловсруулагчдын хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр тодорхой алхмуудыг хийхээр санал гаргасан. Энэ үеэс “эмэгтэйчүүд хөгжилд” гэсэн стратегийн ерөнхий зарчмаас “жендер ба хөгжил” гэсэн шинэ үзэл баримтлал руу шилжсэн юм. Үүнтэй уялдан статистик ч мөн “эмэгтэйчүүдийн талаарх статистик мэдээлэл”-ээс “эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн талаарх статистик мэдээлэл” рүү шилжиж “жендерийн асуудлуудыг статистикийн мэдээлэлд нэгтгэх үйл явц”-ыг эхэлсэн. Энэ үеэс НҮБ болон олон улсын бусад байгууллагаас нийгэм, эдийн засгийн хөгжилд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн ялгаатай үүрэг ролийг харуулах статистикийн мэдээллийг хэрхэн гаргах талаар заавар, зөвлөмж гаргаж, үндэсний хэмжээнд мөрдөж ажиллахыг зөвлөмж болгосон. Үүний үр дүнд БНХАУ-ын нийслэл Бээжин хотноо дэлхийн эмэгтэйчүүдийн дөрөвдүгээр бага хурал хуралдсан. 1995 он болоход олон орны үндэсний статистикийн байгууллага эрэгтэй, эмэгтэйчүүдийн талаарх статистик мэдээллээр ном, товхимол бэлтгэж хэрэглэгчдэд хүргэдэг болсон бөгөөд ойлголт, тодорхойлолт, мэдээлэл цуглуулалт, арга зүйгээ сайжруулах чиглэлээр нэлээд их хүчин чармайлт гаргасан нь харагдаж байлаа.

Бээжингийн бага хурал нь олон улсын болон үндэсний түвшинд жендерийн статистикийг хөгжүүлэх шинэ хөдөлгөгч хүч болсон бөгөөд үүнээс хойш олон орны үндэсний статистикийн байгууллага жендерийн статистикийн нэгж байгуулж, албан ёсны статистикийн мэдээлэл гаргахад бүхэлд нь жендерийн асуудлыг нэгтгэн тусгах тусгай хөтөлбөр боловсруулан ажиллаж байна<sup>2</sup>.

<sup>1</sup> UNECE, “Developing Gender Statistics: A Practical Tool”, 2010

<sup>2</sup> UNECE: Brief history of Gender statistics

## ЭРЭГТЭЙ, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ТЭГШ ЭРХ, ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦООНЫ ХӨГЖИЛ

Бээжин хотноо 1995 онд хуралдсан Дэлхийн эмэгтэйчүүдийн бага хурлаас гаргасан Мөрийн хөтөлбөрт: үндэсний механизм нь Засгийн газраас жендерийн өргөн хүрээний асуудлыг нийгэм, эдийн засгийн нийт бодлогод тусгахыг дэмжиж, жендерийн тэгш байдлын хэтийн төлвийг хангах үүрэг хүлээсэн төрийн бодлогыг уялдуулан зохицуулах үүрэг бүхий нэгж юм. Жендерийн үндэсний тогтолцоо нь Засгийн газрын салбар байгууллагууд /яамд/-аар дамжуулан жендерийн тэгш байдлыг хангах стратегийг хэрэгжүүлэх, бодлогоор дэмжих төдийгүй “өөрчлөлт хийх манлайлагч хүч юм” гэжээ.

Монгол Улс “Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай” болон “Хүүхдийн эрхийг хамгаалах” конвенци зэрэг хүний эрхийн 29 гэрээ конвенцид нэгдэн орсон билээ. Мөн “Хөдөөгийн эмэгтэйчүүдийн байдлыг сайжруулах” 1992 оны Женевийн тунхаглалыг зөвшөөрсөн юм.

### 1921 ОНООС ӨМНӨХ ҮЕ

Ардын хувьсгалаас өмнөх үеийн Монголын нийгэмд эрэгтэй, эмэгтэйчүүдийн ажил, хөдөлмөр нарийн хуваарьтай, эцгийн эрхт ёс давамгайлж, нийгэм, эдийн засаг, улс төрийн амьдралын нэлээд хэсэгт эмэгтэйчүүд хоёр дахь байр суурийг эзэлж байв. Олон нийтийн амьдралд эмэгтэйчүүдийн оролцоо сул байсан тул шийдвэр гаргах түвшинд эрэгтэйчүүд давамгайлж байлаа. Шарын шашин нийгмийн амьдралд чухал байр суурь эзэлж, эрэгтэйчүүд олноороо сахил хүртэж байв. Энэ нь төрөлтийн бууралтад мэдэгдэхүйц нөлөөлж, хүн амын тоо цөөрөхөд хүргэжээ. Эмэгтэйчүүдийн үүрэг хариуцлага зөвхөн гэр бүл, ах дүү, эх хүний үүрэг хариуцлагын хүрээнд хязгаарлагдаж байв<sup>3</sup>.

### АРДЫН ХУВЬСГАЛААС ХОЙШИХ ҮЕ БОЛОН СОЦИАЛИЗМЫН ҮЕ

Монгол Улсын эмэгтэйчүүдийн аж байдалд 1921 оны ардын хувьсгал үлэмж их өөрчлөлт авчирсан юм. 1924 онд батлагдсан Монгол Улсын анхны Үндсэн хуульд “Тус улсын харьяат ард түмэн, иргэн угсаа, шашин, эрэгтэй, эмэгтэй гэдэг ялгаагүйгээр нэгэн адил эрхийг эдлүүлбэл зохино”<sup>4</sup> гэж хүйсийн тэгш байдлыг тунхагласан байдаг. Энэ хүрээнд эмэгтэйчүүдийн эрхийг баталгаажуулж, бие хүнд эрх чөлөө олгож, гэрлэх хүнээ өөрсдөө сонгох эрхийг олгосон зэрэг өөрчлөлт гарчээ.

Монгол Ардын Намаас түмэнд тунхаглан зарлах бичигт монгол үндэсний төлөө зүтгэхийг хүссэн шударга үнэнч хэнийг ч боловч нийгмийн гарал үүсэл, хүйс үл харгалзан намд элсүүлэхээр заасан нь монголын эмэгтэйчүүдийг улс төрийн хэрэгт оролцох үүд хаалгыг нээжээ.

“Бошгыг халах залуучуудын эвлэл” хэмээх нэртэй залуучуудын байгууллага 1921 оны 8 дугаар сарын 25-ны өдөр байгуулагдав. Тэр үед манай эмэгтэйчүүд шашны арга хэмжээнээс өөр хурал, цуглаанд оролцож үзээгүй, бичиг үсэг мэддэг нь цөөн байсан хэдий ч нийгмийн идэвхтэй эмэгтэйчүүд монгол бичиг үсэг төдийгүй түвд, манж, хятад, орос хэл сурч, мэдээлэл авч, шинэ цагийн суртал нэвтрүүлгийн ажилд оролцож байжээ. Хүн амын 49.1 хувийг эзэлж байсан эмэгтэйчүүдийг нийгэм, улс төрийн үйл хэрэгт татан оролцуулахын чухлыг нам, эвлэлийн гишүүд мэдэрч, энэ үйл ажиллагааг зохион байгуулж, эмэгтэйчүүдэд туслах байгууллага бий болгох тухай янз бүрийн санал, санаачилга гаргаж байлаа. Тухайлбал, 1922 онд хуралдсан бошгыг халах залуучуудын анх дугаар их хурал эмэгтэйчүүдэд тэгш

<sup>3</sup> НҮБ-ын ЭХС, 2000

<sup>4</sup> Монгол Улсын Үндсэн хууль. Баримт бичиг. УБ, 2004, 43 дах тал

эрх олгох тухай асуудлыг хэлэлцэж байсан ба залуу эмэгтэйчүүдийг нам, эвлэлд элсүүлэх, тэднийг хувьсгалын үйл ажиллагаанд оролцуулахад туслах, эмэгтэйчүүдийн байгууллага байгуулах шаардлагын тухай ярилцаж байжээ.

МАХН-ын Төв Хорооны Тэргүүлэгчдийн 1924 оны 3 дугаар сарын 8-ны хурлаас монголын эмэгтэйчүүдийн байгууллагыг байгуулах тухай түүхт шийдвэр гаргаж, түүний дүрмийг боловсруулан гаргахыг МАХН-ын Төв Хорооны Суртлын хэлтэст даалгасан байна. Тэрхүү шийдвэрийн дагуу эмэгтэйчүүдийн байгууллагыг анх Монгол Улсын 14 дүгээр оны 2 дугаар сарын 13 буюу 1924 оны 3 дугаар сарын 19-нд “Бүсгүйчүүдийг боловсруулах тасаг” нэртэйгээр байгуулсан нь төрийн өмнө эмэгтэйчүүдийн хөгжил, нийгмийн оролцоог хариуцах, эхчүүд, охид, бүсгүйчүүдийн дунд олон нийтийн үйл ажиллагаа явуулах эрх үүрэг бүхий Монголын Эмэгтэйчүүдийн Хороо байгуулах суурь болж, эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн тэгш эрх, тэгш байдлыг хангах үндэсний тогтолцооны эхлэл тавигдсан гэж үзэж болох юм.

Монгол Улсын Үндсэн хуульд 1940 онд нэмэлт, өөрчлөлт оруулж, улс орныхоо тусгаар тогтнол, эмэгтэйчүүдийн тэгш эрхийг улам бүр баталгаажуулсан бөгөөд Монгол Улсыг хөгжүүлэх нэг жилийн төлөвлөгөө баталж, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа эхэлсэн түүхт он байлаа. Энэ үед Монголын эмэгтэйчүүдийн байгууллага Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтийг эмэгтэйчүүдэд таниулах, нэг жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн идэвхийг өрнүүлэхэд чиглэсэн шинэ ажлыг зохион байгуулж байжээ.

МАХН-ын Улс Төрийн Товчооны 1961 оны 159 дүгээр тогтоолоор МАХН-ын Төв Хороонд байсан Эмэгтэйчүүдийн тасгийг Монголын эмэгтэйчүүдийн хороо гэж нэрлэх болов. Энэхүү тогтоолоор аймаг, хотын эмэгтэйчүүдийн зөвлөлөөр дамжуулан тэдний дунд соёл боловсрол, олон нийтийн ажил зохион байгуулахыг хариуцуулав. Энэ үеэс эмэгтэйчүүдийн нийгмийн байдал эрс өөрчлөгдөж, бараг бүх эмэгтэй бичиг үсэгтэй болсон төдийгүй төрөл бүрийн мэргэжилтэй эмэгтэйчүүдийн тоо нэмэгдсээр байлаа. Эрдмийн зэрэг цолтой эмэгтэйчүүд төрөн гарснаар эмэгтэйчүүдийн дунд соёл хүмүүжил, улс төрийн ажил явуулах боломж өргөжсөн байна.

Төрөөс 1960-1989 онд эмэгтэйчүүдийн ажил эрхлэлт, боловсрол, бичиг үсэг тайлагдалт зэрэгт онцгойлон анхаарснаар хүйсийн ялгаа мэдэгдэхүйцээр багасчээ.

## 1990 ОНООС ХОЙШИХ ҮЕ

Эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулахад манай улс 1990 оноос хуулийн шинэ орчинг бүрдүүлсэн юм. 1992 онд баталсан Монгол Улсын Үндсэн хуульд манай улсын эрэгтэй, эмэгтэй бүх иргэн улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэйг баталгаажуулжээ. Түүнчлэн, ялгаварлан гадуурхахгүй байх, тахир дутуу иргэд, өндөр настанг асрах, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах, сурч боловсрох эрхийг нь хуульчилсан юм.

Төрийн байгууллага, холбогдох яамд 1992-1995 онд эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах асуудал болон “Эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах Үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлыг хариуцан ажиллаж байв.

Жендерийн тэгш байдлын асуудал хариуцах Үндэсний зөвлөлийг 2000 онд байгуулж, 2005 он хүртэл “Жендерийн тэгш байдлыг хангах Үндэсний хөтөлбөр” хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байв. Тус зөвлөл 2005 оноос Жендерийн тэгш байдлын Үндэсний Хороо болон өргөжиж, жендерийн эрх тэгш байдлыг хангах бодлого хэрэгжүүлэхэд төр, олон нийтийн тэнцүү оролцоог хангах, “Жендерийн тэгш байдлыг хангах Үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлыг зохицуулах, хяналт-үнэлгээ хийх үйл ажиллагааг хариуцан ажиллаж байна.

## СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Дэлхийн улс орны удирдагчид, төрийн тэргүүн нар НҮБ-ын Ерөнхий Ассамблей 2000 онд болсон тусгай чуулганд 2000 онд оролцохдоо хүн төрөлхтний өмнө тулгамдаж буй олон асуудлыг хэлэлцэн “Мянганы тунхаглал”-ыг батлан гаргасан. Энэхүү тунхаглалаар аль ч улс орны төрөөс ард иргэдийнхээ ая тухтай, аюулгүй, сайн сайхан амьдралын баталгааг хангахад хамгийн чухал суурь асуудал бол эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломжийг хангах, гэр бүл, нийгмийн харилцаанд тэдний эрхийг дээдэлж баталгаажуулах явдал хэмээн үзсэн юм.

Монгол Улсын төрөөс ч энэхүү “Мянганы тунхаглал”-ын зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор өөрийн орны онцлог байдлыг харгалзан улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд жендерийн тэгш байдлыг хангах эрх зүйн суурь нөхцөл бололцоог бүрдүүлэхэд ихээхэн анхаарч, Монгол Улсын Их Хурлаас “Мянганы хөгжлийн зорилт”-ыг хэлэлцэн баталж, түүнд суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын баримт бичгийг батлан хэрэгжүүлж байна.

Сүүлчийн жилүүдэд манай улсад эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ажил хөдөлмөр эрхлэх, боловсролын үйлчилгээнд хамрагдах бодит байдалд тэгш бус хандлага ажиглагдаж буйг анхаарахгүй өнгөрч болохгүй. Энэ нөхцөл байдлаас улбаалж гэр бүлийн амьдрал, нийгэм, эдийн засаг, улс төрийн харилцаанд сөрөг нөлөө үзүүлэх, эрх нь зөрчигдөх явдал гарч байгааг анхаарах шаардлагатай юм. Иймээс “Жендерийн тэгш байдлыг хангах Үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхэд хяналт, үнэлгээ хийх, шаардлагатай мэдээллийг шинэчлэх, баяжуулах, түүнд үндэслэн хүйсийн нарийвчилсан судалгаа хийх шаардлага гарч байна.

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын үр дүнд үндэслэн хүн амын нас, хүйсийн бүтэц, өрх гэр бүл, боловсрол, ажил эрхлэлт дэх хүйсийн ялгаатай байдлыг илрүүлж, түүнд тулгуурлан зарим дүгнэлт, бодлогын чанартай санал дэвшүүлэхэд судалгааны гол зорилго оршино.

## ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Энэхүү сэдэвчилсэн судалгааг хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын үр дүнд үндэслэн хийсэн учир үндсэн ойлголт, тодорхойлолт, хэмжигдэхүүнийг тооллогод ашигласнаар авсан. Мөн 2000 оны тооллогын мэдээлэлтэй харьцуулах байдлыг ч харгалзан үзсэн болно.

№	Ойлголт	Тодорхойлолт
<b>ӨРХ</b>		
1.	Өрх	Нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын хэрэгцээгээ хамтран хангадаг хэсэг бүлэг хүмүүс
2.	Ам бүлээрээ байгаа өрх	Өрх дангаараа амьдрах буюу эхнэр, нөхөр, хүүхдийн хамт, эцэг эсвэл эх нь хүүхдийн хамт өрх үүсгэн амьдрах
3.	Нийлмэл ам бүлтэй өрх	Нийлмэл өрхөд дараах бүтэцтэй өрх хамрагдана. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>· Нэг ам бүл бусад хамаатан садантайгаа хамт амьдрах;</li> <li>· Хоёр, түүнээс дээш хоорондоо хамааралтай ам бүл дангаараа амьдрах;</li> <li>· Хоёр, түүнээс дээш хоорондоо хамааралтай ам бүл, аль нэгэнтэй нь хамааралтай хүнтэй хамт амьдрах;</li> <li>· Хоёр, түүнээс дээш хоорондоо хамааралтай боловч нэг ам бүлийн биш хүмүүс хамт амьдрах;</li> </ul>
4.	Холимог ам бүлтэй өрх	Холимог өрхөд дараах бүтэцтэй өрх хамрагдана. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>· Нэг ам бүл бусад хамаатан садан эсвэл хамааралгүй хүнтэй хамт амьдрах;</li> <li>· Нэг ам бүл, хамааралгүй хүнтэй хамт амьдрах;</li> <li>· Хоёр, түүнээс дээш хоорондоо хамааралтай ам бүл, аль нэгнийх нь хамаатан садан, хамааралгүй хүнтэй хамт амьдрах;</li> <li>· Хоёр, түүнээс дээш хоорондоо хамааралтай ам бүл эдгээр ам бүлийн алинд ч хамааралгүй хүнтэй хамт амьдрах;</li> <li>· Хоёр, түүнээс дээш хоорондоо хамааралгүй ам бүл бусад хүнтэй эсвэл хүнгүйгээр амьдрах;</li> <li>· Хоорондоо хамааралтай боловч ам бүлийн биш хоёр, түүнээс олон хүн бусад хамааралгүй хүнтэй амьдрах;</li> <li>· Хоорондоо хамааралгүй хүмүүс өрх үүсгэн амьдарч байгаа өрх орно.</li> </ul>
5.	Өрхийн тэргүүлэгч	Арван зургаагаас дээш настай, ажил хөдөлмөр эрхэлдэг, өрхийн орлогод голлох хувь нэмэр оруулдаг, өрхийн аливаа асуудлыг шийдвэрлэхэд голлох үүрэгтэй оролцдог ам бүлийн аль нэг гишүүн
6.	Эрэгтэй, эмэгтэй тэргүүлэгчтэй өрх	Өрхийн тэргүүлэгч эрэгтэй, эсхүл эмэгтэй байхаас хамаарсан ойлголт
7.	Өрх толгойлсон эцэг, эх	Гэрлэлтээ цуцлуулсан, эхнэр, нөхрийн хэн нэг нь нас барсан, эсхүл сураггүй алга болсон нь шүүхээр тогтоогдсон, эцэг, эх байх эрхээ хасуулсан, гэрлэж байгаагүй боловч төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхэдтэй ганц бие эцэг, эх


№	Ойлголт	Тодорхойлолт
<b>ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ</b>		
8.	Огт гэрлээгүй	Огт гэрлэж байгаагүй хүн
9.	Батлуулсан	Гэрлэлтээ иргэний гэр бүлийн байгууллагад бүртгүүлсэн, гэрлэлтийн баталгаатай хүн
10.	Батлуулаагүй	Гэр бүл болж хамтран амьдарч байгаа боловч (хугацаа харгалзахгүйгээр) иргэний гэр бүлийн байгууллагад бүртгүүлж, гэрлэлтээ албан ёсоор батлуулаагүй хүн
11.	Цуцалсан	Гэр бүлээ хуулийн дагуу цуцалснаас хойших хугацааг харгалзахгүйгээр дахин гэрлээгүй хүн
12.	Тусгаарласан	Гэр бүлээ албан ёсоор цуцлуулаагүй боловч тусдаа амьдарч байгаа, дахин гэрлэж хамт амьдраагүй хүн
13.	Бэлбэсэн	Эхнэр, нөхрийн аль нэг нь нас барснаас хойших хугацааг харгалзахгүйгээр дахин гэрлэж, хамт амьдраагүй хүн
<b>БОЛОВСРОЛ</b>		
14.	Боловсролгүй	ЕБС-ийн 3 дугаар ангийг 1975-1996 онд, 4 дүгээр ангийг 1975 он хүртэл, 1997-2004 онд, 5 дугаар ангийг 2005 оноос хойших хугацаанд суралцаж төгсөөгүй хүн. Мөн 2010 онд ЕБС-ийн 1-5 дугаар ангид суралцагч, сурч байгаад сургуулиа орхисон хүн
15.	Бага боловсрол	ЕБС-ийн 3 дугаар ангийг 1975-1996 онд, 4 дүгээр ангийг 1975 он хүртэл, 1997-2004 онд, 5 дугаар ангийг 2005 оноос хойших хугацаанд суралцаж төгссөн хүн. Мөн албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж төгссөн хүн
16.	Бүрэн бус дунд боловсрол	ЕБС-ийн 7 дугаар ангийг 1975 он хүртэл, 8 дугаар ангийг 1975-2004 онд, 9 дүгээр ангийг 2005, түүнээс хойших онд өдөр, орой, эчнээгээр суралцаж төгссөн, суурь боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж төгссөн хүн
17.	Бүрэн дунд боловсрол	ЕБС-ийн 10 дугаар ангийг 2007 он хүртэл, 11 дүгээр ангийг 2006, түүнээс хойших онд өдөр, орой, эчнээгээр суралцаж төгссөн, бүрэн дунд боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж төгссөн хүн
18.	Техникийн болон мэргэжлийн боловсрол	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв (Техник мэргэжлийн сургууль-ТМС) төгссөн хүн
19.	Тусгай мэргэжлийн дунд боловсрол	Гадаад, дотоодын тусгай мэргэжлийн дунд сургууль (хуучнаар техникум) түүнтэй адилтгах сургууль төгссөн хүн
20.	Дээд боловсрол (бакалавр, магистр, доктор, түүнээс дээш)	Гадаад, дотоодын их, дээд сургууль, коллежийг өдөр, орой, эчнээгээр төгссөн, дипломын дээд, бакалавр, магистр, докторын зэргийн диплом болон түүнтэй адилтгах боловсролын баримт бичиг бүхий хүн. Улсын багшийн их сургуулийг 1964 оноос өмнө 3 жилээр, Намын дээд сургуулийг 1966 оноос өмнө, Намын дээд сургуулийн дэргэдэх 2 жилийн курс, Марксизм-Ленинизмын оройн дээд сургууль, Дорно дахины хөдөлмөрчдийн их сургууль (КУТВ) төгссөн хүн

№	Ойлголт	Тодорхойлолт
21.	Бичиг үсэг мэддэг хүн	Аль нэг хэлээр (бичгийн төрөл, хэлбэрээс үл хамааран) өдөр тутмын амьдралын тухай хамгийн энгийн богино өгүүлбэрийг уншиж, ойлгож, бичиж чаддаг, энэ чадвар нь тодорхой хугацаа өнгөрсөн ч хэвээр хадгалагдаж үлдсэн хүн
22.	Сургуульд суралцагч	Ямар нэг түвшний боловсрол олгох сургуулийн өдөр, орой, эчнээ ангид тоолох үед суралцаж байгаа 15-24 насны хүн
<b>ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХ</b>		
23.	Ажил эрхэлдэг хүн	Тооллогын товын үед тогтмол ажил эрхэлж байгаа, эсхүл тогтмол ажил эрхэлдэггүй боловч товын өмнөх 7 хоногт ядаж нэг цаг цалинтай ажил эрхэлсэн хүн
24.	Ажилгүй хүн	Хөдөлмөр, халамж, үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй болон бүртгэлгүй, товын өмнөх 7 хоногт ажил эрхлээгүй, ажил идэвхтэй хайж байгаа хүн
<b>ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН</b>		
25.	Шилжих хөдөлгөөн	6, түүнээс сарын хугацаагаар байнга оршин суугаа аймаг, нийслэлээсээ өөр аймаг, нийслэлд шилжин суурьших хөдөлгөөн
26.	5 жилийн шилжих хөдөлгөөн	2005 оны 1 дүгээр сарын 1-нээс хойших хугацааны шилжих хөдөлгөөн
27.	1 жилийн шилжих хөдөлгөөн	2010 оны 1 дүгээр сараас хойших хугацааны шилжих хөдөлгөөн
<b>ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ</b>		
28.	Хөгжлийн бэрхшээлтэй хүн	Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогийн улмаас бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь бүрэн болон 12 сараас дээш хугацаагаар хязгаарлагдсан хүн
<b>ОРОН СУУЦ</b>		
29.	Гэр	Монголын ард түмний уламжлалт сууц болох бүх төрлийн гэр, цаатны урц
30.	Байшин	Нэг, түүнээс дээш өрөө, дээвэртэй, гадуураа ханатай, сууриас дээвэр хүртэл ханаар хуваагдсан талбай бүхий орон байр
31.	Зориулалтын бус	Анхнаасаа хүн амьдрах зориулалтаар бариагүй боловч хүн амьдрахад зориулан өөрчлөн засч тохижуулсан, тоолох үед хүн амьдарч байгаа сууц
32.	Бусад	Тоолох үед хүн амьдарч байгаа, байнгын бус, түр орогнох байр



# ХОЁРДУГААР БҮЛЭГ

ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТ



## ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТ

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогоор тус улсын нутаг дэвсгэрт оршин сууж байсан хүмүүсээс гадна гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар суугаа Монгол Улсын иргэдээ тоолсон нь тэдний нас, хүйсийн бүтэц болон бусад нийгэм, эдийн засгийн нэн чухал мэдээллийг гарган авах бололцоо олгосноороо өмнөх тооллогоос ихээхэн онцлог болсон билээ. Нас, хүйс гэсэн үзүүлэлтийг төрсөн огноо, тооллогын товтой харьцуулсан бүтэн нас, эрэгтэй, эмэгтэй гэсэн үндсэн хоёр ангилалд багтах хүйсийн уламжлалт ойлголтоор тодорхойлон авч үзсэн юм.

ЗУРАГ 2.1. ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2010 ОНЫ УЛСЫН ТООЛЛОГООР НАС, ХҮЙСИЙГ ТОДОРХОЙЛСОН ҮЗҮҮЛЭЛТ

<b>2. ХҮЙС.</b>	
Эрэгтэй.....	1
Эмэгтэй .....	2
<b>3. ТА ТӨРСӨН ОН, САР, ӨДРӨӨ ХЭЛНЭ ҮҮ?</b>	
Он: .....	<input type="text"/> <input type="text"/> <input type="text"/> <input type="text"/>
Сар: .....	<input type="text"/> <input type="text"/>
Өдөр: .....	<input type="text"/> <input type="text"/>
<b>4. ТА ХЭДЭН НАСТАЙ ВЭ?</b> (бүтэн насаар)	
	<input type="text"/> <input type="text"/> <input type="text"/>

Хүн амын насны бүтцийг хүйсийн ялгаатайгаар судлах нь тухайн улсын хүн ам зүйн түүхэн замналыг тольдох, одоогийн үйл явцыг үнэлж дүгнэх, цаашдын чиг хандлагыг тодорхойлох бололцоо олгодгоороо ихээхэн ач холбогдолтой юм. Энэ нь хүйсийн биологийн ялгааг харуулаад зогсохгүй эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нийгмийн үүрэг хариуцлагын ялгаатай байдлыг ерөнхийд нь дүгнэх бололцоо өгдөг. Тухайлбал, хүн амын насны бүтэц идэрших хандлагатай болохыг (нийт хүн амд хөдөлмөрийн болон түүнээс дээш насныхны эзлэх хувийн нэмэгдэх үйл явц) хүйсээр ангилж үзэхэд цаашид хөдөлмөрийн насны эрэгтэй, эмэгтэй хүний

онцлогийг харгалзан ямар төрлийн ажлын байрыг нэмэгдүүлэх, тэтгэврийн насанд эмэгтэй хүн ам дийлэнх байгаад нийгмийн хамгааллын ямар үйлчилгээ бий болгох, сайжруулах, тэтгэврийн тогтолцоог хэрхэн шинэчлэх вэ зэрэг олон асуудлын учир шалтгааныг илүү тодорхой болгодог юм.

Монгол Улсын хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын дүнгээр суурин хүн амын тоо 2754.7 мянга гарсны 49.5 хувь нь эрэгтэй, 50.5 хувь нь эмэгтэйчүүд байна. Хүн ам өмнөх тооллогын үеэс 16.1 хувиар өссөн бол эрэгтэй хүн ам 15.8, эмэгтэй хүн ам 16.3 хувиар нэмэгджээ. Хүн амын өсөлтийн хувийг хүйсээр нь ангилж үзвэл 1979-1969, 1963-1944 онд эрэгтэй хүн амын өсөлтийн хувь эмэгтэйчүүдийнхээс их байсан бол бусад онд эмэгтэй хүн амын өсөлт илүү байжээ. Энэ нь төрөх үеийн хүйсийн харьцаа (төрсөн 100 эмэгтэйд ногдох эрэгтэй)-наас гадна эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нас баралт, түүний шалтгаанаас ихээхэн хамаарах бөгөөд сүүлчийн 3 тооллогын хугацаанд эмэгтэйчүүдийн өсөлт давамгайлсан нь тэдний дундаж наслалт эрэгтэйчүүдийнхээс илүү байгаагаар нотлогдох үндэслэлтэй юм. Харин гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа Монгол Улсын иргэдийн хүйсийн харьцаа 87.4 байгаа нь гадаадад эмэгтэйчүүд илүү олноороо шилжин явсныг харуулна. Үүнийг явсан зорилгоор нь ангилж үзэхэд суралцах, хувиараа ажиллах болон бусад зорилгын тухайд эмэгтэйчүүд дийлэнх байхад хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар эрэгтэйчүүд илүү олноороо явжээ.

ХҮСНЭГТ 2.1. ХҮН АМЫН БОЛОН ТӨРСӨН, НАС БАРСАН ХҮНИЙ ТОО, ХҮЙСЭЭР, ТООЛЛОГЫН ОНУУДААР

Он	Хүн амын тоо /мян.хүн/			Хүйсийн харьцаа <sup>4</sup>	Төрсөн хүүхдийн тоо			Төрөх үеийн хүйсийн харьцаа	Нас барсан хүний тоо			Нас барах үеийн хүйсийн харьцаа
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй		Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй		Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	
Нийт <sup>1</sup>	2754.7	1363.9	1390.8	98.1								
2010												
Дотоод <sup>2</sup>	2647.5	1314.0	1333.6	98.5	63 270	32 299	30 971	104.3	18 293	10 781	7 512	143.5
Гадаад <sup>3</sup>	107.1	50.0	57.2	87.4								
2000	2373.5	1178.0	1195.5	98.5	48 721	24 832	23 889	103.9	15 472	8 683	6 789	127.9
1989	2044.0	1020.7	1023.3	99.7	73 593	37 591	36 002	104.4	17 000	9 421	7 579	124.3
1979	1594.4	798.3	796.1	100.3	60 233	30 826	29 407	104.8	15 375	8 333	7 042	118.3
1969	1188.3	592.3	596.0	99.4	46 849	23 753	23 096	102.8	13 905	7 342	6 563	111.9
1963	1017.2	508.0	509.1	99.8	40 250	19 813	20 437	96.9	12 168	6 218	5 950	104.5
1956	845.5	420.3	425.2	98.8	26 825	13 807	13 018	106.1	10 573	5 224	5 349	97.7
1944	759.1	371.3	387.8	95.7	-	-	-	-	-	-	-	-
1935	738.2	370.8	367.4	100.9	13 700	7 037	6 663	105.6	12 083	6 006	6 077	98.8
1918	647.5	330.2	317.3	104.1	-	-	-	-	-	-	-	-

Эх үүсвэр:

ҮСХ, "Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллого: Нэгдсэн дүн", 2011 он

ҮСХ, "Монгол Улсын статистикийн эмхтгэл 2010", 2011 он

ҮСГ, "Монгол Улсын хүн ам хорьдугаар зуунд", 2003 он

<sup>1</sup> Монгол Улсын нийт хүн амын тоо

<sup>2</sup> Монгол Улсын нутаг дэвсгэрт тоологдсон суурин хүн амын тоо

<sup>3</sup> Гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа Монгол Улсын иргэдийн тоо


<sup>4</sup> Зуун эмэгтэйд ногдох эрэгтэй хүн ам

Төрөх үеийн хүйсийн харьцаа тооллого явагдсан хугацаанд 102.8-106.1-ийн хооронд (1963 оныг харгалзахгүйгээр) хэлбэлзэж байгаа нь олон улсын жишгээр 100 охин төрөхөд 104-106 хөвгүүн төрж, нас ахих тутам эмэгтэйчүүд давамгайлж, хүйсийн харьцаа буурдаг зүй тогтол манайд ч байгааг харуулна. Энэ нь Хятад, Энэтхэг зэрэг хүйсээс хамаарсан үр хөндөх зан үйл түгээмэл оронтой харьцуулахад манай улсад ийм хандлага одоогоор ажиглагдаагүйг илэрхийлнэ.

Нас барах үеийн хүйсийн харьцаа тооллого явуулсан онуудад тогтвортой өсч, 2010 оны байдлаар 100 эмэгтэйд 143 эрэгтэй ногдох болжээ. Хүн амын 1956 оны тооллогоос өмнө энэ харьцаанд эмэгтэйчүүд давамгайлж байсан нь тухайн үед эрүүл мэндийн тогтолцоо бүрэлдэн бий болоогүйтэй холбоотойгоор халдварт өвчин, эх барих, жирэмслэх, төрөхтэй холбоотой эндэгдэл их байсантай холбоотой болов уу. Харин 1963 оноос эхлэн эрэгтэйчүүдийн нас баралт нэмэгдэж, хүйсийн харьцаа 2010 онд 2000 оны тооллогын түвшнээс 15.6 пунктээр өсчээ. Ялангуяа, 2000-2010 оны тооллого хоорондын өсөлтийн хурд 1989-2000 оныхоос 4 илүү дахин нэмэгдсэн нь ихээхэн анхаарал татаж байна. Сүүлчийн жилүүдэд тамхи татах, архидах зэрэг амьдралын буруу зан үйлээс шалтгаалан эрэгтэйчүүд хөдөлмөрийн чадвараа алдах, нас барах явдал түгээмэл болсныг дээрх үр дүн тодорхой харуулж байна.


Хүн амын хүйсийн харьцаа өнгөрсөн тооллогын үеийнхтэй адил буюу 98.5 хувь байна. Хэдийгээр нийт дүнгээр нь авч үзэхэд ялгаагүй ч насны бүлгээр ангилахад 50 наснаас хойш эрэгтэйчүүдийн тоо эрс буурчээ (зураг 2.1). Тодруулбал, 60-64 насанд тооллого хоорондын хүйсийн харьцааны зөрүү 15.7 пункт буюу хамгийн их байна. Сүүлчийн 11 жил орчмын хугацаанд эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн байдал доройтож, нас баралт нэмэгдсэний шалтгааныг нарийвчлан судлах шаардлагатай дээр 2000 онд эрэгтэй, эмэгтэйчүүдийн төрөлтөөс тооцсон дундаж наслалтын ялгаа 5.7 жил байснаа 2010 онд 1.6 пунктээр нэмэгдэж, 7.3 жил болсныг анхаарах нь зүйтэй.

ЗУРАГ 2.2. ХҮН АМЫН ХҮЙСИЙН ХАРЬЦАА, 2000, 2010 ОН



Нас, хүйсийн суварга нь хүн амын насны бүтэц, цаашдын чиг хандлагыг илэрхийлэх хамгийн тодорхой, ойлгомжтой дүрслэл юм. Сүүлчийн 3-4 жилийн хугацаанд төрөлт нэмэгдсэнийг суваргын суурь хэсэг илүү цүлхийсэн хэлбэртэй болсноос харж болно. Хүн амын насны бүтэц ерөнхийдөө идэрших хандлагатай болсноос гадна хүн амыг насны хувьд таллан хуваадаг үзүүлэлт болох голч нас 2010 онд 25.7 болж, 2000 оны түвшнээс 4.1 пунктээр нэмэгджээ. Эрэгтэй, эмэгтэй хүний голч насны зөрүү тооллогоос тооллогын хооронд аажмаар ихэсч, 2010 онд 1.1 жил болов (хүснэгт 2.2).

ЗУРАГ 2.3. ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2000, 2010 ОН




Хүн амын насны бүлгүүдийн хувийн жин тухайлбал, 0-14 насны хүүхдийн хувь ерөнхий дүнгээрээ 7.8 пунктээр буурсан байхад хөдөлмөрийн насныхан ойролцоо хэмжээгээр нэмэгджээ. Харин ахмад настны хувийн жин хоёр тооллогын хооронд 0.4 пунктээр буурав. Энэ байдлаас хамаараад хүн ам зүйн ачаалал (хөдөлмөрийн насны 100 хүн амд ногдох хүүхэд, ахмад настны тоо) өмнөх тооллогын үеийнхээс 17.8 пунктээр буурсан нь нэн таатай дүн юм. Ерөнхийдөө эдгээр үзүүлэлтийг хүйсээр нь ангилахад онцын ялгаа ажиглагдахгүй байна. Харин 100 хүүхдэд ногдох ахмад настны харьцаа буюу хөгшрөлтийн индекс ахмад настны насны доод хязгаарыг 60, 65-аар зааглан тооцоолоход тус тус 5.7, 4.1 пунктээр өсчээ. Энэ үзүүлэлтийг хүйсээр авч үзэхэд ялгаа нь улам нэмэгдсэн бөгөөд тус өсөлтөд 0-14 насны хүүхдийн хувийн жин буурсан явдал голлон нөлөөлжээ.

ХҮСНЭГТ 2.2. ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН БҮТЦИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, 2000, 2010 ОН

Үзүүлэлтүүд	2010			2000			Өөрчлөлт		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
<b>Хүн амын хувийн жин</b>									
0-14	28.0	28.7	27.4	35.8	36.3	35.2	-7.8	-7.7	-7.9
15-64	68.1	68.1	68.2	60.8	60.8	60.8	7.4	7.3	7.4
65+	3.8	3.3	4.4	3.5	2.9	4.0	0.4	0.3	0.4
Нийт	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	-	-	-
<b>Хүн ам зүйн ачаалал</b>									
0-14	41.1	42.1	40.1	58.9	59.8	57.9	-17.8	-17.7	-17.8
65+	5.6	4.8	6.5	5.7	4.8	6.6	0.0	0.0	-0.1
Нийт	46.7	46.9	46.6	64.6	64.6	64.5	-17.8	-17.7	-17.9
<b>Голч нас</b>	<b>25.7</b>	<b>25.1</b>	<b>26.2</b>	<b>21.6</b>	<b>21.2</b>	<b>22.0</b>	<b>4.1</b>	<b>3.9</b>	<b>4.2</b>
<b>Хөгшрөлтийн индекс</b>									
60+	20.4	17.2	23.7	14.6	12.8	16.5	5.7	4.4	7.2
65+	13.7	11.3	16.2	9.7	8.0	11.4	4.1	3.3	4.8

Хүн амын насны бүтцийг хүйсийн ялгаатай байдлаар харуулах дараагийн дүрслэл бол “жендерийн спираль (gender spiral)” бөгөөд насны бүлэг дэх эрэгтэй, эмэгтэй хүний тооны зөрүүгээр илэрхийлэгддэг. 2000 оны тооллогоор эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйчүүдээс 17.5 мянгаар илүү байсан бол уг үзүүлэлт 2010 онд 19.6 мянга болж, 11.9 хувиар нэмэгдэв. 2000 онд 25-аас дээш насанд эмэгтэйчүүд давамгайлж байснаа 2010 онд 10 насаар ухарч, 35 боллоо.

ЗУРАГ 2.4. ЭРЭГТЭЙ, ЭМЭГТЭЙ ХҮНИЙ ТООНЫ ЗӨРҮҮ, НАСНЫ БҮЛГЭЭР, 2000, 2010 ОН




Ерөнхийдөө бага залуу насанд эрэгтэйчүүд давамгайлж, нас ахих тутам тэдний нас барах магадлал нэмэгддэгтэй холбоотойгоор эмэгтэйчүүд илүү болох хандлага манай улсад ч мөн ажиглагдаж байна. Гэхдээ 2010 онд эмэгтэйчүүдийн давамгайлах нас ухарсныг тэдний гадагш чиглэсэн шилжих хөдөлгөөнтэй холбож үзэх нь зүйтэй юм.

## ХОТ, ХӨДӨӨГИЙН ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТ


Хүн ам, орон сууцны сүүлчийн 2 удаагийн тооллогод хэрэглэсэн хот, хөдөө гэсэн ойлголт өөрчлөгдөөгүй боловч хотод хамаарагдах нутаг дэвсгэрийн бүрэлдэхүүн болох тосгоны хамрах хүрээ 2000 оноос өөрчлөгдсөн юм. Монгол Улс 2000 оны тооллогод тухайн үеийн Дэд бүтцийн яамны тодорхойлолтоор 29 тосгонтой байсан бол 2010 онд ЗТБХБЯ-ны тодорхойлолтоор 17 тосгонтой болсон. Тиймээс хот, хөдөөгийн хүн амын бүрэлдэхүүний зөрүүтэй байдал тодорхой хэмжээгээр нөлөөлснийг анхаарах нь зүйтэй.

ЗУРАГ 2.5. ХОТ, ХӨДӨӨГИЙН ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2000, 2010 ОН




Суваргаас харахад хотын хүн ам өсч, хөдөөгийн хүн ам буурав. 2010 оны аль ч суваргын хувьд суурь өргөссөн нь сүүлчийн 3-4 жилд төрөлт нэмэгдсэнийг харуулна. 2000 онд хотын хүн амын төрөлт хөдөөгийнхөөс нэлээд бага байжээ. Дараагийн онцлог зүйл бол хөдөөгийн 15-24 насны эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээсээ бага байх хандлага 2010 онд улам нэмэгдэж, энэ насны эмэгтэйчүүдийн тоо илүү ихээр багассан үйл явц юм. Энэ нь эмэгтэйчүүд сургуульд суралцахаар бүсийн төвүүд болон томоохон хот, нийслэлд ирж, суралцаж буй газраа тоолуулсантай холбоотой.

ЗУРАГ 2.6. ХОТ, ХӨДӨӨГИЙН ХҮН АМЫН ХҮЙСИЙН ХАРЬЦАА, 2000, 2010 ОН



Хотын хүн амын хүйсийн харьцаа 2010 онд 94.4 болж, 2000 оны түвшнээс 1.2 пунктээр буурсан бол хөдөөгийнх 108 болж, өмнөх тооллогын үеийнхээс 5.4 пунктээр нэмэгдэв. Энэ нь хот, хөдөөгийн хүн амын хүйсийн ялгаа улам бүр нэмэгдсэнийг харуулна. Ялангуяа, хөдөөгийн 20-49 насны эрэгтэйчүүд 2000 оноос хойш ихээхэн өсчээ.

ЗУРАГ 2.7. ХОТ, ХӨДӨӨГИЙН ЭРЭГТЭЙ, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ТООНЫ ЗӨРҮҮ, НАСНЫ БҮЛГЭЭР, 2000, 2010 ОН



Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогоор хотын эрэгтэйчүүдээс эмэгтэйчүүд 21.8 мянгаар илүү байсан нь 2010 оны түвшнээс 1.7 дахин бага үзүүлэлт юм. Харин хөдөөгийн эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 12.8 мянгаар илүү байсан бол 2000-2010 онд 2.5 дахин нэмэгдэж, 32.6 мянга болжээ. Насны бүлгийн хувьд эрэгтэй, эмэгтэйчүүд аль ч насанд илүү нэмэгдсэн нь дээрх зургаас тодорхой харагдана. Хотод 20-24, 40-64 насны эмэгтэйчүүд, хөдөөд 20-49 насны эрэгтэйчүүд өссөн байна. 2000 оны тооллогоор хотод 10-14 насны эмэгтэйчүүд давамгайлж байснаа 2010 онд эрэгтэйчүүд олонх болсон бол хөдөөд 40-49 насанд эрэгтэйчүүд давамгайлж байна.


## АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТ

Аймаг, нийслэлийн хүн амын тоо тооллого хооронд багагүй өөрчлөгджээ. Улаанбаатар хот, Дархан-Уул, Дорноговь, Говьсүмбэр, Өмнөговь, Орхон аймгаас бусад бүх аймгийн хүн ам буурав.

Нас, хүйсийн суваргаас ажиглахад насны болоод хүйсийн бүтэц нь 2000 оны тооллогын үеэс ихээхэн өөрчлөгдсөн зарим аймгийг жагсаавал дараах байдалтай байна (зураг 2.8). Ерөнхийдөө Баян-Өлгий, Ховд аймгаас бусад бүх аймаг, нийслэлийн хүн амын насны бүтэц идэрших хандлагатай болсноос гадна сүүлчийн 3-4 жилд төрөлт нэмэгдсэн нь суваргаас ажиглагдана. Улаанбаатар хотын хүн амын өсөлтөд шилжих хөдөлгөөнөөс гадна ердийн өсөлт багагүй нөлөөлснийг суваргын суурь болон 15-29 насанд огцом цүлхийснээр тайлбарлаж болно. Харин Баян-Өлгий аймгийн хувьд насны залуу бүтэцтэй (2010 оны суваргын сууриас эхлэн жигдхэн нарийссан пирамид хэлбэртэй) байгаа нь төрөлтийн түвшин бусад аймагтай адил өнгөрсөн хорин жилийн хугацаанд эрс хэлбэлзээгүйг гэрчилнэ. Тус аймгийн 1000 хүнд ногдох төрөлт 2000-2010 онд 30.2-21.8<sup>5</sup> болтлоо тогтвортой буурсан байна. Харин Дорноговь, Өмнөговь аймгийн суваргын бүтцэд 20-иос дээш насны эрэгтэйчүүдийн шилжих хөдөлгөөн хэрхэн нөлөөлснийг харж болно. Ялангуяа, Өмнөговь аймгийн төрөлт 2000 оны түвшинд байхад (суваргын 0-4 насны хүн амын тоо 2000, 2010 онд бараг өөрчлөгдсөнгүй) хүн ам өссөн нь шилжих хөдөлгөөний нөлөө ажээ.

<sup>5</sup> ҮСХ, Монгол Улсын статистикийн эмхтгэл, 2000-2010 он

ЗУРАГ 2.8. НИЙСЛЭЛ, ЗАРИМ АЙМГИЙН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2000, 2010 ОН



Хүн амын хүйсийн харьцааг аймаг, нийслэлээр авч үзэхэд 2000 онд 12 аймагт эрэгтэйчүүд давамгайлж байсан бол 2010 онд энэ тоо 15 болж нэмэгдэв (хүснэгт 2.3). Архангай аймагт 2000 онд эрэгтэйчүүд давамгайлж байснаа 2010 онд эмэгтэйчүүд илүү болсон байхад Баянхонгор, Дорнод, Дундговь, Өвөрхангай аймаг 2010 онд эрэгтэйчүүд олонх болсон аймагт оржээ.


ХҮСНЭГТ 2.3. ХҮН АМЫН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХҮЙСЭЭР,  
ХҮЙСИЙН ХАРЬЦАА, 2000-2010 ОН

Аймаг, нийслэл	2010			2000			Хүйсийн харьцаа	
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	2010	2000
<b>БҮГД</b>	<b>2647 545</b>	<b>1313 968</b>	<b>1333 577</b>	<b>2373 493</b>	<b>1177 981</b>	<b>1195 512</b>	<b>98.5</b>	<b>98.5</b>
Архангай	84 078	41 943	42 135	97 091	48 579	48 512	99.5	100.1
Баян-Өлгий	85 232	42 655	42 577	91 068	45 813	45 255	100.2	101.2
Баянхонгор	75 690	38 023	37 667	84 779	42 037	42 742	100.9	98.4
Булган	53 065	27 325	25 740	61 776	31 153	30 623	106.2	101.7
Говь-Алтай	53 223	26 602	26 621	63 673	31 492	32 181	99.9	97.9
Дорноговь	57 930	29 230	28 700	50 575	25 515	25 060	101.8	101.8
Дорнод	68 873	34 796	34 077	75 373	37 639	37 734	102.1	99.7
Дундговь	38 543	19 578	18 965	51 517	25 719	25 798	103.2	99.7
Завхан	64 924	32 544	32 380	89 999	45 032	44 967	100.5	100.1
Өвөрхангай	100 444	50 333	50 111	111 420	55 578	55 842	100.4	99.5
Өмнөговь	60 855	34 884	25 971	46 858	23 488	23 370	134.3	100.5
Сүхбаатар	51 091	26 059	25 032	56 166	28 585	27 581	104.1	103.6
Сэлэнгэ	95 804	48 756	47 048	99 950	51 068	48 882	103.6	104.5
Төв	83 838	43 751	40 087	99 268	51 374	47 894	109.1	107.3
Увс	72 906	36 829	36 077	90 037	45 512	44 525	102.1	102.2
Ховд	76 252	38 006	38 246	86 831	43 213	43 618	99.4	99.1
Хөвсгөл	114 331	56 899	57 432	119 063	59 060	60 003	99.1	98.4
Хэнтий	65 335	33 399	31 936	70 946	35 651	35 295	104.6	101.0
Дархан-Уул	90 642	44 556	46 086	83 271	40 844	42 427	96.7	96.3
Улаанбаатар	1154 290	558 247	596 043	760 077	369 146	390 931	93.7	94.4
Орхон	87 118	42 813	44 305	71 525	35 320	36 205	96.6	97.6
Говьсүмбэр	13 081	6 740	6 341	12 230	6 163	6 067	106.3	101.6

Энэ удаагийн тооллогод гарсан онцлог нь уул уурхайн олборлолт, үйлдвэрлэл эрчимтэй явагдаж байгаагаас хамаарч, Өмнөговь аймгийн 100 эмэгтэйд 34 эрэгтэй илүү ногдох болж, өмнөх тооллогын дүнгээс 33 пунктээр нэмэгдсэн явдал юм. Тиймээс энэ байдлыг анхаарч, тэнд шилжин очиж байгаа эрэгтэйчүүдийн шинж байдлыг судалж, холбогдох арга хэмжээ авах шаардлагатай. Төв аймаг 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо 9 хүнээр илүү байгаа бол Булган, Говьсүмбэр аймагт 6, харин Улаанбаатар хот, Орхон аймагт дээрх харьцаа 6 эмэгтэйгээр илүү байна. Баянхонгор, Булган, Дорнод, Дундговь, Өмнөговь, Говьсүмбэр аймгийн хувьд 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо 2000 оны түвшнээс 3-4 хүнээр нэмэгдсэн нь онцлог юм.


Жендерийн спираль буюу эрэгтэй, эмэгтэйчүүдийн тооны зөрүүг насны бүлгээр дүрслэн үзүүлсэн мэдээллээс харахад аймаг, нийслэлийн хүн амын талаар тодорхой дүгнэлт өгч болохоор байна. Монгол Улсын хүн амын жендерийн спираль 2010 онд 35 хүртэлх насанд эрэгтэйчүүд, түүнээс дээш насанд эмэгтэйчүүд давамгайлж байсан (Зураг 2.3). Гэтэл Улаанбаатар хотын хувьд 15 наснаас эхлэн эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээсээ олон болж, нийт дүнгээрээ 37.8 мянган эмэгтэй илүү тоологджээ. 30-39 насыг эс тооцвол 15-64 насны эмэгтэйчүүд олон байгаа нь 2000 оны тооллогын үеийнхээс багагүй өөрчлөгдсөнийг харуулна. Ялангуяа, 20-24 насанд хамгийн олон байгаа нь дээд боловсрол олгох үйл ажиллагаа Улаанбаатар хотод үндсэндээ төвлөрч, түүнд суралцагч эмэгтэйчүүд олонх байгаагаас шалтгаалжээ (зураг 2.9). Дараагийн онцлог болоод сүүлчийн 11 орчим жилийн хугацаанд эрч өөрчлөгдсөн аймаг бол Өмнөговь бөгөөд тус аймагт нийт дүнгээрээ 8.9 мянган эрэгтэй эмэгтэйгээсээ илүү байна.

ЗУРАГ 2.9. ЗУУН ЭМЭГТЭЙД НОГДОХ ЭРЭГТЭЙ ХҮН АМЫН ТОО, ЗӨРҮҮГЭЭР, 2000, 2010 ОН



Хөдөлмөрийн болон нөхөн үржихүйн хамгийн идэвхтэй үе болох 20-44 насны эрэгтэйчүүд хамгийн их байна. Уул уурхайн бүтээн байгуулалтыг дагасан хүн ам зүйн энэхүү сөрөг үр дагаврыг цаашид нарийвчлан судалж, тус аймгийн хүн амын хүйсийн харьцааг ердийн түвшинд байлгах бодлого явуулах, зохицуулалт хийх шаардлагатай болжээ.

ЗУРАГ 2.10. ЭРЭГТЭЙ, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ТООНЫ ЗӨРҮҮ, НАСНЫ БҮЛЭГ, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2000, 2010 ОН



Төв аймгийн хувьд жендерийн спиралийн хэв маяг Өмнөговь аймагтай ойролцоо байгаа боловч шалтгаан нь өөр юм. Нэгд, Төв аймгийн жендерийн спиралийн хэв маяг 2 тооллогын хооронд өөрчлөгдсөнгүй. Хоёрт, тус аймаг Улаанбаатар хотод хамгийн ойр орших бөгөөд бусад аймгаас шилжин ирэгчид хот руу шууд шилжихээс гадна Төв аймгаар дамжих байдал тодорхой хэмжээгээр байна. Дээд боловсрол эзэмших насанд эрэгтэйчүүд хамгийн их байгаа нь тэдний сургуульд хамрагдалт бага байгаагаас шалтгаалж байгаа бол бусад насны хувьд шилжих хөдөлгөөнд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү оролцож байгаатай холбоотой байж болох юм.

Эцэст нь тэмдэглэхэд Хөвсгөл аймаг зурагт ороогүй бусад аймгийн жендерийн спиралийн дүр төрхийг үндсэндээ төлөөлж байгаа юм. 30-40 нас хүртэл эрэгтэйчүүд, түүнээс өндөр насанд эмэгтэйчүүд давамгайлж байгаа нь бусад аймгийн хувьд нийтлэг хэв маяг байна. Дээд боловсролын насанд эрэгтэйчүүд дийлэнх байгаагийн шалтгааныг дээр дурьдсан. Харин өндөр насанд эмэгтэйчүүд давамгайлж байгаа нь тэдний эрэгтэйчүүдээс илүү урт насалж байгаатай холбоотой.

## ДҮГНЭЛТ

Хүн амын нас, хүйсийн бүтэц идэрших хандлагатай болов. 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүд буюу хүйсийн харьцаа өмнөх тооллогын түвшинд хадгалагдаж байгаа ч 50 наснаас эхлэн эрс буурсан нь эрэгтэйчүүдийн нас баралт нэмэгдсэнтэй холбоотой. Нас барах үеийн хүйсийн харьцаа сүүлчийн 2 тооллогын хооронд 15.6 пунктээр нэмэгдсэн нь 1956 оны тооллогоос хойших хугацааны хамгийн өндөр өсөлт юм.

Улсын хэмжээнд эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйчүүдээс 19.6 мянгаар илүү байгаа нь өмнөх тооллогын дүнгээс 11.9 хувиар нэмэгджээ. 2000 онд 25-аас дээш насанд эмэгтэйчүүд давамгайлж байснаа 2010 онд 10 насаар ухарч, 35 болов.

Хотын хүн амын хүйсийн харьцаа 2010 онд 94.4 болж, 2000 оны түвшнээс 1.2 пунктээр буурсан бол хөдөөгийнх 108 болж, өмнөх тооллогын үеийнхээс 5.4 пунктээр нэмэгдэв. Насны бүлгээр нь ангилж үзвэл хотод 20-24, 40-64 насанд эмэгтэйчүүд, хөдөөд 20-49 насанд эрэгтэйчүүд илүү ихээр нэмэгджээ.

Хүн амын хүйсийн харьцааг аймаг, нийслэлээр авч үзэхэд 2000 онд 12 аймагт эрэгтэйчүүд давамгайлж байсан бол 2010 онд 15 болж нэмэгдэв. Энэ удаагийн тооллогод гарсан онцлог нь уул уурхайн олборлолт, үйлдвэрлэл эрчимтэй явагдаж байгаагаас хамаарч, Өмнөговь аймгийн 100 эмэгтэйд 34 эрэгтэй илүү ногдох болж, өмнөх тооллогын дүнгээс 33 пунктээр нэмэгдсэн явдал юм. Ялангуяа хөдөлмөрийн болоод нөхөн үржихүйн хамгийн идэвхтэй үе болох 20-44 насны эрэгтэйчүүд тус аймагт хамгийн их байна. Уул уурхайн бүтээн байгуулалтыг дагасан хүн ам зүйн энэхүү сөрөг үр дагаврыг цаашид нарийвчлан судалж, тус аймгийн хүн амын хүйсийн харьцааг ердийн түвшинд байлгах бодлого явуулах, зохицуулалт хийх шаардлагатай болж байна.

# ГУРАВДУГААР БҮЛЭГ

ӨРХ, ГЭР БҮЛ ДЭХ ЖЕНДЕРИЙН ЯЛГААТАЙ БАЙДАЛ



## ӨРХ, ГЭР БҮЛ ДЭХ ЖЕНДЕРИЙН ЯЛГААТАЙ БАЙДАЛ

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогоор “нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын хэрэгцээгээ хамтран хангадаг хэсэг бүлэг хүмүүсийг өрх” гэж үзсэн. Өрх нь гэр бүл бүлээс илүү өргөн хүрээтэй ойлголт юм. Гэр бүлийг эрх зүйн талаас “гэрлэлтийн үр дүнд буй болсон, эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүд”<sup>6</sup> хэмээн тодорхойлж, гэр бүлийн гишүүнд “гэрлэгчид, тэдэнтэй хамт амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд болон төрөл, садангийн хүн”-ийг ойлгоно гэжээ. Амьдрал дээр түгээмэл тохиолддог гэр бүлийн хэлбэр болох эхнэр, нөхөр, үр хүүхэдтэйгээ амьдрах, эсвэл эцэг, эх, хамаатан садангийн хамт 2 үеийн гэр бүл нэг дор амьдрах нь өрх, гэр бүл хэмээх ойлголтуудын адил талыг харуулдаг бол гэр бүлийн гишүүдийн дунд төрлийн болон садангийн хамааралгүй хүн амьдарч байгаа тохиолдлыг авч үздэгээрээ өрх илүү өргөн хүрээтэй ухагдахуун юм.

Өрх, гэр бүлийн түвшинд жендерийн талаас судлах нь өрхийн тэргүүлэгчийн хүйс, нас, хөдөлмөр эрхлэлт, боловсрол эзэмшилт, амьдарч буй сууцны төрөл, нөхцөл цаашлаад гэр бүлийн гишүүдийн нийгэм, эдийн засгийн үзүүлэлттэй уялддаг. Өрхийн тэргүүлэгчийн хүйсээс хамаараад өрхийн сайн сайхан амьдрах орчин, амьжиргааны эх үүсвэр, үр хүүхдийн хүмүүжил, сургуульд хамрагдалт, улмаар бие хүн болж төлөвших явдал зэрэг олон зүйлс ялгаатай байдаг. Тиймээс энэ бүлэгт өрх, гэр бүлийн нийгэм, эдийн засгийн байдлыг өрхийн тэргүүлэгчийн хүйсийн ялгаатайгаар харуулахыг зорив. Мөн өрх толгойлсон эрэгтэй, эмэгтэйчүүд, тэр дундаа эцэг, эхчүүдийн ялгаатай талыг тооллогын мэдээлэлд үндэслэн харуулна.

Өрх, гэр бүлийн тэргүүлэгч нь нөхөр эсвэл эхнэр байхаас хамааруулж эрэгтэй эсвэл эмэгтэй тэргүүлэгчтэй өрх гэсэн ойлголтыг энэхүү судалгаанд хэрэглэсэн бол огт гэр бүл болоогүй эсвэл гэрлэлтээ цуцлуулсан, хамтран амьдрахаа больсон, бэлбэсэрсний улмаас өрх толгойлон амьдарч байгаа хүүхэдтэй эрэгтэй, эмэгтэйчүүдийг өрх толгойлсон эцэг, эх гэж тодорхойлон тэдний талаар тусад нь дэд бүлэг болгон авч үзлээ.

## ӨРХИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮЙСИЙН ЯЛГААТАЙ БАЙДАЛ

Монгол Улсын өрхийн тоо 2010 онд 713.8 мянга болж, 2000 оноос хойш 31.9 хувиар өссөний дотор эрэгтэй тэргүүлэгчтэй өрх 560.2 мянгад хүрч 23.8 хувиар, эмэгтэй тэргүүлэгчтэй өрх 153.6 мянга болж 73.6 хувиар нэмэгдлээ. Өрхийн хэлбэрээр нь авч үзвэл ганц бие өрх хоёр тооллогын хооронд 2.1 дахин, ам бүлээрээ өрх 30.7 хувь, нийлмэл өрх 18.3 хувь, холимог өрх 1.4 хувиар өсөв (өрхийн хэлбэрээр нь ангилсан ойлголт, тодорхойлолтыг хавсралтаас үзнэ үү). Ганц бие эрэгтэй, эмэгтэйчүүд тус тус 2.0, 2.4 дахин өссөн нь эмэгтэй тэргүүлэгчтэй өрх нэмэгдэхэд голлон нөлөөлжээ (хүснэгт 3.1). Ганц бие эрэгтэй, эмэгтэйчүүд нэмэгдсэн нь салалттай холбоотой бөгөөд сүүлчийн 11 орчим жилийн хугацаанд 45-54 насны хосын дунд салалт бараг 4 дахин өссөн байх юм.

<sup>6</sup> Гэр бүлийн тухай хууль, 3.1.2, 3.1.4 дүгээр заалт, [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn)


ХҮСНЭГТ 3.1. ӨРХИЙН ТОО, ӨРХИЙН ХЭЛБЭР, ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХҮЙСЭЭР, ХУВИАР, 2000, 2010 ОН

Үзүүлэлтүүд		Тоо		Хувь		2010 2000
		2000	2010	2000	2010	
Бүгд	Бүгд	541 149	713 780	100.0	100.0	31.9
	Эрэгтэй	452 704	560 224	83.7	78.5	23.8
	Эмэгтэй	88 445	153 556	16.3	21.5	73.6
Ганц бие	Бүгд	35 410	75 917	100.0	100.0	114.4
	Эрэгтэй	21 177	42 278	59.8	55.7	99.6
	Эмэгтэй	14 233	33 639	40.2	44.3	136.3
Ам бүлээрээ	Бүгд	340 590	445 048	100.0	100.0	30.7
	Эрэгтэй	302 713	380 296	88.9	85.5	25.6
	Эмэгтэй	37 877	64 752	11.1	14.5	71.0
Нийлмэл	Бүгд	150 431	177 898	100.0	100.0	18.3
	Эрэгтэй	117 210	127 071	77.9	71.4	8.4
	Эмэгтэй	33 221	50 827	22.1	28.6	53.0
Холимог	Бүгд	14 718	14 917	100.0	100.0	1.4
	Эрэгтэй	11 604	10 579	78.8	70.9	-8.8
	Эмэгтэй	3 114	4 338	21.2	29.1	39.3

Өрхийн бусад хэлбэрийн хувьд эмэгтэй тэргүүлэгчтэй өрх 39.3-71.0 хувиар өссөнөөс харахад өрх, гэр бүлийг эмэгтэйчүүд тэргүүлэх хандлага түгээмэл болсон гэж дүгнэх үндэслэлтэй.


Аймгийн төв, томоохон суурин газар болон нийслэлд нийгэм, соёлын үйлчилгээ хөдөөгийн сумынхтай харьцуулахад илүү байгаатай холбоотойгоор сүүлчийн 11 жилийн хугацаанд хотжих үйл явц эрчимтэй явагдаж, 2000 оны тооллогоор өрхийн 54.8 хувь хотод амьдарч байсан бол 2010 онд энэ хувь 67.2 болов. Хот, хөдөөгийн өрхийн өсөлтийг хэлбэрээр нь авч үзвэл хэв маягийн хувьд өрхийн тэргүүлэгчийн хүйсээрх ялгаа ажиглагдахгүй байна. Өөрөөр хэлбэл, хотод холимог өрхөөс бусад хэлбэрийн өрх ихээр нэмэгдсэн байхад хөдөөд нийлмэл өрх буурчээ.

ЗУРАГ 3.1. ХОТ, ХӨДӨӨГИЙН ӨРХИЙН ӨСӨЛТ, ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХҮЙС, ӨРХИЙН ХЭЛБЭР, ХУВИАР, 2000-2010 ОН



Хотод ганц бие эмэгтэйчүүд 3.2 дахин, эмэгтэй тэргүүлэгчтэй ам бүлээрээ, нийлмэл өрх тус тус 2.2, 1.9 дахин нэмэгдсэн нь эрэгтэй тэргүүлэгчтэй тохирох хэлбэрийн өрхүүдтэй харьцуулахад ихээхэн өндөр өсөлт юм.

ЗУРАГ 3.2. ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2000, 2010 ОН



Өрхийн тэргүүлэгчдийн нас, хүйсийн суваргыг зураг 3.1.2-т байршлаар үзүүлэв. Улсын дүнгээр 2000 онд эрэгтэй тэргүүлэгчтэй өрх эмэгтэй тэргүүлэгчтэй өрхөөс 5.1 дахин олон байсан бол энэ харьцаа 2010 онд 1.5 пунктээр буурч 3.6 болов. Эмэгтэй тэргүүлэгчид бүх насанд өмнөх тооллогын үеэс нэмэгдсэн бөгөөд ялангуяа 40-54 насанд хамгийн ихээр өсчээ. Өрхийн тэргүүлэгчдийг насны хувьд таллан хувааж байгаа үзүүлэлт болох голч нас 2000 онд 39.0 (эрэгтэй тэргүүлэгч 38.0, эмэгтэй тэргүүлэгч 46.6) байснаа сүүлчийн тооллогоор 41.5 (эрэгтэй тэргүүлэгч 40.1, эмэгтэй тэргүүлэгч 47.5) болж нэмэгдсэн нь насны бүтэц идэрших хандлагатай болсныг харуулна. Байршлаар нь ангилж үзэхэд хотод өрхийн тэргүүлэгчдийн тоо бүх насанд нэмэгдсэн байхад хөдөөд 40-54 наснаас бусад насанд буурсан байна. Хөдөөгийн 15-34 насны эрэгтэй тэргүүлэгчтэй өрх 2000 оны түвшнээс хамгийн ихээр буурсан нь шилжих хөдөлгөөнтэй холбоотой болов уу.

ХҮСНЭГТ 3.2. ӨРХИЙН АМ БҮЛИЙН ДУНДАЖ ТОО, ӨРХИЙН ХЭЛБЭР, ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010 ОН

Өрхийн хэлбэр		Байршил		
		Бүгд	Хот	Хөдөө
Ам бүлээрээ	Бүгд	3.6	3.5	3.7
	Эрэгтэй	3.7	3.6	3.8
	Эмэгтэй	2.8	2.8	2.8
Нийлмэл	Бүгд	4.6	4.6	4.3
	Эрэгтэй	4.8	4.9	4.5
	Эмэгтэй	4.1	4.1	3.7
Холимог	Бүгд	4.6	4.6	4.4
	Эрэгтэй	4.7	4.7	4.5
	Эмэгтэй	4.2	4.3	3.8

Улсын хэмжээнд ам бүлээрээ амьдарч байгаа өрхөд дунджаар 3.6 гишүүн, нийлмэл өрхөд 4.8 хүн, холимог өрхөд 4.7 хүн ногдож байна. Үүнийг өрхийн тэргүүлэгчийн хүйс, байршлаар ангилж үзэхэд тодорхой ялгаа ажиглагдана. Тодруулбал, хотод ам бүлээрээ байгаа өрхийн ам бүлийн дундаж тоо хөдөөгийнхөөс бага байхад бусад хэлбэрийн хувьд хөдөөд ам бүлийн дундаж тоо нь их байна. Энэ нь хотод орон сууцны хүрэлцээ, хангамж тааруу, шилжин ирсэн иргэн орон сууц худалдан авах бололцоо тэр бүр байхгүй байгаатай холбоотойгоор өрх нийлж, нэг сууцанд амьдарч байгаагаар тайлбарлагдана. Өрхийн тэргүүлэгчийн хүйсээр ангилсан дүнгээс харахад эмэгтэй тэргүүлэгчтэй өрх эрэгтэй тэргүүлэгчтэй өрхтэй харьцуулахад илүү цөөхүүлээ амьдарч байна. Энэ нь эрэгтэй өрхийн тэргүүлэгчидтэй харьцуулахад салсан, бэлбэсэн эмэгтэйчүүд өрх тэргүүлэн олноороо амьдарч байгаатай холбоотой юм.

### ХҮСНЭГТ 3.3. ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН БОЛОН ЭХНЭР/НӨХРИЙН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХҮЙСЭЭР, 2000, 2010 ОН

2010 он

Боловсролын түвшин*		Бүгд			Боловсролгүй			Ерөнхий боловсрол			Мэргэжлийн боловсрол			Дээд боловсрол		
		Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Тоо	Бүгд	470 867	466 388	4 479	17 771	17 701	70	308 214	305 697	2 517	50 370	49 765	605	94 512	93 225	1 287
	Нөхөр	4 479	-	4 479	70	-	70	2 517	-	2 517	605	-	605	1 287	-	1 287
	Эхнэр	466 388	466 388	-	17 701	17 701	-	305 697	305 697	-	49 765	49 765	-	93 225	93 225	-
Хувь	Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
	Нөхөр	100.0	-	100.0	100.0	-	100.0	100.0	-	100.0	100.0	-	100.0	100.0	-	100.0
	Эхнэр	100.0	100.0	-	100.0	100.0	-	100.0	100.0	-	100.0	100.0	-	100.0	100.0	-
Боловсролгүй	Бүгд	2.7	2.7	2.5	31.6	31.6	35.7	2.2	2.2	2.9	0.7	0.7	1.5	0.1	0.1	0.2
	Нөхөр	2.5	-	2.5	35.7	-	35.7	2.9	-	2.9	1.5	-	1.5	0.2	-	0.2
	Эхнэр	2.7	2.7	-	31.6	31.6	-	2.2	2.2	-	0.7	0.7	-	0.1	0.1	-
Ерөнхий боловсрол	Бүгд	58.3	58.2	63.9	62.1	62.1	60.0	73.9	73.9	81.0	39.6	39.4	56.7	16.3	16.1	33.9
	Нөхөр	63.9	-	63.9	60.0	-	60.0	81.0	-	81.0	56.7	-	56.7	33.9	-	33.9
	Эхнэр	58.2	58.2	-	62.1	62.1	-	73.9	73.9	-	39.4	39.4	-	16.1	16.1	-
Мэргэжлийн боловсрол	Бүгд	13.3	13.4	10.8	4.0	4.0	2.9	10.4	10.4	7.3	36.7	36.8	25.6	12.3	12.3	11.0
	Нөхөр	10.8	-	10.8	2.9	-	2.9	7.3	-	7.3	25.6	-	25.6	11.0	-	11.0
	Эхнэр	13.4	13.4	-	4.0	4.0	-	10.4	10.4	-	36.8	36.8	-	12.3	12.3	-
Дээд боловсрол	Бүгд	25.7	25.7	22.9	2.3	2.3	1.4	13.5	13.6	8.8	23.0	23.1	16.2	71.2	71.5	54.9
	Нөхөр	22.9	-	22.9	1.4	-	1.4	8.8	-	8.8	16.2	-	16.2	54.9	-	54.9
	Эхнэр	25.7	25.7	-	2.3	2.3	-	13.6	13.6	-	23.1	23.1	-	71.5	71.5	-

2000 он

Боловсролын түвшин*		Бүгд			Боловсролгүй			Ерөнхий боловсрол			Мэргэжлийн боловсрол			Дээд боловсрол		
		Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Тоо	Бүгд	385 174	383 315	1 859	11 728	11 688	40	262 906	261 842	1 064	61 217	60 831	386	49 323	48 954	369
	Нөхөр	1 859	-	1 859	40	-	40	1 064	-	1 064	386	-	386	369	-	369
	Эхнэр	383 315	383 315	-	11 688	11 688	-	261 842	261 842	-	60 831	60 831	-	48 954	48 954	-
Хувь	Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
	Нөхөр	100.0	-	100.0	100.0	-	100.0	100.0	-	100.0	100.0	-	100.0	100.0	-	100.0
	Эхнэр	100.0	100.0	-	100.0	100.0	-	100.0	100.0	-	100.0	100.0	-	100.0	100.0	-
Боловсролгүй	Бүгд	2.7	2.7	2.4	42.8	42.8	35.0	1.8	1.8	2.8	0.8	0.8	0.3	0.1	0.1	0.0
	Нөхөр	2.4	-	2.4	35.0	-	35.0	2.8	-	2.8	0.3	-	0.3	0.0	-	0.0
	Эхнэр	2.7	2.7	-	42.8	42.8	-	1.8	1.8	-	0.8	0.8	-	0.1	0.1	-
Ерөнхий боловсрол	Бүгд	65.3	65.3	63.3	53.4	53.4	57.5	79.6	79.6	80.4	42.1	42.0	49.2	20.5	20.4	29.5
	Нөхөр	63.3	-	63.3	57.5	-	57.5	80.4	-	80.4	49.2	-	49.2	29.5	-	29.5
	Эхнэр	65.3	65.3	-	53.4	53.4	-	79.6	79.6	-	42.0	42.0	-	20.4	20.4	-
Мэргэжлийн боловсрол	Бүгд	21.3	21.3	16.3	3.6	3.6	5.0	14.9	14.9	10.0	47.2	47.2	33.2	27.4	27.4	18.2
	Нөхөр	16.3	-	16.3	5.0	-	5.0	10.0	-	10.0	33.2	-	33.2	18.2	-	18.2
	Эхнэр	21.3	21.3	-	3.6	3.6	-	14.9	14.9	-	47.2	47.2	-	27.4	27.4	-
Дээд боловсрол	Бүгд	10.8	10.8	18.0	0.2	0.2	2.5	3.7	3.7	6.9	10.0	9.9	17.4	52.0	52.0	52.3
	Нөхөр	18.0	-	18.0	2.5	-	2.5	6.9	-	6.9	17.4	-	17.4	52.3	-	52.3
	Эхнэр	10.8	10.8	-	0.2	0.2	-	3.7	3.7	-	9.9	9.9	-	52.0	52.0	-


\* Тайлбар: Ерөнхий боловсролд бага, суурь, бүрэн дунд боловсролыг, Мэргэжлийн боловсролд техникийн болон мэргэжлийн, тусгай мэргэжлийн дунд боловсролыг, Дээд боловсролд дипломын дээд болон бакалавр, магистр, докторын боловсролыг тус тус хамруулав.

Өрхийн тэргүүлэгч болон эхнэр/нөхрийн боловсролын түвшинг зэрэгцүүлж, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр ангилан дээрх хүснэгтэд үзүүлэв. Хүснэгтийн үр дүнг тайлбарлахаас өмнө дараах асуудлыг тодруулах нь зүйтэй юм.

Улсын хэмжээнд 2010 оны байдлаар 713.8 мянган өрх байгаагийн 470.9 мянга буюу 66 хувь өрхийн тэргүүлэгч, эхнэр/нөхрийн хамт тоологдсон өрх ажээ. Үүний 99 хувь нь эрэгтэй тэргүүлэгчтэй өрх, 1.0 хувь буюу 4.5 мянган өрх эмэгтэй тэргүүлэгчтэй байна. Үлдсэн нь өрхийн тэргүүлэгч огт гэрлээгүй, салсан, бэлбэсэн болон эхнэр/нөхөр хамт тоологдоогүй буюу гадаадад эсвэл өөр аймаг, нийслэлд тусдаа тоологдсон өрхүүд юм.

Эрэгтэйчүүдийн боловсролын түвшин доогуур байгаа нь өрхийн түвшинд ч тодорхой харагдана. Тухайлбал, сүүлчийн тооллогын дүнгээр ижил түвшний боловсролтой эхнэр, нөхрүүдийн хувьд ерөнхий боловсролоос бага түвшинд эрэгтэйчүүд давамгайлж байхад (хувийн жин нь тус бүр 35.7, 81.0) мэргэжлийн, түүнээс дээш боловсролын түвшинд эмэгтэйчүүд илүү (хувийн жин нь тус бүр 36.8, 71.5) байна. Өөрөөр хэлбэл, боловсролгүй эрэгтэй тэргүүлэгчтэй өрхийн эхнэрийн 31.6 хувь нь боловсролгүй бол эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн нөхрийн 35.7 хувь нь боловсролгүй юм. Гэтэл дээд боловсролтой эрэгтэй тэргүүлэгчтэй өрхийн хувьд энэ үзүүлэлт 71.5 хувь бол эмэгтэй тэргүүлэгчтэй өрхөд 54.9 хувь болж, ялгаа нь улам нэмэгджээ. 2000 оны тооллогын дүнгээс харахад мэргэжлийн боловсролоос бусад түвшинд эхнэр, нөхрийн боловсролын түвшний ялгаа 2010 оных шиг их байсангүй. Харин ч тухайн үед боловсролгүй эрэгтэй өрхийн тэргүүлэгчийн хувьд ижил түвшний боловсролтой эхнэрийн хувийн жин эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн нөхрийнхтэй харьцуулахад илүү (тус бүр 42.8, 35.0 хувь) байжээ. Өөрөөр хэлбэл, боловсролгүй эхнэр их байсан гэсэн үг юм. Энэ бүхнээс үзэхэд нөхрийн боловсролын түвшин эхнэрээсээ бага байх хандлага сүүлчийн 2 тооллогын дүнгээс тодорхой харагдсаны дээр 2010 онд энэ ялгаа улам нэмэгджээ.

**ЗУРАГ 3.3. ЭХНЭР/НӨХРИЙН ХАМТ ТООЛОГДСОН ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХҮЙС, ХУВИАР, 2000, 2010 ОН**



Дээрх зургаас харахад өрхийн эмэгтэй тэргүүлэгчдийн боловсролын түвшин улам нэмэгдэх хандлагатай болжээ.

Сүүлчийн 11 жил орчмын хугацаанд салалт, ялангуяа 45-54 насанд ихээр нэмэгдсэн нь эхнэр, нөхрийн боловсролын түвшний ялгаа улам ихэссэнээс шалтгаалсан эсэхийг цаашид нарийвчлан судлах нь зүйтэй юм. Нөгөө талаар, охин хүүхдээ бусдаас дутуугүй боловсрол эзэмшүүлж, ажил амьдралд нь залгуулах гэсэн эцэг, эхчүүдийн үзэл хандлагын цаана хөвгүүд орхигдож, өрхөд дээрх байдлаар нөлөөлөх болсныг онцгой анхаарах шаардлагатай болжээ.

Өрхийн тэргүүлэгч, түүний эхнэр/нөхрийн хөдөлмөр эрхлэлтийг авч үзэх нь өрх, гэр бүлийн хүрээнд жендерийн ялгаатай байдлыг гаргахад ихээхэн чухал үзүүлэлт билээ. Ялангуяа, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт өрхийн түвшинд гэр бүлийн хүчирхийлэл, шийдвэр гаргах эрх мэдэл, бие даасан байдал, цаашлаад байгууллага, хамт олны түвшин дэх өөрийгөө илэрхийлэх, таниулах чадвар, макро түвшинд улс төрийн төлөөлөл зэрэг олон хүчин зүйлд нөлөөлдөг.

Эхнэр, нөхөр хоёулаа хөдөлмөр эрхэлж байгаа хувь эрэгтэй тэргүүлэгчтэй өрхөд 68.8 болж, 2000 оны түвшнээс 3.6 пунктээр буурсан бол эмэгтэй тэргүүлэгчтэй өрхөд 68.1 хувь болж, 3.5 пунктээр өсчээ. Харин эхнэр, нөхөр хоёулаа ажилгүй байх хандлага өмнөх тооллогын үеийнхээс буурсны дотор эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн хувьд илүү ихээр багасав. Энэ нь өрхийн түвшинд гэрийн эзэгтэй нарын эдийн засгийн идэвх өмнөх тооллогын дүнтэй харьцуулахад буурсныг харуулна. Нийт хүн амын дунд эрэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт эмэгтэйчүүдтэй харьцуулахад нэмэгдсэнтэй холбоотойгоор өрхийн тэргүүлэгчийн хүйсээс үл хамаараад эрэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт илүү байна.

### ХҮСНЭГТ 3.4. ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН БОЛОН ЭХНЭР/НӨХРИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХҮЙСЭЭР, 2000, 2010 ОН

2010 он

Хөдөлмөр эрхэлдэг эсэх	Бүгд	Бүгд			Хөдөлмөр эрхэлдэг			Хөдөлмөр эрхэлдэггүй		
		Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Тоо	Бүгд	470 867	466 388	4 479	308 551	306 224	2 327	162 316	160 164	2 152
	Нөхөр	4 479	-	4 479	2 327	-	2 327	2 152	-	2 152
	Эхнэр	466 388	466 388	-	306 224	306 224	-	160 164	160 164	-
Хувь	Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
	Нөхөр	100.0	-	100.0	100.0	-	100.0	100.0	-	100.0
	Эхнэр	100.0	100.0	-	100.0	100.0	-	100.0	100.0	-
Хөдөлмөр эрхэлдэг	Бүгд	56.2	56.2	55.9	68.8	68.8	68.1	32.1	31.9	42.8
	Нөхөр	55.9	-	55.9	68.1	-	68.1	42.8	-	42.8
	Эхнэр	56.2	56.2	-	68.8	68.8	-	31.9	31.9	-
Хөдөлмөр эрхэлдэггүй	Бүгд	43.8	43.8	44.1	31.2	31.2	31.9	67.9	68.1	57.2
	Нөхөр	44.1	-	44.1	31.9	-	31.9	57.2	-	57.2
	Эхнэр	43.8	43.8	-	31.2	31.2	-	68.1	68.1	-

2000 он

Хөдөлмөр эрхэлдэг эсэх	Бүгд	Бүгд			Хөдөлмөр эрхэлдэг			Хөдөлмөр эрхэлдэггүй		
		Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Тоо	Бүгд	385 174	383 315	1 859	255 982	254 997	985	129 192	128 318	874
	Нөхөр	1 859	-	1 859	985	-	985	874	-	874
	Эхнэр	383 315	383 315	-	254 997	254 997	-	128 318	128 318	-
Хувь	Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
	Нөхөр	100.0	-	100.0	100.0	-	100.0	100.0	-	100.0
	Эхнэр	100.0	100.0	-	100.0	100.0	-	100.0	100.0	-
Хөдөлмөр эрхэлдэг	Бүгд	58.1	58.2	51.2	72.3	72.4	64.6	30.0	29.9	36.2
	Нөхөр	51.2	-	51.2	64.6	-	64.6	36.2	-	36.2
	Эхнэр	58.2	58.2	-	72.4	72.4	-	29.9	29.9	-
Хөдөлмөр эрхэлдэггүй	Бүгд	41.9	41.8	48.8	27.7	27.6	35.4	70.0	70.1	63.8
	Нөхөр	48.8	-	48.8	35.4	-	35.4	63.8	-	63.8
	Эхнэр	41.8	41.8	-	27.6	27.6	-	70.1	70.1	-

Хүснэгт 3.5-д сууцны эзэмшлийн хэлбэрийг сууцны төрөл, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр ангилж үзүүлэв. Нийт өрхийн 86.7 хувь өөрийн эзэмшлийн сууцтай бол үлдсэн 13.3 хувь буюу 94.7 мянган өрх бусдын сууцанд амьдарч байна. Эрэгтэй тэргүүлэгчтэй өрхийн 88.1 хувь, эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн 81.7 хувь нь өөрийн гэсэн сууцтай юм. Бусдын сууц түрээсэлдэг, түрээсгүй ашигладаг аль ч тохиолдолд эмэгтэй тэргүүлэгчтэй өрх олон байна. Байршлаар нь авч үзвэл хотод өөрийн эзэмшлийн сууцтай өрх хөдөөтэй харьцуулахад бага, хотын эмэгтэй тэргүүлэгчтэй 10 өрх тутмын нэг нь байр түрээслэн амьдарч байна.

Гэрт амьдардаг өрхийн 6 хувь, байшинд амьдардаг өрхийн 18 хувь өөрийн гэсэн сууцгүй байгаагийн дийлэнх хэсгийг эмэгтэй тэргүүлэгчтэй өрх бүрдүүлж байна. Гэхдээ хөдөөд гэр түрээслэн амьдрах явдал хоттой харьцуулахад бага юм. Байшинд суудаг эрэгтэй тэргүүлэгчтэй хот, хөдөөгийн өрхийн 83-86 хувь нь өөрийн эзэмшлийн сууцтай байхад эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн хувьд энэ үзүүлэлт байршлаар ялгаагүй 77 орчим хувьтай байна. Энэ бүхнээс дүгнэхэд хотод сууцны хүрэлцээ, хангамж тааруу байгаагаас шалтгаалан өрхүүд, тэр дундаа эмэгтэй тэргүүлэгчтэй өрх бусдын сууцанд амьдрах явдал түгээмэл байна. Тиймээс тэдний орлогыг нэмэгдүүлж, хүний анхдагч хэрэгцээ болсон хямд, чанартай сууцаар хангах, зээлийн хүүгийн бодлогоор дэмжихэд анхаарах шаардлагатайг харуулна.

### ХҮСНЭГТ 3.5. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ЭЗЭМШЛИЙН ХЭЛБЭР, СУУЦНЫ ТӨРӨЛ, ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010 ОН

Эзэмшлийн хэлбэр	Бүгд			Гэр			Байшин			Зориулалтын бус сууц, бусад		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
<b>УЛСЫН ДҮН</b>												
Тоо	713 780	560 224	153 556	322 836	258 461	64 375	382 808	296 267	86 541	8 136	5 496	2 640
Хувь	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Өөрийн эзэмшлийн	86.7	88.1	81.7	93.9	94.7	90.5	81.9	83.3	76.8	31.4	33.6	26.9
Бусдын сууцанд түрээстэй суудаг	6.3	5.6	9.0	1.5	1.3	2.4	9.9	8.9	13.2	27.7	25.9	31.6
Бусдын сууцанд түрээсгүй суудаг	6.1	5.5	8.2	4.1	3.6	6.5	7.4	6.9	9.0	24.9	25.1	24.6
Бусад	0.9	0.8	1.1	0.5	0.4	0.6	0.9	0.9	1.0	15.9	15.4	16.9
<b>ХОТ</b>												
Тоо	479 503	364 270	115 233	156 744	119 139	37 605	316 116	240 749	75 367	6 643	4 382	2 261
Хувь	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Өөрийн эзэмшлийн	83.6	85.0	79.4	90.8	91.7	87.9	81.3	82.7	76.8	28.6	30.5	25.1
Бусдын сууцанд түрээстэй суудаг	8.5	7.7	11.1	2.7	2.4	3.8	10.9	10.0	14.1	30.3	29.0	32.8
Бусдын сууцанд түрээсгүй суудаг	6.9	6.4	8.4	5.8	5.3	7.6	7.0	6.7	8.3	23.9	24.0	23.7
Бусад	0.9	0.9	1.1	0.6	0.6	0.7	0.8	0.7	0.8	17.2	16.6	18.4
<b>ХӨДӨӨ</b>												
Тоо	234 277	195 954	38 323	166 092	139 322	26 770	66 692	55 518	11 174	1 493	1 114	379
Хувь	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Өөрийн эзэмшлийн	93.0	93.9	88.6	96.8	97.3	94.2	84.7	86.3	76.9	43.8	46.0	37.5
Бусдын сууцанд түрээстэй суудаг	1.7	1.6	2.6	0.3	0.3	0.5	4.9	4.5	6.9	16.5	13.7	24.5
Бусдын сууцанд түрээсгүй суудаг	4.5	3.9	7.8	2.5	2.1	4.9	8.8	7.8	14.2	29.7	29.6	29.8
Бусад	0.7	0.7	1.0	0.3	0.3	0.5	1.6	1.5	2.0	10.0	10.7	8.2

## ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭЦЭГ, ЭХЧҮҮДИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ЯЛГААТАЙ БАЙДАЛ

Энэ хэсэгт өрх толгойлсон эцэг, эхийг тэдний ам бүл, хүүхдийн тоо, нийгэм, эдийн засгийн үзүүлэлттэй холбож судалсан. Энэ төрлийн судалгаанаас харахад өрх толгойлсон эх, түүний гэр бүлийн гишүүд өрх толгойлсон эцгийнхтэй харьцуулахад илүү эмзэг, ядууралд өртөмтгийг нотлон харуулсан байдаг. Хэдийгээр тооллогоор ядуурал, амьжиргааны түвшинг тодорхойлох үзүүлэлт цуглуулаагүй боловч өрхийн тэргүүлэгчийн хөдөлмөр эрхлэлт, орон сууцны нөхцөл зэрэг үзүүлэлтээс зарим чухал дүгнэлтийг хийж болох юм.

Улсын хэмжээнд өрх толгойлсон эцэг, эхийн тоо 83.9 мянга болж, 2000 оны тооллогын үеийнхээс 22.5 хувиар нэмэгдсэний дотор өрх толгойлсон эхийн тоо 31 хувиар өссөн бол өрх толгойлсон эцгийн тоо 5.9 хувиар буурчээ. Өрх толгойлсон эцэг, эхийн 17.6 хувь нь эрэгтэйчүүд, 82.4 хувь нь эмэгтэйчүүд байна. Нийт дүнгээрээ өрх толгойлсон эцэг, эхийн тоо хотод 44.4 хувиар өссөн байхад хөдөөд 11.7 хувиар буурав. Хүйсээр нь авч үзвэл өрх толгойлсон эхийн тоо хотод S-ээр өссөн нь хөдөөнөөс хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөнөөс хамаарчээ.


Өрхийн хэлбэрээр ангилахад ам бүлээрээ амьдарч байгаа өрх толгойлсон эхийн тоо тооллого хооронд хамгийн ихээр (нийт дүнгээрээ 39.1 хувь, хотод 70.1 хувь) өссөн (өрхийн бусад хэлбэрийн хувьд ч эхчүүдийн тоо өссөн) нь гэр бүл салсны дараа насанд хүрээгүй хүүхдүүд ихэнхдээ эхийнхээ асрамжид үлдэж байгаатай холбоотой.

### ХҮСНЭГТ 3.6. ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭЦЭГ, ЭХИЙН ТОО, ӨРХИЙН ХЭЛБЭР, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2000, 2010 ОН

Үзүүлэлтүүд	Бүгд		Өөрчлөлт	Хот		Өөрчлөлт	Хөдөө		Өөрчлөлт	
	2000	2010		2000	2010		2000	2010		
<b>ТООГООР</b>										
Бүгд	Бүгд	68 505	83 929	22.5	41 824	60 381	44.4	26 681	23 548	-11.7
	Эрэгтэй	15 696	14 771	-5.9	8 858	9 942	12.2	6 838	4 829	-29.4
	Эмэгтэй	52 809	69 158	31.0	32 966	50 439	53.0	19 843	18 719	-5.7
Ам бүлээрээ	Бүгд	39 985	52 281	30.8	21 324	34 501	61.8	18 661	17 780	-4.7
	Эрэгтэй	8 911	9 058	1.6	4 234	5 437	28.4	4 677	3 621	-22.6
	Эмэгтэй	31 074	43 223	39.1	17 090	29 064	70.1	13 984	14 159	1.3
Нийлмэл	Бүгд	26 639	29 727	11.6	18 954	24 364	28.5	7 685	5 363	-30.2
	Эрэгтэй	6 359	5 411	-14.9	4 273	4 265	-0.2	2 086	1 146	-45.1
	Эмэгтэй	20 280	24 316	19.9	14 681	20 099	36.9	5 599	4 217	-24.7
Холимог	Бүгд	1 881	1 921	2.1	1 546	1 516	-1.9	335	405	20.9
	Эрэгтэй	426	302	-29.1	351	240	-31.6	75	62	-17.3
	Эмэгтэй	1 455	1 619	11.3	1 195	1 276	6.8	260	343	31.9
<b>ХУВИАР</b>										
Бүгд	Бүгд	100.0	100.0	0.0	100.0	100.0	0.0	100.0	100.0	0.0
	Эрэгтэй	22.9	17.6	-5.3	21.2	16.5	-4.7	25.6	20.5	-5.1
	Эмэгтэй	77.1	82.4	5.3	78.8	83.5	4.7	74.4	79.5	5.1
Ам бүлээрээ	Бүгд	100.0	100.0	0.0	100.0	100.0	0.0	100.0	100.0	0.0
	Эрэгтэй	22.3	17.3	-5.0	19.9	15.8	-4.1	25.1	20.4	-4.7
	Эмэгтэй	77.7	82.7	5.0	80.1	84.2	4.1	74.9	79.6	4.7
Нийлмэл	Бүгд	100.0	100.0	0.0	100.0	100.0	0.0	100.0	100.0	0.0
	Эрэгтэй	23.9	18.2	-5.7	22.5	17.5	-5.0	27.1	21.4	-5.8
	Эмэгтэй	76.1	81.8	5.7	77.5	82.5	5.0	72.9	78.6	5.8
Холимог	Бүгд	100.0	100.0	0.0	100.0	100.0	0.0	100.0	100.0	0.0
	Эрэгтэй	22.6	15.7	-6.9	22.7	15.8	-6.9	22.4	15.3	-7.1
	Эмэгтэй	77.4	84.3	6.9	77.3	84.2	6.9	77.6	84.7	7.1


Өрх толгойлсон эцэг, эхийн тооны өөрчлөлтийг тэдний гэр бүллэлтийн байдлаар ангилж харахад нэлээд зүйл тодорхой болж байна. Сүүлчийн 11 жил орчмын хугацаанд салалт, ялангуяа 45-54 насанд маш ихээр нэмэгдсэнтэй холбоотой ажээ.

ЗУРАГ 3.3. САЛСАН\* ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭЦЭГ, ЭХИЙН ХУВЬ, НАСНЫ БҮЛГЭЭР, 2000, 2010 ОН



Хэдийгээр 35-44 насны хос хамгийн ихээр салж байгаа хандлага тооллого хооронд хэвээр байгаа боловч дараагийн насны бүлэгт ийнхүү өссөн шалтгааныг цаашид гүнзгийрүүлэн судлах шаардлагатай юм. Өрхийн доторх ажил амьдрал жигдэрч, хат сууж туршлагажсан, үр хүүхэд нь өсч том болсон үед салалт ихээр нэмэгдсэн нь нэг талаас гэр бүлийн хүчирхийлэл, шилжилтийн үеийн зовлон бэрхшээл гэр бүлийн харилцаанд нөлөөлсөн, нөгөө талаас “дунд насныхны хямрал (middle life crisis)” буюу эрэгтэй, эмэгтэйчүүдийн идэр наснаас ахмад насанд шилжих үеийн биологийн өөрчлөлт (санаа зовнил, цэвэршилт, сэтгэл зүйн тогтворгүй байдал), ажилгүйдэл эсвэл ажлын хэт их ачаалалд дарагдах зэрэг нийгмийн болоод сэтгэлзүйн олон хүчин зүйлээс хамаарч байж болзошгүй юм.


ЗУРАГ 3.4. ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭЦЭГ, ЭХИЙН ХУВЬ, НАСНЫ БҮЛГЭЭР, 2000, 2010 ОН



Өрхийн тоог өрхийн тэргүүлэгчийн хүйсээр ангилахад эрэгтэйчүүд давамгайлж байсан бол тэднийг гэр бүлийн байдал болон хүүхэдтэй эсэхээр нь ялгаж харвал өрх толгойлсон эхчүүд эцгүүдээс олон байна. Улсын дүнгээрээ 45-54 насанд эцэг, эхчүүд хамгийн олноор нэмэгджээ. Дараагийн онцлог өөрчлөлт бол 55, түүнээс дээш насны өрх толгойлсон эцгийн хувь өмнөх тооллогын үеэс 10 орчим пунктээр буурсан явдал юм. Хүн амын хүйсийн харьцаа 50 наснаас эхэлж огцом буурсныг дээр тэмдэглэсэн. Өрх толгойлсон эцгийн хувийн жин буурсан нь эрэгтэйчүүдийн нас баралт нэмэгдсэнтэй холбоотой ажээ.


Өрх толгойлсон эцэг, эхийн голч нас 2000 онд 43.2 (эцэг 51.7, эх 41.0) байснаа сүүлчийн тооллогоор 44.0 (эцэг 48.1, эх 43.3) болж өсөв. Эмэгтэй тэргүүлэгчийн голч нас эрэгтэйгийнхээс өндөр байсан бол өрх толгойлсон эцгийн голч нас эхийнхээс илүү байгаа нь онцлог юм. 2000 онтой харьцуулахад өрх толгойлсон эцгийн голч нас буурч, эхийнх өссөн нь эмэгтэйчүүд салсныхаа дараа дахин гэрлэх магадлал эрэгтэйчүүдийнхээс бага байдгаар тайлбарлагдана.

ЗУРАГ 3.5. ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭЦЭГ, ЭХИЙН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, БАЙРШЛААР, 2000, 2010 ОН



Нас, хүйсийн суваргыг байршлаар нь ажиглавал хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөнөөс хамаараад хотод бүх насанд өрх толгойлсон эцэг, эх, ялангуяа 40-54 насанд илүү олноор нэмэгджээ. Харин хөдөөгийн хувьд 45-54, 70, түүнээс дээш наснаас бусад насанд буурсан байна.

ЗУРАГ 3.6. ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭЦЭГ, ЭХИЙН ХУВЬ, ГЭР БҮЛИЙН БАЙДЛААР, 2000, 2010 ОН



Дээрх зургаас харахад өрх толгойлсон эцгийн тоо тооллого хооронд буурсан ч салсан болон бэлбэсэн эцгийн хувийн жин эхийнхтэй харьцуулахад ихээр өөрчлөгдсөн байна. Тухайлбал, өрх толгойлсон, салсан эцгийн хувийн жин 6.5 пунктээр нэмэгдсэн байхад эхийнх 1.4 пунктээр өсөв. Эхнэр нь нас барснаас хойш дахин гэрлээгүй буюу бэлбэсэн эцгийн хувийн жин 8.3 пунктээр буурсан бол эхийнх 2.3 пунктээр багасчээ.

Боловсрол нь хүний хөгжилд ихээхэн нөлөөлдөг үзүүлэлт бөгөөд түүнийг нийгэм, эдийн засгийн олон хүчин зүйлтэй холбон судалгаанд өргөн хэрэглэдэг. Хүний амьдралын анхдагч орчин өрх, гэр бүлийн хувьд өрхийн тэргүүлэгчийн боловсролын түвшин нь өрхийн сайн сайхан байдал, ядуурал, хүүхдийн сургуульд хамрагдалт, боловсрол, эрүүл мэнд зэрэг олон хүчин зүйлд шууд нөлөөлдөг.

Өрх толгойлсон эцэг, эхийн боловсролын түвшин өмнөх тооллогын үеийнхээс сайжирчээ. Ерөнхий дүнгээрээ боловсролгүй эцэг, эхийн хувь 4.2 пунктээр буурч, 6.0 хувь болов. Харин хүйсийн хувьд онцлогтой байна. 2000 онд боловсролгүй өрх толгойлсон эхийн нийт өрх толгойлсон эхэд эзлэх хувийн жин их байснаа 2010 онд эцгийнх давамгайл болжээ. Боловсролын түвшингээр ангилахад бүрэн дунд боловсролтой өрх толгойлсон эцгийн хувь 14.1 пунктээр, дээд боловсролтой эхийнх 9.4 пунктээр нэмэгдсэн нь хамгийн өндөр үзүүлэлт юм. Боловсролтой өрх толгойлсон эцэг, эхийн хүйсийн харьцаа боловсролын аль ч түвшинд өмнөх тооллогын үеэс буурсан нь боловсрол дахь жендерийн тэгш бус байдал улам нэмэгдсэнийг харуулна.

### ХҮСНЭГТ 3.7. ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭЦЭГ, ЭХИЙН ТОО, БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХУВИАР, 2000, 2010 ОН

Боловсролын түвшин		2010			2000			Хүйсийн харьцаа	
		Бүгд	Эцэг	Эх	Бүгд	Эцэг	Эх	2010	2000
Бүгд	Тоо	83 929	14 771	69 158	68 505	15 696	52 809	21.4	29.7
		100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	-	-
Боловсролгүй		6.0	6.3	5.9	10.2	9.7	10.3	22.9	28.0
Бага		15.0	18.9	14.2	24.9	27.5	24.1	28.5	33.9
Суурь		15.9	19.5	15.1	22.4	25.4	21.5	27.5	35.2
Бүрэн дунд		29.4	26.7	29.9	16.0	12.6	17.1	19.1	22.0
Техникийн болон мэргэжлийн	Хувь	3.9	4.4	3.8	4.2	3.8	4.4	24.5	26.1
Тусгай мэргэжлийн дунд		11.1	7.9	11.8	12.1	9.5	12.8	14.3	22.0
Дээд		18.7	16.2	19.2	10.2	11.4	9.8	18.1	34.3

Тооллогын үр дүнд үндэслэн өрх толгойлсон эцэг, эхийн эмзэг байдлыг илэрхийлж болох үзүүлэлт бол тэдний хөдөлмөр эрхлэлт юм. Өрх толгойлсон эцэг, эх, тэр дундаа эхчүүд хөдөлмөр эрхлэлт бага, тэр хэрээрээ ядууралд өртөмтгий байдгийг олон судалгааны баримтаар нотолдог.


Хүүхэдтэйгээ амьдарч байгаа, огт гэрлээгүй, салсан эсвэл бэлбэсэн эрэгтэй, эмэгтэй өрх толгойлсон эцэг, эх гэж тодорхойлсон нь өрхийн тэргүүн эрэгтэй, эмэгтэй байхаас ялгаатайг ойлголт, тодорхойлолтод тодорхой дурдсан билээ. Тиймээс өрх толгойлсон эцэг, эх хэдэн хүүхэдтэй, хичнээн ам бүлтэйг судлах нь зүй ёсны асуудал юм. Хүүхдийн болон ам бүлийн тоо олон байх нь тэдний ачааллыг нэмэгдүүлж, өрхийн нэг хүнд ногдох орлогод нөлөөлдөг.

ЗУРАГ 3.7. ХҮҮХДИЙН ДУНДАЖ ТОО, ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭЦЭГ, ЭХИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГ ЭСЭХЭЭР, 2000, 2010 ОН



Улсын хэмжээнд 2010 оны байдлаар өрх толгойлсон эцэг, эхэд ногдох хүүхдийн дундаж тоо ойролцоогоор 1.8 болж, 2000 оны түвшнээс 0.5 пунктээр буурав. Харин эцэгт ногдох хүүхдийн дундаж тоо 1.7 болж, 0.4 пунктээр, эхийн хувьд 1.8 болж, 0.5 пунктээр тус тус буурчээ. Өрх толгойлсон эхэд ногдох хүүхдийн дундаж тоог хөдөлмөр эрхэлдэг эсэхээр нь ангилж үзэхэд энэ давамгайл байдал хадгалагдаж байна. Хөдөлмөр эрхэлдэг эцэгт ногдох хүүхдийн дундаж тоо эрхэлдэггүйгээс олон байгаа бол 2010 онд хөдөлмөр эрхэлдэг эхэд ногдох хүүхдийн дундаж тоо эрхэлдэггүйгээс бага болсон дүнтэй гарлаа. Өрх толгойлсон эх олон хүүхэд тэжээж байгаагаас гадна хөдөлмөр эрхлэхгүй байгаа нь тэдний ядууралд өртөх магадлалыг нэмэгдүүлж, эмзэг байдалд оруулдгийг цаашид анхаарч, нийгмийн халамжийн бодлогыг зорилтот бүлэгт илүү чиглүүлэх, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах нь зүйтэй. Тухайлбал, тэд үр хүүхдээ өсгөх, гэр орны ажлаа амжуулахад эрэгтэйчүүдээс илүү цаг зав гаргадгийг харгалзан ажлын цагийн уян хатан зохицуулалт хийх боломжийг судлах, өндөр настан, хүүхэд асрах газар, ясли цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зэрэг асуудлыг шийдвэрлэх шаардлагатай юм.

ЗУРАГ 3.8. ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭЦЭГ, ЭХИЙН ХУВЬ, ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГ ЭСЭХ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2000, 2010 ОН



Өрх толгойлсон эцэг, эхийн 42.3 хувь хөдөлмөр эрхэлж байгаа нь өмнөх тооллогын үеийнхээс бага зэрэг буурсан (0.4 пунктээр) бол хөдөлмөр эрхэлдэггүй хувь 57.7 болж өсчээ. Хүйсээр нь ангилж үзэхэд эцгүүдийн хөдөлмөр эрхлэлт эхчүүдтэй харьцуулахад доогуур түвшинд байна. Энэ нь тэдний насны бүтэц болон боловсролын түвшний ялгаанаас шалтгаалсан байж болох юм. Эрэгтэй, эмэгтэйчүүдийн боловсролын түвшин дэх тэнцвэрт бус харьцаа өрхийн түвшинд нэмэгдсэн нь дээрх ялгаа нэмэгдэхэд нөлөөлсөн байх талтай бөгөөд байршлаар нарийвчилж ангилахад илүү тодорхой үр дүн ажиглагдана.

Хот, хөдөөгийн өрх толгойлсон эцэг, эхийн хөдөлмөр эрхлэлт дэх тэнцвэрт бус харьцаа 2010 онд илүү гүнзгийрэв. Ялангуяа, хотод хөдөлмөр эрхэлдэг эцэг, эхийн хувийн жингийн ялгаа 8.6 пункт байхад хөдөөд энэ зөрүү 1.7 пункт байна. Гэтэл уг үзүүлэлт 2000 онд хотод 7.4 пункт, хөдөөд зөрүүгүй байжээ. Хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа, дэд бүтэц, мэдээллийн хүрэлцээтэй байдлаас шалтгаалаад үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх боломж, бүтэц, зах зээлийн багтаамж харилцан адилгүй байдаг. Хөдөөд мал аж ахуйн үйлдвэрлэл гол амин зуулга болдогос хамаарч, өрх толгойлсон эцэг, эхийн хөдөлмөр эрхлэлтийн ялгаа бага байна. Харин хотод энэ ялгаа их байгаа нь ажлын байранд тавигдах шаардлага эрхлэх ажлаас хамаарахын зэрэгцээ дээд боловсролтой эмэгтэйчүүд илүү байгаатай холбоотой. Хотод өрх толгойлсон эх илүү ихээр хөдөлмөр эрхэлж байгааг ажил мэргэжлээр нь ангилж, дараах хүснэгтэд үзүүлэв.

ХҮСНЭГТ 3.8. ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГ ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭЦЭГ, ЭХИЙН ТОО, АЖИЛ МЭРГЭЖЛИЙН АНГИЛАЛ, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010 ОН

Ажил мэргэжил	Бүгд			Хот			Хөдөө		
	Бүгд	Эцэг	Эх	Бүгд	Эцэг	Эх	Бүгд	Эцэг	Эх
Тоо	35 465	5 601	29 864	25 297	3 450	21 847	10 168	2 151	8 017
Хувь	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Менежер	7.6	7.2	7.7	9.4	9.7	9.3	3.3	3.1	3.4
Мэргэжилтэн	20.5	10.0	22.5	24.4	13.9	26.0	11.0	3.7	13.0
Техникч болон туслах/дэд мэргэжилтэн	6.4	2.4	7.2	7.5	3.1	8.2	3.9	1.4	4.5
Контор, үйлчилгээний ажилтан	3.3	1.4	3.6	4.0	1.9	4.3	1.5	0.5	1.8
Худалдаа үйлчилгээний ажилтан	19.3	10.3	21.0	23.9	15.4	25.3	7.8	2.1	9.3
ХАА, ой, загас агнуурын ажилтан	18.7	30.6	16.4	2.4	4.5	2.0	59.2	72.4	55.6
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан	7.6	12.9	6.6	9.8	18.9	8.4	2.2	3.2	1.9
Суурин төхөөрөг, машин механизмын операторч, угсрагч	3.5	13.3	1.7	4.3	18.8	2.0	1.5	4.6	0.7
Энгийн ажил мэргэжил	12.6	10.9	12.9	13.9	12.3	14.1	9.4	8.7	9.6
Зэвсэгт хүчний ажил, мэргэжил	0.5	1.0	0.3	0.6	1.6	0.4	0.2	0.2	0.2

Хот, хөдөөгийн үйлдвэрлэл, үйлчилгээний хөгжил, бүтэц, ажлын байрны ялгаатай байдлаас шалтгаалаад эрхэлдэг ажлын төрөл өөр өөр байгаа юм. Хөдөөд үндсэндээ мал аж ахуй, газар тариалангийн ажил эрхлэгчид дийлэнх хувийг (59.2 хувь) бүрдүүлж, сумын төвийн төрийн байгууллагууд, тухайлбал боловсрол, эмнэлгүүдэд ажиллагчид зонхилж (11.0 хувь) байна. Мөн амралт, дэн буудлын ажилтан, бусад үйлчилгээний энгийн ажил эрхлэгчид багагүй (тус тус 7.8, 9.4 хувь) байна. ХАА-н өсгөх, үржүүлэх, бүх төрлийн тээврийн хэрэгсэл, машин, механизм жолоодох, ажиллуулах, угсрах, барилга барих болон модон эдлэл хийх, дархан зэрэг чиг үүрэгтэй ажлын байранд өрх толгойлсон эцэг түгээмэл (тус тус 72.4, 4.6, 3.2 хувь) ажиллаж байхад бусад ажилд эхчүүд давамгайлж байна. Ялангуяа, сумын Засаг даргын Тамгын газар, боловсрол, эмнэлэг зэрэг төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллага, банк, санхүүгийн байгууллагын мэргэжилтэн, бөөний болон жижиглэн худалдаа, буудал зэрэг түр сууц, хоол хүнсээр хангах үйлчилгээний ажилтнаар өрх толгойлсон эхчүүд ихэнхдээ (тус тус 13.0, 9.3 хувь) ажилладаг ажээ.

Хотын өрх толгойлсон эцэг, эхийн хувьд хөдөөгийнхтэй адил нэг төрлийн ажлын байранд төвлөрөх бус бусад чиглэлийн ажил мэргэжилд харьцангуй жигд хуваарилагджээ. Мэргэжилтэн, худалдаа, үйлчилгээний ажилтан, энгийн ажил мэргэжилд өрх толгойлсон эцэг, эх олноор ажиллаж байна. Хүйсээр нь ангилж харахад бүх шатны байгууллага, аж

ахуйн нэгжийн үйл ажиллагааг төлөвлөх, удирдан чиглүүлэх үүрэг бүхий ажлын байр, ХАА, ой, загас агнуур, үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан, суурин төхөөрөг, машин механизмын операторч, угсрагч, зэвсэгт хүчний ажил мэргэжилд эцгүүд олноороо (тус тус 9.7, 4.5, 18.9, 18.8, 1.6 хувь) ажиллаж байна. Бусад ажлын байранд эхчүүд, тэр дундаа мэргэжилтэн, худалдаа үйлчилгээний ажилтнаар эхчүүд илүү ихээр (тус тус 26.9, 25.3 хувь) ажиллаж байна.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал буюу хөдөлмөр эрхэлдэг хүний үйлдвэрлэл, үйлчилгээний үндсэн үйл ажиллагааны чиглэлийг судлахад мал, амьтны болон таримал, байгалийн ургамлын нөөцийг ашиглахтай холбоотой үйл ажиллагаа, бүх төрлийн бараа бүтээгдэхүүний бөөний болон жижиглэн худалдаа, төрийн удирдлагаар хэрэгждэг болон бүх шатны, бүх мэргэжлийн боловсрол олгох үйл ажиллагааны салбар хүн амын эдийн засгийн үйл ажиллагааны тэргүүлэгч 4 салбар юм (ҮСХ, ХАОС-ны 2010 оны улсын тооллого: Нэгдсэн дүн). Өрх толгойлсон эцэг, эхийн ажилладаг голлох салбар нь хувьд ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур, бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ, боловсролын болон боловсруулах үйлдвэрлэл гэсэн 4 салбар болж байна. Хотын өрх толгойлсон эцгүүд түүхий эд материалыг хувиргаж, шинээр бүтээгдэхүүн үйлдвэрлэх, барилга, инженерийн байгууламж угсрах, бүх төрлийн тээврийн хэрэгслээр ачаа ба зорчигч тээвэрлэх, агуулах, ачаа тээшийн болон төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагааны салбарт эхчүүдээс илүү (тус тус 10.4, 11.2, 12.2, 8.6 хувь) ажиллаж байгаа нь онцлог юм. Харин хотын эхчүүд бүх төрлийн бараа бүтээгдэхүүний бөөний болон жижиглэн худалдаа, зочид буудал, зоогийн газарт байр сууц, хоол хүнсээр хангах, үйлчилгээ үзүүлэх, бүх шатны, бүх мэргэжлийн боловсрол олгох болон эрүүл мэндийн хамгаалах, асрах, нийгмийн үйл ажиллагааны салбарт эцгүүдээс олноороо (тус тус 20.2, 7.1, 15.3, 9.3 хувь) ажиллаж байгаа нь хамгийн түгээмэл байна.

Хөдөөд өрх толгойлсон эцгийн  $\frac{3}{4}$ , эхийн  $\frac{1}{2}$  хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарт ажиллаж байгаа нь тэд байгаль, цаг уурын нөхцөлөөс хамаарал бүхий эрсдэлтэй салбарт эдийн засгийн үйл ажиллагаа явуулж байгааг харуулна. Өрх толгойлсон эцгүүд төрийн удирдлага, батлан хамгаалах, цахилгаан эрчим хүч, уур, халуун, хүйтэн усаар хангах үйл ажиллагаа, барилгын салбарт (тус тус 5.8, 1.7, 1.1 хувь) ихээр ажиллаж байхад эхчүүд бөөний болон жижиглэн худалдаа, боловсрол, эрүүл мэндийн салбарт олноороо (тус тус 5.0, 14.9, 6.0 хувь) ажиллаж байна.

Эрхэлдэг ажил мэргэжил, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар нарийвчлан авч үзэхэд өрх толгойлсон эхчүүд эцгүүдтэй харьцуулахад илүү нийгэм, хүмүүнлэгийн болон үйлчилгээний чиглэлийн үйл ажиллагаа, тухайлбал асран хамгаалах, боловсрол олгох, хоол, хүнсээр үйлчлэх, энгийн ажил үйлчилгээ буюу хөдөлмөрийн үнэлгээ бага салбарт ажиллаж байна.

ХҮСНЭГТ 3.9. ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГ ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭЦЭГ, ЭХИЙН ТОО, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАРЫН АНГИЛАЛ, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010 ОН

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Бүгд			Хот			Хөдөө		
	Бүгд	Эцэг	Эх	Бүгд	Эцэг	Эх	Бүгд	Эцэг	Эх
Тоо	35 465	5 601	29 864	25 297	3 450	21 847	10 168	2 151	8 017
Хувь	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	19.0	31.5	16.7	2.7	5.3	2.3	59.7	73.6	56.0
Уул уурхай, олборлолт	2.8	4.9	2.4	3.0	6.8	2.4	2.3	2.0	2.3
Боловсруулах үйлдвэрлэл	7.7	7.1	7.8	9.9	10.4	9.8	2.1	1.9	2.2
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	1.4	2.7	1.1	1.7	3.3	1.5	0.6	1.7	0.3
Усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	1.2	1.5	1.2	1.6	2.2	1.5	0.3	0.4	0.3
Барилга	4.2	7.4	3.6	5.6	11.2	4.7	0.7	1.1	0.6
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	15.0	9.1	16.1	19.3	13.8	20.2	4.3	1.6	5.0
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	4.0	8.1	3.3	5.2	12.2	4.1	1.1	1.6	0.9
Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	5.1	1.6	5.8	6.5	2.3	7.1	1.7	0.3	2.0
Мэдээлэл, холбоо	1.2	1.1	1.2	1.6	1.6	1.6	0.2	0.2	0.2
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1.5	0.9	1.6	1.7	1.3	1.8	0.9	0.4	1.0
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	1.9	1.2	2.0	2.7	2.0	2.8	0.0	0.0	0.0
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	1.3	1.0	1.4	1.4	1.1	1.4	1.0	0.8	1.1
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	1.0	1.7	0.9	1.2	2.6	1.0	0.6	0.4	0.7
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	7.1	7.6	7.1	8.0	8.6	7.9	5.1	5.8	4.9
Боловсрол	13.9	7.2	15.2	14.3	8.1	15.3	13.0	5.7	14.9
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	7.5	2.4	8.4	8.4	2.8	9.3	5.1	1.6	6.0
Урлаг, үзвэр, тоглоом наадам	1.0	0.9	1.0	1.1	1.2	1.1	0.6	0.3	0.7
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	2.6	1.9	2.8	3.5	2.7	3.6	0.5	0.5	0.5
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	0.1	0.0	0.1	0.1	0.0	0.2	0.0	0.0	0.0
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	0.4	0.2	0.4	0.5	0.3	0.5	0.1	0.0	0.1

Өрх толгойлсон эцэг, эхийн 42.3 хувь нь хөдөлмөр эрхэлж, 57.7 хувь нь ажилгүй буюу хөдөлмөрийн зах зээлд ажиллах хүчээ нийлүүлэхгүй байгааг дээр дурдсан. Тиймээс ажил эрхлэхгүй байгаа шалтгааныг сүүлчийн 2 тооллогын дүнгээр ангилж, хүснэгт 3.2.6-д үзүүлэв. Өрх толгойлсон эцэг, эхийн хөдөлмөр эрхлэхгүй байгаа үндсэн шалтгаан өндөр насны тэтгэвэрт гарснаас (55.6 хувь) хамаарч, 2000 оны тооллогын үеийнхээс 8.2 пунктээр буурчээ. Энэ нь тэтгэврийн насны өрх толгойлсон эцэг, эхийн тоо 2000 оноос хойш буурсантай холбоотой юм.

### ХҮСНЭГТ 3.10. ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭЦЭГ, ЭХИЙН ТОО, АЖИЛ ЭРХЛЭХГҮЙ БАЙГАА ШАЛТГААН, ХУВИАР, 2000, 2010 ОН

Ажил эрхлээгүй шалтгаан	2010			2000		
	Бүгд	Эцэг	Эх	Бүгд	Эцэг	Эх
Тоо	48 464	9 170	39 294	39 272	9 456	29 816
Хувь	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Сургуульд сурдаг	0.9	0.5	0.9	0.8	0.5	0.9
Тэтгэвэрт	55.6	57.5	55.2	63.8	68.2	62.4
Хөдөлмөр эрхлэх чадваргүй	7.7	9.4	7.3	6.1	6.8	5.9
Гэрийн ажилтай	9.9	3.4	11.4	7.3	3.0	8.7
Тохирох ажил олдохгүй	11.6	13.9	11.1	7.0	7.6	6.8
Ажил хайж байгаа	10.8	11.3	10.7	11.9	10.9	12.3
Ажиллах сонирхолгүй	0.3	0.4	0.2	-	-	-
Бусад	3.3	3.6	3.2	3.1	3.0	3.1

Ажил эрхлэхгүй байгаа шалтгааныг ангилж үзэхэд хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнээ асрах, хоол унд, гэр орны ажил хийдгээсээ болж хөдөлмөрийн хүчээ зах зээлд нийлүүлж чадахгүй байгаа эхчүүдийн хувийн жин ихээхэн өссөн (2000 онд 8.7 хувь, 2010 онд 11.4 хувь) дүн гарлаа. Тохирох ажил олдохгүйн улмаас ажилгүй байгаа гэж хариулсан өрх толгойлсон эцэг, эхийн хувь өмнөх тооллогын үеэс 2/3 дахин нэмэгдсэн нь бусад шалтгаанаас онцлог байна. Тиймээс өрх толгойлсон эцэг, эх, ялангуяа эхчүүдийн ажилгүйдлийг бууруулахын тулд цэцэрлэг, ясли, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асрах үйлчилгээг хүртээмжтэй болгож, тохирох ажил олдохгүй байгаа шалтгааныг нарийвчлан судалж, мэргэжил дээшлүүлэх сургалт, давтан сургалтад хамруулсны үндсэн дээр хөдөлмөрийн зах зээлд оролцох боломжийг бүрдүүлэх шаардлагатай.

**ХҮСНЭГТ 3.11. ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭЦЭГ, ЭХИЙН ТОО, СУУЦНЫ ЭЗЭМШЛИЙН ХЭЛБЭР, СУУЦНЫ ТӨРӨЛ, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010 ОН**

Эзэмшлийн хэлбэр	Бүгд			Гэр			Байшин			Зориулалтын бус сууц, бусад		
	Бүгд	Эцэг	Эх	Бүгд	Эцэг	Эх	Бүгд	Эцэг	Эх	Бүгд	Эцэг	Эх
<b>УЛСЫН ДҮН</b>												
Тоо	83 929	14 771	69 158	37 182	6 882	30 300	45 581	7 735	37 846	1 166	154	1 012
Хувь	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Өөрийн эзэмшлийн	86.1	89.6	85.4	91.6	93.4	91.2	83.0	87.3	82.1	32.9	39.6	31.9
Бусдын сууцанд түрээстэй суудаг	6.1	4.1	6.5	2.2	1.5	2.4	8.7	5.9	9.2	26.7	24.0	27.1
Бусдын сууцанд түрээсгүй суудаг	6.9	5.6	7.2	5.6	4.5	5.8	7.5	6.2	7.8	24.4	20.1	25.0
Бусад	0.9	0.7	1.0	0.6	0.6	0.6	0.8	0.6	0.9	16.0	16.2	16.0
<b>ХОТ</b>												
Тоо	60 381	9 942	50 439	21 005	3 511	17 494	38 381	6 308	32 073	995	123	872
Хувь	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Өөрийн эзэмшлийн	84.1	87.6	83.4	88.9	91.1	88.5	82.8	86.7	82.0	30.6	34.1	30.0
Бусдын сууцанд түрээстэй суудаг	7.7	5.5	8.2	3.6	2.5	3.8	9.4	6.7	10.0	27.8	28.5	27.8
Бусдын сууцанд түрээсгүй суудаг	7.2	6.0	7.5	6.7	5.5	6.9	7.1	6.0	7.3	24.3	19.5	25.0
Бусад	1.0	0.9	1.0	0.7	0.9	0.7	0.7	0.6	0.7	17.3	17.9	17.2
<b>ХӨДӨӨ</b>												
Тоо	23 548	4 829	18 719	16 177	3 371	12 806	7 200	1 427	5 773	171	31	140
Хувь	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Өөрийн эзэмшлийн	91.3	93.8	90.7	95.1	95.8	94.9	84.0	89.8	82.6	46.8	61.3	43.6
Бусдын сууцанд түрээстэй суудаг	1.8	1.1	2.0	0.4	0.5	0.4	4.5	2.5	5.0	19.9	6.5	22.9
Бусдын сууцанд түрээсгүй суудаг	6.1	4.7	6.5	4.1	3.5	4.3	10.1	7.1	10.9	24.6	22.6	25.0
Бусад	0.8	0.4	0.9	0.4	0.2	0.4	1.4	0.6	1.6	8.8	9.7	8.6

Өөрийн эзэмшлийн сууцгүй эмэгтэй тэргүүлэгчтэй өрх эрэгтэй тэргүүлэгчтэй өрхтэй харьцуулахад их байсантай адилаар өрх толгойлсон эхчүүд бусдын сууцанд амьдрах явдал илүү байна. Улсын хэмжээнд өөрийн эзэмшлийн сууцгүй 10.1 мянган өрх толгойлсон эх байгаа нь нийт өрх толгойлсон эхчүүдийн 14.6 хувь юм. Энэ үзүүлэлт өрх толгойлсон эцгүүдийн хувьд 10.4 хувь байна. Гэрт амьдардаг өрх толгойлсон эцэг, эхийн 90-ээс дээш хувь өөрийн эзэмшлийн сууцтай бол байшинд энэ хувь 82-87 байна.

## ДҮГНЭЛТ

Монгол Улсад эрэгтэй тэргүүлэгчтэй өрх 560.2 мянгад хүрч, өмнөх тооллогын үеийнхээс 23.8 хувиар, эмэгтэй тэргүүлэгчтэй өрх 153.6 мянга болж  $\frac{3}{4}$ -аар нэмэгдэв. Ганц бие эмэгтэйчүүд 2.4 дахин өссөн нь эмэгтэй тэргүүлэгчтэй өрх нэмэгдэхэд голлон нөлөөлжээ. Үүний шалтгаан нь салалттай холбоотой бөгөөд сүүлчийн 11 орчим жилийн хугацаанд 45-54 насны хосын дунд салалт бараг 4 дахин өссөн байна.

Эрэгтэй, эмэгтэйчүүдийн эзэмшсэн боловсролын ялгаа өрхийн түвшинд ч тодорхой илрэх болов. Өөрөөр хэлбэл, нөхрийн боловсролын түвшин эхнэрээсээ бага байх хандлага хоёр тооллогын дүнгээс харагдсаны дээр 2010 онд уг ялгаа улам нэмэгджээ. Эхнэр, нөхрийн боловсролын түвшний ялгаа салалт нэмэгдэхэд нөлөөлсөн эсэхийг цаашид нарийвчлан судлах нь зүйтэй юм.

Эхнэр, нөхөр хоёулаа хөдөлмөр эрхэлж байгаа байдал эрэгтэй тэргүүлэгчтэй өрхөд 68.8 хувь болж, 2000 оны түвшнээс 3.6 пунктээр буурсан бол эмэгтэй тэргүүлэгчтэй өрхөд 68.1 хувь болж, 3.5 пунктээр өсчээ. Харин эхнэр, нөхөр хоёулаа ажилгүй байх хандлага өмнөх тооллогын үеийнхээс буурсны дотор эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн хувьд илүү ихээр багасав. Энэ нь өрхийн түвшинд гэрийн эзэгтэй нарын эдийн засгийн идэвх буурсныг харуулна.

Улсын хэмжээнд эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн 18.3 хувь буюу 28.1 мянган өрх өөрийн гэсэн сууцгүй байгаа нь эрэгтэй тэргүүлэгчтэй өрхтэй харьцуулахад 6.4 пунктээр илүү үзүүлэлт юм. Байршлаар нь авч үзвэл хотод өөрийн эзэмшлийн сууцтай өрх хөдөөтэй харьцуулахад бага бөгөөд хотын эмэгтэй тэргүүлэгчтэй 10 өрх тутмын нэг нь байр түрээслэн амьдарч байна.

Өрх толгойлсон эцэг, эхийн тоо 83.9 мянга болж, 2000 оны тооллогын үеийнхээс 22.5 хувиар нэмэгдсэний дотор өрх толгойлсон эхийн тоо 31 хувиар өссөн бол өрх толгойлсон эцгийн тоо 5.9 хувиар буурчээ. Өрх толгойлсон эцэг, эхийн 17.6 хувь нь эрэгтэйчүүд, 82.4 хувь нь эмэгтэйчүүд юм.

Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогоор өрх толгойлсон эхэд дунджаар 2.3 хүүхэд, эцэгт 2.1 хүүхэд ногдож байсан бол 2010 онд тус тус 1.8, 1.7 болж буурав. Гэсэн хэдий ч эхчүүд илүү олон хүүхэд асарч, тэжээж байна.

Боловсролтой өрх толгойлсон эцэг, эхийн хувийн жин тооллого хооронд өссөн боловч боловсролын түвшин дэх хүйсийн харьцаа буурсан нь өрх толгойлсон эцгийн боловсрол эхтэй харьцуулахад доогуур түвшинд байгааг харуулна. Ялангуяа, дээд боловсролд энэ ялгаа илүү нэмэгджээ.

Өрх толгойлсон эцгийн хөдөлмөр эрхлэлт эхтэй харьцуулахад бага бөгөөд хот, хөдөөгөөр авч үзвэл хотод ажилгүй эцгүүд олон байна. Эдийн засгийн үйл ажиллагаанд өрх толгойлсон эцгийн оролцоо бага байгаа нь тэдний насны бүтэц болон боловсролын түвшинтэй холбоотой юм.

# ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ХҮН АМЫН ДОТООД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН ДЭХ  
ЖЕНДЕРИЙН ЯЛГААТАЙ БАЙДАЛ



## ХҮН АМЫН ДОТООД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН ДЭХ ЖЕНДЕРИЙН ЯЛГААТАЙ БАЙДАЛ

Шилжих хөдөлгөөн болон жендер нь харилцан бие биедээ нөлөөлж байдаг ойлголт юм. Дэлхий нийтэд гадаад шилжих хөдөлгөөн болон жендерийн талаар илүү өргөн хүрээнд судалж үздэг бол хөгжиж байгаа орнууд, тэр дундаа Азийн орнуудад жендер болон дотоод шилжих хөдөлгөөний талаар мэдээлэл сайтай байдаг. Монгол Улс 2000 оны тооллогоор дотоод шилжих хөдөлгөөний мэлээллийг анх удаа үндэсний хэмжээнд хүйсээр ангилан харуулсан.

Энэ бүлэгт дотоод шилжих хөдөлгөөнд эрэгтэй, эмэгтэй хүмүүс оролцсоноор шилжин явсан болон шилжин очсон газар нутагт хэрхэн нөлөөлж байгаа, шилжих хөдөлгөөний хугацаанаас хамаарч жендерийн ялгаа үүсч байгаа эсэхийг харуулахыг зорив.

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын дүнгээр төрснөөс хойш шилжигчдийн тоо өмнөх 2000 онтой харьцуулахад 1.8 дахин нэмэгджээ. (Үүнд өөр газар амьдарч байгаад буцаж ирсэн хүмүүсийг тодотгож оруулсан нь нөлөөлсөн ч байж болзошгүй). Хүйсээр авч үзвэл энэ хугацаанд эрэгтэй шилжигчдийн тоо 1.77 дахин өссөн бол эмэгтэй нь 1.83 дахин нэмэгдэв.

Шилжих хөдөлгөөнд эрэгтэйчүүд оролцдог гэсэн уламжлалт ойлголт байдаг хэдий ч сүүлчийн үед эмэгтэйчүүдийн шилжилт эрчимтэй нэмэгдэн нийт шилжигчдийн бараг тал хувийг бүрдүүлдэг болсон (*UN, Women and Migration, Sec1, P4*). 2000 оны тооллогын дүнгээр төрснөөс хойш шилжих хөдөлгөөнд оролцсон хүн амын 47.7 хувийг эмэгтэйчүүд эзэлж байсан нь 2010 онд 48.5 хувь болж, бага зэрэг өссөн бол тэдний хүйсийн харьцаа 110-аас 106 болж буурсан. Энэ нь манай оронд шилжих хөдөлгөөнд эрэгтэйчүүд түлхүү оролцож байгааг илтгэхийн зэрэгцээ сүүлчийн үед эмэгтэйчүүдийн шилжилт нэмэгдэж байгааг харуулна.

ЗУРАГ 4.1. ШИЛЖИГЧДИЙН ТОО, ХҮЙСИЙН ХАРЬЦАА, ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦСОН ХУГАЦАА, МЯНГАН ХҮНЭЭР, 2000, 2010 ОН



## ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН БА ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТ

Шилжигчдийн хүйсийн харьцаа шилжих хөдөлгөөнд оролцсон буюу тоолох үед амьдарч байгаа нутагтаа оршин суусан хугацаанаас хамаарч харилцан адилгүй байна. Шилжих хөдөлгөөнд орох болсон зорилго, шалтгаан зэрэг нь шилжин суурьших хугацаатай хамааралтай байдаг. Тооллогын дүнгээс харахад тухайн нутагт 1-ээс цөөн болон 4-өөс дээш жил болсон шилжигчдэд эрэгтэйчүүд, 1-4 жил болсон шилжигчдэд эмэгтэйчүүд давамгайлах хандлагатай байна. Энэ нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн шилжилтийн зорилго, шалтгаан харилцан адилгүй байгаатай холбоотой.

### ХҮСНЭГТ 4.1. ХҮН АМЫН ТОО, ХҮЙСИЙН ХАРЬЦАА, ТУХАЙН ГАЗАРТ СУУСАН ХУГАЦААГААР, 2000, 2010 ОН


МЯН.ХҮН

Тухайн газарт суусан хугацаа	2000				2010				2010/2000		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
<b>БҮГД</b>	<b>2 373.5</b>	<b>1 178.0</b>	<b>1 195.5</b>	<b>98.5</b>	<b>2 647.5</b>	<b>1 314.0</b>	<b>1 333.6</b>	<b>98.5</b>	<b>1.1</b>	<b>1.1</b>	<b>1.1</b>
Төрснөөс хойш	1 762.8	858.7	904.2	95.0	1 550.0	749.2	800.7	93.6	0.9	0.9	0.9
Шилжиж ирсэн	610.7	319.3	291.3	109.6	1 097.6	564.7	532.9	106.0	1.8	1.8	1.8
1 жил хүртэл*	79.0	42.9	36.1	118.8	114.2	61.0	53.2	114.8	1.4	1.4	1.5
1-4 жил	132.1	65.8	66.2	99.4	227.5	111.8	115.7	96.6	1.7	1.7	1.7
5-9 жил	99.0	51.2	47.9	106.9	213.7	108.7	105.0	103.5	2.2	2.1	2.2
10, түүнээс дээш жил	300.6	159.5	141.2	112.9	542.2	283.3	259.0	109.4	1.8	1.8	1.8

\* Тооллогын тов 2010 оны 11 дүгээр сард байсан

Шилжигч болон шилжигч бус хүн амын нас, хүйсийн бүтэц, гарч байгаа өөрчлөлт хүн амын суваргаас илүү тодорхой харагдана. Төрснөөс хойш шилжээгүй хүн амын суварга баруун, шилжсэн хүн амын суварга зүүн тал руугаа, ялангуяа 30-54 насанд бага зэрэг цүлхийсэн байгаа нь энэ насны бүлэгт эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс бага шилждэг болохыг харуулж байна.


### ЗУРАГ 4.2. ШИЛЖИГЧ, ШИЛЖИГЧ БУС ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, МЯНГАН ХҮНЭЭР, 2000, 2010 ОН



Төрснөөс хойш шилжих хөдөлгөөнд оролцсон хүн амын хувьд 2000 онд 20-39 насны хүн ам давамгайлж байсан бол 2010 онд 20-29 насны залуучууд давамгайлах болжээ. Энэ нь шилжигчдийн нас эрс залуужиж байгааг илэрхийлнэ. Сүүлчийн хоёр тооллогын хооронд шилжигчдийн насны бүтцэд хүйсээс хамааран харилцан адилгүй өөрчлөлт орсон байна. Тухайлбал, 15-24 насанд эмэгтэйчүүдийн шилжилт нэмэгдсэн бол 40-49 насанд эрэгтэйчүүдийнх нэмэгдэв.

Шилжигч болон шилжигч бус хүн амын насны бүлэг дэх хүйсийн харьцааг тооллого хоорондын хугацаанд харьцуулан үзэх нь өөрчлөлтийг илүү тод харуулна. Нийт хүн амын хувьд тодорхой харагдаж байсанчлан 55-64 насны шилжигч болон шилжигч бус хүн амын хүйсийн харьцаа эрс буурчээ. Тэр дундаа, төрснөөс хойш шилжээгүй хүн амын хувьд хүйсийн харьцаа 20-30 пунктээр буурав.

ЗУРАГ 4.3. ШИЛЖИГЧ, ШИЛЖИГЧ БУС ХҮН АМЫН НАСНЫ БҮЛЭГ ДЭХ ХҮЙСИЙН ХАРЬЦАА, 2000, 2010 ОН



Шилжигчдийн насны бүлэг дэх хүйсийн харьцаа шилжих хөдөлгөөнд оролцсон хугацаа тус бүрт харилцан адилгүй юм. Сүүлчийн нэг жилд шилжигчдийн хувьд 15-24 насанд эмэгтэйчүүдийн шилжилт, 35-54 насанд эрэгтэйчүүдийн шилжилт нэмэгджээ.

ХҮСНЭГТ 4.2. ШИЛЖИГЧДИЙН НАСНЫ БҮЛЭГ ДЭХ ХҮЙСИЙН ХАРЬЦАА, ТУХАЙН ГАЗАРТ СУУСАН ХУГАЦААГААР, 2000, 2010 ОН

Тухайн газарт суусан хугацаа	Он	Бүгд	0-4	5-9	10-14	15-19	20-24	25-29	30-34	35-39	40-44	45-49	50-54	55-59	60-64	65+
1 жил хүртэл	2010	114.8	103.4	101.3	106.0	86.9	106.1	132.8	115.6	172.9	190.7	168.9	133.9	104.8	98.5	60.7
	2000	118.8	101.0	99.6	97.0	128.3	151.9	114.3	119.7	124.4	126.9	122.0	105.0	101.4	90.4	64.3
1-4 жил	2010	96.6	103.6	102.6	100.4	81.1	96.8	92.0	106.3	111.6	106.0	108.5	102.6	88.9	84.1	73.7
	2000	99.4	101.4	99.3	101.1	73.2	103.3	108.1	104.1	107.6	114.5	115.5	114.4	108.4	106.6	68.4
5-9 жил	2010	103.5	-	103.8	99.6	106.2	104.5	122.2	98.2	98.3	102.0	100.7	95.6	94.2	72.7	72.2
	2000	106.9	-	97.2	98.6	99.5	82.7	132.7	112.5	101.7	109.6	117.5	106.4	100.6	96.8	72.6
10, түүнээс дээш жил	2010	109.4	-	-	102.6	100.2	98.9	96.4	116.4	114.3	120.4	115.2	113.8	110.9	104.0	94.6
	2000	112.9	-	-	102.3	102.4	104.2	96.2	119.6	114.8	119.1	116.7	115.0	125.0	123.5	95.4

Шилжигч болон шилжигч бус хүн амын хувийн жинг 0-14, 15-64, 65-аас дээш гэсэн үндсэн насны бүлгээр авч үзвэл тооллого хооронд хөдөлмөрийн насны хүн амын шилжилт нэмэгдэж, хүүхдийн шилжилт буурчээ. Хүүхэд болон өндөр настнууд төдийлөн бие даан шилжилт хийдэггүй тул энэ нь ганцаарчилсан шилжилт нэмэгдэж байгааг харуулна.

ЗУРАГ 4.4. ШИЛЖИГЧ, ШИЛЖИГЧ БУС ХҮН АМЫН ХУВЬ,  
НАСНЫ БҮЛГЭЭР, 2000, 2010 ОН




### ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН, ХОТ, ХӨДӨӨ ДЭХ ЖЕНДЕРИЙН ЯЛГААТАЙ БАЙДАЛ

Шилжих хөдөлгөөн нь тухайн улс орон, нутаг дэвсгэр дэх хүн амын нас хүйсийн бүтцэд өөрчлөлт оруулдаг хүчин зүйлсийн нэг юм. Дотоод шилжих хөдөлгөөн нь голдуу хөдөөнөөс хот руу чиглэсэн урсгалтай байдаг тул хотын хүн амын нас, хүйсийн бүтцэд хөдөөнөөс шилжин суурьшсан хүн ам нөлөөлдөг.

Манай орны хувьд хот, хөдөөгийн хүн амын хүйсийн харьцаа нэлээд ялгаатай байдаг. Энэ ялгаа тооллого хоорондын хугацаанд улам нэмэгдэж, 14 пунктын зөрүүтэй болов. Тухайлбал, хотод эмэгтэйчүүд давамгайлдаг байдал нэмэгдэж, хүйсийн харьцаа 94 болсон ба хотын хүн амын хүйсийн харьцаа шилжих хөдөлгөөнд орсон эсэхээс хамаарахгүйгээр ойролцоо түвшинд байна.


ЗУРАГ 4.5. ХОТ, ХӨДӨӨГИЙН ХҮН АМЫН ХҮЙСИЙН ХАРЬЦАА,  
ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦСОН БАЙДЛААР, 2000, 2010 ОН



Харин тоолох үед хөдөө амьдарч байсан, шилжих хөдөлгөөнд оролцсон хүн амын хүйсийн харьцаа өмнөх үеийнхээс 10 пунктээр нэмэгдсэн бол сүүлчийн нэг жилд шилжигчдийн хувьд 15 пунктээр өсчээ. Энэ нь хөдөөд эрэгтэйчүүдийн шилжилт эрс нэмэгдэж байгааг харуулна. Тодруулбал, хөдөөгийн эрэгтэйчүүд сүүлчийн нэг жилд эмэгтэйчүүдээсээ 2 дахин их шилжсэн гэсэн үг юм.

Хот, хөдөөгийн шилжигч болон шилжигч бус хүн амын нас, хүйсийн бүтцийг 2010 оны үр дүнгээс харвал хотод 20-иос дээш насанд шилжигч хүн ам нь шилжигч бус хүн амаасаа илүү байна. Харин хөдөөд шилжээгүй эмэгтэйчүүд бүх насны бүлэгт шилжсэнээсээ олон байгаа бол 35-64 насны эрэгтэйчүүд илүү ихээр шилжих хөдөлгөөнд оролцжээ.


ЗУРАГ 4.6. ХОТ, ХӨДӨӨГИЙН ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, ТӨРСНӨӨС ХОЙШ ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНД ОРСОН ЭСЭХЭЭР, 2010 ОН



Сүүлчийн нэг жилд шилжсэн эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс аль насны бүлэгт илүү зөрүүтэй байгааг хот, хөдөөгөөр ангилан авч үзвэл хотод 15-24 насны эмэгтэйчүүд илүү их шилжих хөдөлгөөнд оролцсон байна. Энэ нь хөдөөнөөс хот руу залуу эмэгтэйчүүд шилжиж байгааг илэрхийлнэ. Харин хөдөөд бүх насны эрэгтэйчүүдийн шилжилт эмэгтэйчүүдээс илүү байна. Дотоод шилжих хөдөлгөөн голдуу сайн дурын үндсэн дээр хийгддэг бөгөөд гол шалтгаан нь сурч боловсрох, ажил хөдөлмөр эрхлэх зэрэг амьдралын нөхцөл боломжоо сайжруулахад чиглэсэн байдаг.

Манайд хотжилт эрчимтэй явагдаж байгаатай холбоотойгоор хотод үйлчилгээний салбар илүү хөгжиж байгаагаас залуу эмэгтэйчүүдийг хот руу, уул уурхай, газар тариалан хөгжиж, энэ төрлийн ажлын байр нэмэгдэж байгаа нь эрэгтэйчүүдийг хөдөө рүү шилжихэд нөлөөлж байгаа болов уу.


ЗУРАГ 4.7. СҮҮЛЧИЙН 1 ЖИЛД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНД ОРСОН ХОТ, ХӨДӨӨГИЙН ЭРЭГТЭЙ, ЭМЭГТЭЙ ХҮНИЙ ТООНЫ ЗӨРҮҮ, НАСНЫ БҮЛГЭЭР, 2010 ОН



Зарим судлаачид дотоод шилжих хөдөлгөөн нь гадаад шилжих хөдөлгөөний тусгал болдог гэж үздэг (Bridge, Gender and Migration, Sec3, P1). Өөрөөр хэлбэл, гадагшаа эмэгтэйчүүд их шилжвэл хөдөөнөөс хот руу эмэгтэйчүүд шилжих хандлагатай байдаг. Энэ удаагийн тооллогын дүнгээр гадаад шилжих хөдөлгөөний талаар тодорхой мэдээлэл цуглуулсан бөгөөд гадагшаа эмэгтэйчүүд илүү шилжсэн байв. Үүнтэй холбоотойгоор хотод залуу охид болон нас ахисан эмэгтэйчүүд илүү шилжин ирсэн байж болзошгүй юм. Учир нь гадагш шилжсэн эмэгтэйчүүдийн наад зах нь гэрийн ажил, хүүхэд асрах үүргийг хэн нэг нь зайлшгүй гүйцэтгэх шаардлагатай болно.

Сүүлчийн 5 жилд шилжих хөдөлгөөнд оролцсон хүн амын байршлыг авч үзвэл нийслэлд эмэгтэйчүүд дийлэнх байна. Харин сумын төв, хөдөөд эрэгтэйчүүд давамгайлж байна.

ЗУРАГ 4.8. СҮҮЛЧИЙН 5 ЖИЛД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНД ОРСОН ЭРЭГТЭЙ, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХАМГИЙН СҮҮЛД ШИЛЖИН СУУРЬШСАН БАЙРШИЛ, ХУВИАР, 2010 ОН



Тухайн аймаг, нийслэлд төрсөн болон одоо амьдарч байгаа (тоолох үед) хүн амын зөрүүгээр шилжих хөдөлгөөнийг тодорхойлдог. Тиймээс уг мэдээллийг ашиглан шилжих хөдөлгөөнд оролцсон хүн амын хүйсийн харьцаа тухайн орон нутгийн хүн амын хүйсийн харьцаанд ямар өөрчлөлт оруулж байгааг харуулахыг зорилго.

Тооллого хооронд тухайн аймаг, нийслэлд төрсөн хүн амын хүйсийн харьцаа харьцангуй тогтвортой байсан бол одоо амьдарч байгаа хүн амын хүйсийн харьцаанд нэлээд хэмжээний өөрчлөлт орсон нь шилжих хөдөлгөөний нөлөөлөл их байгааг харуулна. Төрсөн болон одоо амьдарч байгаа хүн амын хүйсийн харьцаа аймаг тус бүрт харилцан адилгүй байгаа ба зөрүү нь тооллого хоорондын хугацаанд улам нэмэгджээ. Өмнөх тооллогоор Төв аймагт төрсөн болон одоо амьдарч байгаа хүн амын хүйсийн харьцаа хамгийн их буюу 8.4 пунктийн зөрүүтэй байсан бол 2010 онд Өмнөговь аймагт уг зөрүү 35.4 пункт байна.

#### ХҮСНЭГТ 4.3. ТУХАЙН АЙМАГ, НИЙСЛЭЛД ТӨРСӨН БОЛОН ОДОО АМЬДАРЧ БАЙГАА ХҮН АМЫН ХҮЙСИЙН ХАРЬЦАА, ТӨРСНӨӨС ХОЙШ ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНД ОРСОН ЭСЭХЭЭР, 2000, 2010 ОН


Аймаг, нийслэл	2010					2000				
	Төрсөн		Одоо амьдарч байгаа		Шилжээ-гүй	Төрсөн		Одоо амьдарч байгаа		Шилжээ-гүй
	Нийт	Шилжсэн	Нийт	Шилжсэн		Нийт	Шилжсэн	Нийт	Шилжсэн	
<b>БҮГД</b>	<b>98.5</b>	<b>106.0</b>	<b>98.5</b>	<b>106.0</b>	<b>93.6</b>	<b>98.5</b>	<b>109.6</b>	<b>98.5</b>	<b>109.6</b>	<b>95.0</b>
Архангай	95.9	105.5	99.5	172.4	86.1	98.8	94.0	100.1	75.1	100.9
Баян-Өлгий	98.9	119.6	100.2	155.9	92.3	100.7	97.4	101.2	106.2	101.1
Баянхонгор	97.7	119.6	100.9	223.4	78.8	98.7	99.7	98.4	90.0	98.4
Булган	97.7	101.4	106.2	133.6	92.8	98.0	97.8	101.7	119.0	98.0
Говь-Алтай	96.1	105.2	99.9	164.8	83.0	96.6	93.6	97.9	74.5	98.3
Дорноговь	95.9	106.9	101.8	126.7	87.8	97.0	117.5	101.8	142.5	87.1
Дорнод	96.8	92.8	102.1	117.3	99.3	97.0	105.2	99.7	132.0	94.9
Дундговь	98.2	112.3	103.2	217.4	81.3	99.3	97.5	99.7	95.9	99.8
Завхан	96.8	104.6	100.5	189.4	84.7	99.7	129.8	100.1	305.3	80.8
Өвөрхангай	97.0	109.5	100.4	168.1	87.2	98.8	101.9	99.5	125.4	97.8
Өмнөговь	98.9	109.4	134.3	245.5	92.2	97.7	127.0	100.5	181.6	87.6
Сүхбаатар	97.0	106.2	104.1	160.4	87.3	98.8	117.8	103.6	182.8	88.7
Сэлэнгэ	98.6	87.7	103.6	97.0	110.3	99.3	87.4	104.5	106.2	103.5
Төв	97.7	93.4	109.1	115.4	104.6	98.8	109.7	107.3	139.8	91.1
Увс	98.0	110.1	102.1	195.3	81.7	100.1	130.8	102.2	240.0	80.2
Ховд	97.1	104.7	99.4	146.3	90.1	98.9	124.2	99.1	171.3	86.1
Хөвсгөл	95.5	101.3	99.1	146.0	92.1	97.2	105.6	98.4	157.5	94.9
Хэнтий	97.3	108.4	104.6	147.1	86.6	98.5	113.0	101.0	134.9	93.2
Дархан-Уул	101.8	95.9	96.7	90.7	106.6	101.4	98.2	96.3	91.3	102.3
Улаанбаатар	99.5	105.3	93.7	89.3	98.8	97.5	104.8	94.4	90.4	96.9
Орхон	102.1	93.3	96.6	92.4	107.4	100.0	91.7	97.6	95.8	101.9
Говьсүмбэр	102.1	96.9	106.3	106.4	106.1	96.8	99.8	101.6	104.8	95.6
Гадаадад	221.3	221.3	-	-	-	125.4	125.4	-	-	-

Энэ нь Өмнөговь аймагт эрэгтэйчүүд олноор шилжин очиж байгааг харуулна. Тодруулбал, тус аймагт 2010 онд амьдарч байсан шилжин суурьшигчдын хүйсийн харьцаа 246 байв.

Ерөнхийдөө уул уурхай, газар тариалан идэвхтэй хөгжиж байгаа аймаг, бүс нутагт эрэгтэйчүүд олноор шилжин суурьшиж байгаа бол Улаанбаатар хот, Дархан-Уул болон Орхон зэрэг томоохон аймгуудад эмэгтэйчүүд түлхүү шилжин очиж байна. Үүнээс гадна өмнөх тооллоготой харьцуулахад Монгол Улсад тоологдсон гадаадын харьяат иргэдийн хүйсийн харьцаа 221 болсон нь анхаарал татаж байна.

Тухайн аймаг, нийслэлд төрсөн болон амьдарч байгаа хүн амын зэрэгцүүлсэн жендерийн спиралийг 2 тооллогын дүнгээр харьцуулан харууллаа. Эндээс тооллого хоорондын хугацаанд суурин байгаа эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээсээ илүү аймгийн тоо эрс нэмэгдсэн, хот сууринд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү олон болсон нь тодорхой харагдана.

**ЗУРАГ 4.9. ТУХАЙН АЙМАГ, НИЙСЛЭЛД ТӨРСӨН БОЛОН ОДОО АМЬДАРЧ БАЙГАА ЭРЭГТЭЙ, ЭМЭГТЭЙ ХҮНИЙ ТООНЫ ЗӨРҮҮ, 2000, 2010 ОН**



### ШИЛЖИГЧ, ШИЛЖИГЧ БУС ХҮН АМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ ДАХЬ ЖЕНДЕРИЙН ЯЛГАА

Хүн амын гэрлэлт, боловсрол, ажил эрхлэлт зэрэг нийгэм, эдийн засгийн байдалд жендерийн ялгаа их байдаг. Тэгвэл шилжих хөдөлгөөнд оролцсон эсэх, хэзээ шилжсэн зэргээс хамаарч жендерийн ялгаа манай оронд ямар түвшинд байгааг тооллогын мэдээллээс харах боломжтой. Түүнчлэн, энэ удаагийн тооллогоор гар утас, интернетийн хэрэглээ, хөгжлийн бэрхшээлийн талаарх үзүүлэлтийг шинээр цуглуулсан.

Монгол Улсад эмэгтэйчүүдийн боловсролын түвшин эрэгтэйчүүдээс өндөр байдаг. Шилжих хөдөлгөөнд оролцоогүй дээд (магистр, доктор, бакалавр) боловсролтой хүн амын хүйсийн харьцаа төрснөөс хойш шилжих хөдөлгөөнд оролцсон дээд боловсролтой хүн амын хүйсийн харьцаанаас доогуур түвшинд байна.

Харин тоологдсон газраа 1-4 жил амьдарч байгаа магистр болон бакалавр зэрэгтэй дээд боловсролтой хүн амын хүйсийн харьцаа харгалзан 76, 66 байхад 1 хүртэл жил болсон хүн амын хувьд уг харьцаа 99, 83 байна. Түүнчлэн, шилжих хөдөлгөөнд оролцсон хугацаа багасах тутам боловсролгүй хүн амын хүйсийн харьцаа буурч, 100 руу дөхөж байгаа нь огт боловсролгүй эрэгтэйчүүд шилжих хөдөлгөөнд бага оролцож байгааг харуулна.

#### ХҮСНЭГТ 4.4. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ХҮЙСИЙН ХАРЬЦАА, БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНД ОРСОН ЭСЭХЭЭР, 2010 ОН

Тухайн газарт суусан хугацаа	Боловсролын түвшин									
	Бүгд	Доктор	Магистр	Бакалавр	Тусгай мэргэжлийн дунд	Техникийн болон мэргэжлийн	Бүрэн дунд	Суурь	Бага	Боловсролгүй
<b>БҮГД</b>	<b>97.9</b>	<b>142.5</b>	<b>67.0</b>	<b>70.3</b>	<b>64.8</b>	<b>115.1</b>	<b>98.4</b>	<b>126.4</b>	<b>107.8</b>	<b>108.1</b>
Төрснөөс хойш	91.3	70.9	57.6	65.9	69.0	99.2	88.3	97.3	96.4	103.9
Шилжиж ирсэн	106.0	188.7	72.6	72.6	63.0	128.1	107.7	191.0	141.6	128.8
1 жил хүртэл	116.1	116.0	99.2	83.2	107.4	194.0	111.4	193.8	130.0	114.7
1-4 жил	96.2	171.6	76.0	66.4	83.0	140.6	93.1	157.8	132.5	123.3
5-9 жил	103.4	147.1	61.5	64.2	67.7	137.8	109.3	162.7	136.2	128.6
10, түүнээс дээш жил	109.4	201.8	73.0	77.5	57.7	120.2	114.4	213.1	149.6	143.2


Шилжих хөдөлгөөнд гэр бүлгүй эмэгтэйчүүд олноороо оролцдог бол гэр бүлтэй эмэгтэйчүүд төрсөн нутагтаа суух магадлал өндөр байна. Харин гэр бүлтэй эрэгтэйчүүд гэр бүлгүй эрэгтэйчүүдтэй харьцуулахад шилжилтэд илүү оролцдог болох нь ажиглагдав.

#### ХҮСНЭГТ 4.5. АРВАН ТАВ. ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ХҮЙСИЙН ХАРЬЦАА, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ, ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНД ОРСОН ЭСЭХЭЭР, 2010 ОН

Тухайн газарт суусан хугацаа	Гэр бүлийн байдал						
	Бүгд	Огт гэр бүл болоогүй	Батлуулсан гэр бүлтэй	Батлуулаагүй гэр бүлтэй	Тусгаарласан	Цуцалсан	Бэлбэсэн
<b>БҮГД</b>	<b>96.8</b>	<b>117.9</b>	<b>99.5</b>	<b>92.8</b>	<b>76.1</b>	<b>73.3</b>	<b>24.6</b>
Төрснөөс хойш	87.2	121.8	78.6	80.7	72.7	71.0	18.9
Шилжиж ирсэн	106.4	113.1	119.6	102.8	78.8	75.3	29.5
1 жил хүртэл	117.2	114.2	141.8	99.9	100.9	90.2	26.1
1-4 жил	95.6	103.1	95.7	96.9	72.4	70.3	24.5
5-9 жил	103.8	121.7	105.2	105.3	74.3	69.5	23.8
10, түүнээс дээш жил	109.5	117.9	128.9	104.7	79.7	76.4	31.1


Эдийн засгийн идэвхийн хувьд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү идэвхтэй байдаг. Шилжих хөдөлгөөнд оролцсон эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс эдийн засгийн идэвх өндөртэй юм. Шилжих хөдөлгөөнд ороод 5 хүртэл жил болсон эмэгтэйчүүдийн дийлэнх нь эдийн засгийн идэвхгүй байгаа бол 1 жил болоогүй эмэгтэйчүүдийн 61 хувь нь эдийн засгийн идэвхгүй ажээ.

ЗУРАГ 4.10. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХ, ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНД ОРСОН ЭСЭХ, ХҮЙС, ХУВИАР, 2010 ОН




Эдийн засгийн идэвхгүй хүн амын хөдөлмөр эрхлэхгүй байгаа шалтгаан нь хүйсээр ялгаатай байна. Тухайлбал, эрэгтэйчүүд сургуульд сурдаг, тохирох ажил олдохгүй байгаа, хөдөлмөр эрхлэх чадваргүй гэсэн шалтгааныг эмэгтэйчүүдтэй харьцуулахад илүү нэрлэсэн бол эмэгтэйчүүд тэтгэвэрт, гэрийн ажилтай гэсэн шалтгаанаар хөдөлмөрийн зах зээлд оролцож чадахгүй байна.

ЗУРАГ 4.11. ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХГҮЙ ХҮН АМЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХГҮЙ БАЙГАА ШАЛТГААН, ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНД ОРСОН ЭСЭХ, ХҮЙС, ХУВИАР, 2010 ОН



Эдийн засгийн идэвхтэй хүн амын дийлэнх буюу 85 хувь нь хөдөлмөр эрхэлж байна. Гэхдээ эрэгтэй, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин ойролцоо юм. Харин ажил хайж байгаа буюу хөдөлмөр эрхэлдэггүй хүмүүсийн хүйсийн харьцаа 138 байна. Шилжих хөдөлгөөнд ороод 1 жил болоогүй байгаа эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү хувиар ажил хайж байгаа нь шилжин ирсэн эмэгтэйчүүд ирсэн даруйдаа ажилд орж чадахгүй байгааг харуулна.

ЗУРАГ 4.12. ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХТЭЙ ХҮН АМЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНД ОРСОН ЭСЭХ, ХҮЙС, ХУВИАР, 2010 ОН



Эдийн засгийн идэвхтэй хүн амын ажил мэргэжлийн ангиллыг төрснөөс хойш шилжих хөдөлгөөнд орсон эсэхээр ангилж үзвэл шилжээгүй эмэгтэйчүүдтэй харьцуулахад шилжсэн эмэгтэйчүүд менежер, мэргэжилтэн болон бусад мэргэшсэн ажил үүрэг илүүтэйгээр гүйцэтгэж байна.

#### ХҮСНЭГТ 4.6. ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХТЭЙ ХҮН АМЫН АЖИЛ МЭРГЭЖЛИЙН АНГИЛАЛ, ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНД ОРСОН ЭСЭХ, ХҮЙС, ХУВИАР, 2010 ОН

Ажил мэргэжлийн ангилал	Бүгд			Төрснөөс хойш		Шилжиж ирсэн		5 жил		1 жил хүртэл	
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Менежер	7.9	8.3	7.5	6.9	5.9	9.3	9.0	7.7	7.2	6.1	5.8
Мэргэжилтэн	16.9	10.8	24.2	8.4	16.4	12.4	31.6	13.6	30.0	12.2	28.3
Техникч болон туслах/дэд мэргэжилтэн	4.4	3.1	6.0	2.7	4.8	3.4	7.2	4.0	7.5	4.1	7.8
Контор, үйлчилгээний ажилтан	2.6	1.3	4.1	1.1	3.3	1.5	4.9	1.7	5.1	1.5	4.8
Худалдаа үйлчилгээний ажилтан	14.7	10.8	19.4	9.8	17.3	11.4	21.5	11.6	20.7	9.5	21.4
ХАА, ой, загас агнуурын ажилтан	25.9	27.4	24.2	36.2	39.5	21.0	9.6	12.2	13.1	11.5	14.1
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан	9.3	12.8	5.2	10.7	4.5	14.2	5.9	18.1	6.1	23.4	6.9
Суурин төхөөрөг, машин механизмын операторч, угсрагч	8.7	14.9	1.4	13.3	1.0	16.2	1.7	16.6	1.4	19.2	1.4
Энгийн ажил мэргэжил	7.5	7.4	7.7	6.7	7.0	7.9	8.3	9.2	8.3	10.0	9.2
Зэвсэгт хүчний ажил, мэргэжил	1.9	3.2	0.3	4.2	0.3	2.5	0.4	5.2	0.5	2.4	0.5

Гар утас хэрэглэдэг хүн амын хүйсийн харьцаа 93 байгаа бол хэрэглэдэггүй хүн амын хүйсийн харьцаа үүнээс 20 пунктээр илүү юм. Шилжих хөдөлгөөнд оролцсон эсэхээр авч үзэхэд эрэгтэйчүүдийн гар утасны хэрэглээ нэмэгдэж байна.

#### ХҮСНЭГТ 4.7. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ГАР УТАС, ИНТЕРНЕТИЙН ХЭРЭГЛЭЭ, ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНД ОРСОН ЭСЭХ, ХҮЙС, ХУВИАР, 2010 ОН

Тухайн газарт суусан хугацаа	Гар утас хэрэглэдэг хүн ам				Интернет хэрэглэдэг хүн ам			
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>48.2</b>	<b>51.8</b>	<b>93.1</b>	<b>100.0</b>	<b>45.8</b>	<b>54.2</b>	<b>84.7</b>
Төрснөөс хойш	100.0	46.6	53.4	87.4	100.0	47.1	52.9	88.9
Шилжиж ирсэн	100.0	49.6	50.4	98.5	100.0	44.9	55.1	81.3
1 жил хүртэл	100.0	52.8	47.2	111.9	100.0	48.5	51.5	94.1
1-4 жил	100.0	47.9	52.1	92.1	100.0	44.1	55.9	79.0
5-9 жил	100.0	48.6	51.4	94.4	100.0	44.7	55.3	80.7
10, түүнээс дээш жил	100.0	50.1	49.9	100.4	100.0	44.4	55.6	79.7
Хувийн жин	Бүгд 74.0	Эрэгтэй 72.2	Эмэгтэй 75.9	-	Бүгд 30.6	Эрэгтэй 28.4	Эмэгтэй 32.8	-

Эмэгтэйчүүдийн интернет хэрэглээний түвшин гар утаснаас илүү байна. Шилжих хөдөлгөөнд оролцсон эмэгтэйчүүдийн хэрэглээний түвшин оролцоогүй эмэгтэйчүүдээс өндөр байхад шилжиж ирээд удаагүй эрэгтэйчүүдийн интернет хэрэглээ хамгийн өндөр байна.


Эмэгтэйчүүдтэй харьцуулахад эрэгтэйчүүд хөгжлийн бэрхшээлтэй байх хандлага түгээмэл байгаа нь тэд эрсдэл өндөртэй, хүнд хөдөлмөр эрхэлдэгтэй холбоотой. Шилжих хөдөлгөөнд оролцоогүй эмэгтэйчүүдийн 48 хувь хөгжлийн бэрхшээлтэй байгаа нь шилжих хөдөлгөөнд оролцсон эмэгтэйчүүдтэй харьцуулахад өндөр юм. Гэхдээ нийт хөгжлийн бэрхшээлтэй хүн амын бараг тэн хагас нь шилжээд 10-аас дээш жил болсон байгаа нь тэд хөгжлийн бэрхшээлтэй болохоосоо өмнө шилжсэнтэй холбоотой байж болох юм.

#### ХҮСНЭГТ 4.8. ХҮН АМЫН ХҮЙСИЙН ХАРЬЦАА, ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНД ОРСОН ЭСЭХ, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ, ХҮЙС, ХУВИАР, 2010 ОН

Тухайн газарт суусан хугацаа	Хөгжлийн бэрхшээлтэй				Хөгжлийн бэрхшээлгүй			
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>55.2</b>	<b>44.8</b>	<b>123.2</b>	<b>100.0</b>	<b>49.4</b>	<b>50.6</b>	<b>97.6</b>
Төрснөөс хойш	100.0	52.1	47.9	108.8	100.0	48.2	51.8	93.0
Шилжиж ирсэн	100.0	59.3	40.7	145.8	100.0	51.1	48.9	104.5
1 жил хүртэл	100.0	54.3	45.7	118.9	100.0	53.4	46.6	114.8
1-4 жил	100.0	54.2	45.8	118.6	100.0	49.0	51.0	96.1
5-9 жил	100.0	55.8	44.2	126.1	100.0	50.7	49.3	102.8
10, түүнээс дээш жил	100.0	61.5	38.5	159.4	100.0	51.7	48.3	106.9


Тооллогын дүнгээр өрхийн 74 хувь нь эрэгтэй тэргүүлэгчтэй байна. Харин шилжих хөдөлгөөнд оролцсон өрхийн тэргүүлэгчийн 80 хувь эрэгтэйчүүд байгаа нь нэг талаас эрэгтэй тэргүүлэгчтэй өрх илүү шилжих магадлалтай байдгийг харуулна. Тэгвэл өрхийн тэргүүлэгчийн хүйсээс хамаарч өрхийн сууцны нөхцөл ялгаатай байна. Тодруулбал, шилжих хөдөлгөөнд орсон эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн дийлэнх буюу 65 хувь нь байшинд амьдарч байна.

#### ЗУРАГ 4.13. ӨРХИЙН СУУЦНЫ ТӨРӨЛ, ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНД ОРСОН ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХҮЙС, ХУВИАР, 2010 ОН



Эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн дийлэнх нь байшинд амьдарч байгаа хэдий ч шилжих хөдөлгөөнд оролцсон эмэгтэй тэргүүлэгчтэй өрх бусдын сууцанд амьдрах нь элбэг тохиолдож байна. Ялангуяа, шилжээд удаагүй буюу 1 жил болоогүй, эмэгтэй тэргүүлэгчтэй өрх илүүтэй бусдын сууцанд түрээс төлөн амьдарч байна.

ЗУРАГ 4.14. ӨРХИЙН СУУЦНЫ ЭЗЭМШЛИЙН ХЭЛБЭР, ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНД ОРСОН ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХҮЙС, ХУВИАР, 2010 ОН



## ДҮГНЭЛТ

Сүүлчийн хоёр тооллогын хооронд эрэгтэйчүүд илүүтэй шилждэг хандлага хэвээр хадгалагдаж байгаа хэдий ч эмэгтэйчүүдийн шилжилт эрчимтэй нэмэгдсэн байна. Ялангуяа, 20-29 насны эмэгтэйчүүдийн шилжилт эрс нэмэгджээ.

Хотод төвлөрөл, хөдөөд уул уурхайн салбар эрчимжиж байгаатай холбоотойгоор манай оронд эмэгтэйчүүд хот руу, эрэгтэйчүүд хөдөө рүү чиглэсэн эсрэг урсгал бий болсон байна. Тухайлбал, хот, хөдөөгийн хүн амын хүйсийн харьцааны зөрүү өмнөх тооллоготой харьцуулахад 2 дахин нэмэгджээ.

Шилжих хөдөлгөөний нөлөө аймаг, нийслэлийн хүн амын бүтэц, тэр дундаа хүйсийн харьцаанд ихээхэн өөрчлөлт оруулсан байна. Энэ нөлөө Өмнөговь аймагт хамгийн тод илэрч байна. Тодруулбал, тус аймагт төрсөн хүн амын хүйсийн харьцаа 99 байхад одоо амьдарч байгаа хүн амын хүйсийн харьцаа 134 байна.

Шилжих хөдөлгөөнд оролцсон эсэхээс хамаараад эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн гэр бүлийн байдал, боловсрол, ажил эрхлэлт зэрэг нийгэм, эдийн засгийн үндсэн шинж байдалд ихээхэн ялгаа гарч байна. Тухайлбал, гэр бүлтэй эмэгтэйчүүд шилжих хөдөлгөөнд бага оролцож байхад, шилжих хөдөлгөөнд харьцангуй боловсрол өндөртэй эрэгтэйчүүд оржээ.

Ажил эрхлэлт нь шилжих хөдөлгөөний тулгуур хүчин зүйл болдог. Шилжих хөдөлгөөнд ороод удаагүй байгаа эмэгтэйчүүд илүүтэй эдийн засгийн идэвхгүй байна. Шилжих хөдөлгөөнд оролцсоноор эмэгтэйчүүд ХАА-н ажлаас худалдаа үйлчилгээний ажил болон бусад мэргэшсэн ажил үүрэг гүйцэтгэж байна.

Өрхийн тэргүүлэгчийн хүйсээс хамаарч тухайн өрхийн сууцны төрөл, нөхцөл, эзэмшил өөр байна. Эмэгтэй тэргүүлэгчтэй, шилжээд удаагүй байгаа өрх түрээсийн сууцанд суух хандлага давамгайлж байна. Энэ нь эрэгтэй эмэгтэй хүмүүс амьдарч байгаа байршлаа өөрчилснөөр өмчийн тэгш бус хувиарлалт нэмэгддэгийг харуулна.

# ТАВДУГААР БҮЛЭГ

БОЛОВСРОЛ, СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ



## БОЛОВСРОЛ, СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ

Энэ бүлэгт бичиг үсгийн мэдлэг, бүх шатны боловсролд хамрагдалт, боловсролын түвшин, сургууль завсардалт, боловсролын салбарын багшлах боловсон хүчний хүйсийн ялгаатай байдлыг багцалж судлав. Ингэхдээ хүн амын бичиг үсгийн мэдлэг, сургуульд хамрагдалт, боловсролын түвшин гэсэн гурван үндсэн үзүүлэлтийг авч үзлээ.

2010 оны тооллогоор 6, түүнээс дээш насны хүн бүрээс боловсролын түвшин, бичиг үсгийн мэдлэг, 2-39 насны хүн амаас сургуульд суралцаж (цэцэрлэгт хүмүүжиж) байгаа эсэхийг асуусан болно.

## БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ

Ямар нэг боловсрол эзэмшээгүй ч аль нэг хэлээр хамгийн энгийн богино өгүүлбэрийг уншиж, ойлгож, бичих чадвартай хүнийг бичиг үсэг мэддэг хүн гэнэ. Хүн ам, орон сууцны 2000, 2010 оны тооллогоор боловсрол, бичиг үсгийн мэдлэгийг хоёр асуултаар асууж, боловсролгүй хүнээс бичиг үсэг мэддэг, үл мэддэг болохыг тодруулсан юм.

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын дүнгээр 15, түүнээс насны хүн амын бичиг үсгийн мэдлэгийн түвшин 98.3 хувь байгаа нь 2000 оныхоос 0.5 пунктээр өссөний дотор эрэгтэйчүүдийнх 0.2 пунктээр, эмэгтэйчүүдийнх 0.8 пунктээр нэмэгджээ.

### ХҮСНЭГТ 5.1. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ТОО, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ, ХУВИАР, 2000, 2010 ОН


Бичиг үсгийн мэдлэг	2000			2010		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Бичиг үсэг мэддэг	97.8	98.0	97.5	98.3	98.2	98.3
Бичиг үсэг мэддэггүй	2.2	2.0	2.5	1.7	1.8	1.7

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын дүнгээс харахад хотын 10, түүнээс дээш насны хүн ам үндсэндээ бичигтэн болсон бол хөдөөгийнх өмнөх тооллогын үеийнхээс ердөө 0.1 пунктээр л нэмэгджээ.

Зургаа, түүнээс дээш насны боловсролгүй хүн амын 83.0 хувийг бичиг үсэг мэддэг хүмүүс эзэлж байна. Нас, хүйсийн бүтцийг авч үзвэл эрэгтэйчүүдийн 82.6 хувь нь бичиг үсэг мэддэг, 81.0 хувь нь 6-14 насны хөвгүүд; эмэгтэйчүүдийн 82.9 хувь нь бичиг үсэг мэддэг, 83.5 хувь нь 6-14 насны охид байна.

Бичиг үл мэдэгчдийн тоо 15-29 насанд их, тэр дундаа эрэгтэйчүүд олон байгаа нь анхаарал татаж байна. Зах зээлийн нийгэмд шилжих явцад охид, хөвгүүдийн сургууль завсардалт нэмэгдэж, хөвгүүд олноороо сургуулиа орхисныг үүнтэй холбон тайлбарлаж болно.

ЗУРАГ 5.1. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ БОЛОВСРОЛГҮЙ ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2010 ОН



Зургаа, түүнээс дээш насны бичиг үсэг мэддэггүй эрэгтэй хүн ам эмэгтэйгээс 10 хувиар илүү ажээ. Байршлын хувьд хотын хүн амын бичиг үсгийн мэдлэгийн түвшин хоёр хүйсийн хувьд хөдөөгийнхөөс 2.5 пунктээр, улсын дунджаас 0.7-0.8 пунктээр дээгүүр байна.

ХҮСНЭГТ 5.2 ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ХУВЬ, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ, ХОТ, ХӨДӨӨ, ХҮЙСЭЭР, 2010 ОН

Байршил	Бичиг үсэг мэддэг			Бичиг үсэг мэддэггүй		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
<b>БҮГД</b>	<b>96.5</b>	<b>98.2</b>	<b>98.4</b>	<b>3.5</b>	<b>1.8</b>	<b>1.6</b>
Хот	98.3	99.0	99.1	1.7	1.0	0.9
Хөдөө	97.8	96.5	96.6	2.2	3.5	3.4

Зургаа, түүнээс дээш насны боловсролгүй хүн амын 17.0 хувь нь бичиг үсэг мэддэггүй хүмүүс байна. Тэдний 63.5 хувь нь хөдөө тоологджээ. Хөдөө тоологдсон бичиг үсэг мэддэггүй хүн амын 53.0 хувь нь эрэгтэйчүүд, 47.0 хувь нь эмэгтэйчүүд юм.

Бичиг үсэг мэддэг 6, түүнээс дээш насны хүн амын дийлэнх нь Улаанбаатар хот, Хангайн бүсэд тоологджээ. Бичиг үсэг мэддэг эрэгтэй, эмэгтэйчүүдийн тоо Зүүн бүсээс бусад бүсэд ойролцоо байна. Харин Зүүн бүсэд бичиг үсэг мэддэг эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 2.1 дахин олон байна.

ХҮСНЭГТ 5.3. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ТОО,  
БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ, ХҮЙС, БҮС, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2010 ОН

Аймаг, нийслэл	Бичиг үсэг мэддэг			Хүйсийн харьцаа	Бичиг үсэг мэддэггүй			Хүйсийн харьцаа
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй		Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	
<b>БҮГД</b>	<b>271 877</b>	<b>140 987</b>	<b>130 890</b>	<b>107.7</b>	<b>56 793</b>	<b>29 749</b>	<b>27 044</b>	<b>110.0</b>
<b>БАРУУН БҮС</b>								
Дүн	53 661	27 794	25 867	107.4	11 921	5 958	5 963	99.9
Баян-Өлгий	14 526	7 335	7 191	102.0	2 814	1 390	1 424	97.6
Говь-Алтай	7 693	3 981	3 712	107.2	1 570	758	812	93.3
Завхан	8 999	4 727	4 272	110.7	2 246	1 126	1 120	100.5
Увс	11 790	6 288	5 502	114.3	2 708	1 395	1 313	106.2
Ховд	10 653	5 463	5 190	105.3	2 583	1 289	1 294	99.6
<b>ХАНГАЙН БҮС</b>								
Дүн	63 913	33 297	30 616	108.8	15 477	8 063	7 414	108.8
Архангай	10 955	5 788	5 167	112.0	3 297	1 761	1 536	114.6
Баянхонгор	9 850	5 088	4 762	106.8	2 730	1 376	1 354	101.6
Булган	5 556	3 000	2 556	117.4	1 458	785	673	116.6
Орхон	8 083	4 115	3 968	103.7	1 060	550	510	107.8
Өвөрхангай	14 330	7 508	6 822	110.1	3 212	1 709	1 503	113.7
Хөвсгөл	15 139	7 798	7 341	106.2	3 720	1 882	1 838	102.4
<b>ТӨВИЙН БҮС</b>								
Дүн	46 080	24 078	22 002	109.4	10 207	5 607	4 600	121.9
Говьсүмбэр	1 352	704	648	108.6	269	147	122	120.5
Дархан-Уул	7 662	3 890	3 772	103.1	1 228	668	560	119.3
Дорноговь	6 338	3 283	3 055	107.5	1 455	775	680	114.0
Дундговь	5 449	2 910	2 539	114.6	1 471	793	678	117.0
Өмнөговь	6 377	3 353	3 024	110.9	1 432	780	652	119.6
Сэлэнгэ	9 925	5 099	4 826	105.7	2 009	1 115	894	124.7
Төв	8 977	4 839	4 138	116.9	2 343	1 329	1 014	131.1
<b>ЗҮҮН БҮС</b>								
Дүн	23 057	12 285	10 772	114.0	7 141	3 880	3 261	119.0
Дорнод	7 214	3 827	3 387	113.0	2 134	1 166	968	120.5
Сүхбаатар	7 238	3 881	3 357	115.6	2 866	1 537	1 329	115.7
Хэнтий	8 605	4 577	4 028	113.6	2 141	1 177	964	122.1
<b>УЛААНБААТАР</b>								
Улаанбаатар	85 166	43 533	41 633	104.6	12 047	6 241	5 806	107.5

## СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ

Сургуульд суралцаж байгааг тодорхойлохдоо цэцэрлэгт хүмүүждэг эсэхийг 2-5 насны хүүхдээс, албан ёсны боловсрол олгох сургуульд суралцаж байгаа эсэхийг 6-39 насны хүнээс асуусан. Мөн албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж байгаа хүнийг сургуульд суралцдаг гэж үзсэн.

НҮБ-аас гаргасан “Хүн ам, орон сууцны тооллогын зарчим, зөвлөмж”-ийн 2.209-д “Сургуульд хамрагдалт нь тооллогын өдрүүдэд албан ёсны боловсрол олгох ямар нэг шатны сургуульд суралцаж байгаа тоолуулагчийн, хэрэв тооллого нь сургуулийн амралтын хугацаанд явагдсан бол тухайн хичээлийн жилийн төгсгөлд буюу өнгөрсөн хичээлийн жилийн турш суралцсан тоолуулагчаар тодорхойлогдоно. Боловсролын олон улсын стандарт ангилалд заасанчлан боловсрол гэдэгт хүний сурч боловсрох хэрэгцээг хангахад чиглэсэн зориудын, системтэй бүхий л үйл ажиллагааг багтаан ойлгоно. Тооллогын зорилгоор ямар нэг шатны боловсрол олгодоггүй сургалтад хамрагдахыг “сургуульд хамрагдалт” гэж үзэхгүй” гэж заажээ. Түүнчлэн, дээрх зөвлөмжид сургуульд хамрагдалт “сургуульд элсэлт”-тэй харилцан бие биеэ нөхдөг үзүүлэлт ч гэлээ сургуульд элсэлтийг захиргааны мэдээллээс авдгаараа ялгардаг гэдгийг дурьджээ.

## СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ (СӨБ)-Д ХАМРАГДАЛТ

Монгол Улсын “Боловсролын тухай” хуульд сургуулийн өмнөх боловсролын байгууллага нь цэцэрлэг болохыг заасан. “Сургуулийн өмнөх боловсролын тухай” хуульд зааснаар “хүүхдийн цэцэрлэг” гэж хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насны хүүхдийг асрах, хамгаалах, хүмүүжүүлэх, сургах цогц үйл ажиллагаагаар хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг дэмжих сургалтын байгууллагыг хэлдэг.

ҮСХ-оос гаргасан албан ёсны статистикийн мэдээллээр 2010/2011 оны хичээлийн жилд нийт 839 цэцэрлэг<sup>7</sup> ажиллаж байна.

Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогоор 7-29 насны хүн бүрээс сургуульд суралцаж байгаа эсэхийг асуусан учир сургуулийн өмнөх боловсрол (СӨБ)-д хамрагдаж байгаа хүүхдийн талаарх мэдээллийг харьцуулах боломжгүй юм.

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын дүнгээр 2-39 насны 1834.9 мянган хүн тоологдсоны 45.6 хувь нь цэцэрлэг, сургуульд хамрагддаг, 54.4 хувь нь аль нэг шатны сургуульд хамрагддаггүй ажээ. Энэ тооллогоор 2-5 насны 202.4 мянган хүүхэд тоологдсоны 60.1 хувь нь цэцэрлэгт хүмүүжиж байгаа бол 39.9 хувь нь цэцэрлэгт хүмүүжээгүй байна. Цэцэрлэгт хүмүүжиж байгаа 2-5 насны хүүхдийн 50.1 хувь нь хөвгүүд, 49.9 хувь нь охид байна.


### ХҮСНЭГТ 5.4. ХОЁРООС ТАВАН НАСНЫ ХҮН АМЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ЦЭЦЭРЛЭГТ ХҮМҮҮЖДЭГ ЭСЭХ, ХҮЙСЭЭР, 2010 ОН

Нас	Цэцэрлэгт хүмүүждэг			Хүйсийн харьцаа	Цэцэрлэгт хүмүүждэггүй			Хүйсийн харьцаа
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй		Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	
<b>БҮГД</b>	<b>121 647</b>	<b>60 910</b>	<b>60 737</b>	<b>100.3</b>	<b>80 773</b>	<b>42 076</b>	<b>38 697</b>	<b>108.7</b>
2	27 361	13 683	13 678	100.0	34 072	17 459	16 613	105.1
3	30 875	15 369	15 506	99.1	21 253	11 132	10 121	110.0
4	30 703	15 358	15 345	100.1	14 806	7 819	6 987	111.9
5	32 708	16 500	16 208	101.8	10 642	5 666	4 976	113.9

<sup>7</sup> ҮСХ, “Статистикийн эмхтгэл 2010”, 2011 он

2-5 насны хүн амын хүйсийн харьцаа 103, үүнээс цэцэрлэгт хүмүүждэг хүүхдийн хүйсийн харьцаа 100.3 байна. Цэцэрлэгт хүмүүждэг хүүхдийн дотор 3 насанд хөвгүүдийн тоо охидоосоо цөөн байна.

ЗУРАГ 5.2. ХОЁРООС ТАВАН НАСНЫ ХҮҮХДИЙН ТОО, ЦЭЦЭРЛЭГТ ХҮМҮҮЖДЭГ ЭСЭХ, ХҮЙС, ХУВИАР, 2010 ОН



СӨБ-д хамрагдсан хүүхдийн хүйсийн харьцааг хот, хөдөөгийн ялгавартайгаар авч үзэхэд хотод хөвгүүд, хөдөөд охидын тоо олон байна. Насны бүтцийг ажиглахад нас ахих тутам цэцэрлэгт хүмүүжиж байгаа хүүхдийн хувийн жин нэмэгдэж байгаа нь бага насныхны СӨБ-д хамрагдалт доогуур түвшинд байгааг харуулна.

ХҮСНЭГТ 5.5. ЦЭЦЭРЛЭГТ ХҮМҮҮЖДЭГ 2-5 НАСНЫ ХҮҮХДИЙН ТОО, НАС, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010 ОН

Нас	Цэцэрлэгт хүмүүждэг			Хүйсийн харьцаа	Хувь - А			Хувь - Б	
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй		Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
<b>УЛСЫН ДҮН</b>									
2	27 361	13 683	13 678	100.0	100.0	50.0	50.0	22.5	22.5
3	30 875	15 369	15 506	99.1	100.0	49.8	50.2	25.2	25.5
4	30 703	15 358	15 345	100.1	100.0	50.0	50.0	25.2	25.3
5	32 708	16 500	16 208	101.8	100.0	50.4	49.6	27.1	26.7
Бүгд	121 647	60 910	60 737	100.3	100.0	50.1	49.9	100.0	100.0
<b>ХОТ</b>									
2	20 590	10 311	10 279	100.3	100.0	50.1	49.9	23.1	23.4
3	23 225	11 643	11 582	100.5	100.0	50.1	49.9	26.1	26.3
4	22 188	11 197	10 991	101.9	100.0	50.5	49.5	25.1	25.0
5	22 574	11 451	11 123	102.9	100.0	50.7	49.3	25.7	25.3
Бүгд	88 577	44 602	43 975	101.4	100.0	50.4	49.6	100.0	100.0
<b>ХӨДӨӨ</b>									
2	6 771	3 372	3 399	99.2	100.0	49.8	50.2	20.7	20.3
3	7 650	3 726	3 924	95.0	100.0	48.7	51.3	22.8	23.4
4	8 515	4 161	4 354	95.6	100.0	48.9	51.1	25.5	26.0
5	10 134	5 049	5 085	99.3	100.0	49.8	50.2	31.0	30.3
Бүгд	33 070	16 308	16 762	97.3	100.0	49.3	50.7	100.0	100.0

СӨБ-д хамрагддаггүй хүүхдийн хувьд хот, хөдөө ялгаагүй хөвгүүд давамгайл байна.

### ХҮСНЭГТ 5.6. ЦЭЦЭРЛЭГТ ХҮМҮҮЖДЭГҮЙ 2-5 НАСНЫ ХҮҮХДИЙН ТОО, НАС, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010 ОН

Нас	Цэцэрлэгт хүмүүждэг			Хүйсийн харьцаа	Хувь - А			Хувь - Б	
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй		Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
<b>УЛСЫН ДҮН</b>									
2	34 072	17 459	16 613	105.1	100.0	51.2	48.8	41.5	42.9
3	21 253	11 132	10 121	110.0	100.0	52.4	47.6	26.5	26.2
4	14 806	7 819	6 987	111.9	100.0	52.8	47.2	18.5	18.1
5	10 642	5 666	4 976	113.9	100.0	53.2	46.8	13.5	12.8
Бүгд	80 773	42 076	38 697	108.7	100.0	52.1	47.9	100.0	100.0
<b>ХОТ</b>									
2	19 321	9 947	9 374	106.1	100.0	51.5	48.5	46.2	47.3
3	10 738	5 620	5 118	109.8	100.0	52.3	47.7	26.1	25.8
4	6 681	3 473	3 208	108.3	100.0	52	48.0	16.1	16.2
5	4 614	2 485	2 129	116.7	100.0	53.9	46.1	11.6	10.7
Бүгд	41 354	21 525	19 829	108.6	100.0	52.1	47.9	100.0	100.0
<b>ХӨДӨӨ</b>									
2	14 751	7 512	7 239	103.8	100.0	50.9	49.1	36.6	38.4
3	10 515	5 512	5 003	110.2	100.0	52.4	47.6	26.8	26.5
4	8 125	4 346	3 779	115.0	100.0	53.5	46.5	21.1	20.0
5	6 028	3 181	2 847	111.7	100.0	52.8	47.2	15.5	15.1
Бүгд	39 419	20 551	18 868	108.9	100.0	52.1	47.9	100.0	100.0

### БҮХ ШАТНЫ СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ

Монгол Улсын “Боловсролын тухай” хуульд “сургалтын байгууллага” гэж нэг буюу хэд хэдэн түвшний боловсролын агуулгыг хэрэгжүүлдэг хуулийн этгээдийг хэлнэ гэж тодорхойлсон. Мөн “бүх нийтийн ерөнхий боловсрол” гэж 12 жилийн сургалтын агуулгын түвшинг, “суурь боловсрол” гэж 9 жилийн сургалтын агуулгын түвшинг хэлнэ гэжээ. Бага, дунд боловсролын байгууллага нь ерөнхий боловсролын сургууль юм.

Тооллогоор 6-39 насны 1632.4 мянган хүн тоологдсоны 43.8 хувь нь аль нэг шатны сургуульд суралцдаг ажээ. Сургуульд суралцдаг хүмүүсийн 48.3 хувь нь эрэгтэйчүүд, 51.7 хувь нь эмэгтэйчүүд юм.

Суралцагчдын хүйсийн харьцааг авч үзэхэд 6-14 насныхны дотор хүйсийн ялгаа их биш байгаа ч 15 наснаас эхлэн эмэгтэйчүүд мэдэгдэхүйц нэмэгдэж байна. Энэ байдал хот, хөдөөд ч ижил хандлагатай байна.

### ХҮСНЭГТ 5.7. СУРГУУЛЬД СУРАЛЦДАГ 6-15 НАСНЫ ХҮН АМЫН ТОО, НАС, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010 ОН

Нас	Улсын дүн		Хүйсийн харьцаа	Хот		Хүйсийн харьцаа	Хөдөө		Хүйсийн харьцаа
	Эрэгтэй	Эмэгтэй		Эрэгтэй	Эмэгтэй		Эрэгтэй	Эмэгтэй	
<b>БҮГД</b>	<b>223 230</b>	<b>220 754</b>	<b>101.1</b>	<b>138 454</b>	<b>137 202</b>	<b>100.9</b>	<b>97 838</b>	<b>98 117</b>	<b>99.7</b>
6	20 003	19 459	102.8	12 790	12 339	103.7	7 213	7 120	101.3
7	21 231	20 439	103.9	13 284	12 775	104.0	7 947	7 664	103.7
8	21 592	20 877	103.4	13 209	12 855	102.8	8 383	8 022	104.5
9	22 351	21 942	101.9	13 726	13 434	102.2	8 625	8 508	101.4
10-14	114 838	113 992	100.7	70 167	70 194	100.0	44 671	43 798	102.0
15	23 215	24 045	96.5	15 278	15 605	97.9	20 999	23 005	91.3

Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогын дүнгээр 7-29 насны хүн амын сургуульд хамрагдалтыг судлахад тэдний бараг тал хувь нь (47.8 хувь) сургуульд суралцаж байв. 2010 оны тооллогоор энэ насны хүмүүсийн 56.9 хувь сургуульд суралцаж байгаа нь 10 жилийн өмнөхөөс 9.1 пунктээр илүү байна. Үүнийг хүйсээр ангилахад эмэгтэйчүүдийн сургуульд хамрагдалтын хувь эрэгтэйчүүдийнхээс 5 пунктээр их байна. Эмэгтэйчүүдийн сургуульд хамрагдалтын хувь 2 тооллогын хооронд 8.3 пунктээр, эрэгтэйчүүдийнх 9.9 пунктээр нэмэгджээ.

Хөдөөгийн хүн амын сургуульд хамрагдалтад гарсан ахиц бол 7-29 насныхны суралцагчдын хувь өмнөх тооллогын үеийнхээс 16.3 пунктээр, тэр дундаа эрэгтэйчүүдийнх 15.8, эмэгтэйчүүдийнх 17 пунктээр өссөн явдал юм. Харин хотын суралцагчдын хувьд мэдэгдэхүйц өөрчлөлт гарсангүй.

#### ХҮСНЭГТ 5.8. ДОЛООГООС ХОРИН ЕСӨН НАСНЫ ХҮН АМЫН СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ, НАС, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2000, 2010 ОН

Нас	Улсын дүн			Хүйсийн ялгаа *	Хот			Хүйсийн ялгаа *	Хөдөө			Хүйсийн ялгаа *
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй		Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй		Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	
<b>2010</b>												
7	97.9	97.7	98.1	0.4	98.4	98.3	98.5	0.2	97.0	96.7	97.4	0.7
8	98.4	98.3	98.6	0.3	98.7	98.6	98.7	0.1	98.0	97.8	98.3	0.5
9	98.5	98.3	98.6	0.3	98.7	98.6	98.9	0.2	98.0	97.8	98.2	0.5
10	98.2	97.9	98.5	0.7	98.5	98.3	98.7	0.4	97.8	97.3	98.3	1.0
11	97.6	97.1	98.1	1.0	98.1	97.9	98.4	0.4	96.7	95.8	97.7	1.9
12	96.7	95.8	97.7	1.9	97.6	97.2	98.0	0.9	95.4	93.8	97.1	3.3
13	95.8	94.6	97.0	2.4	97.1	96.5	97.6	1.1	93.9	91.9	96.0	4.1
14	94.7	92.8	96.7	3.8	96.6	95.8	97.4	1.7	91.9	88.4	95.5	7.0
15	93.0	90.5	95.6	5.1	95.8	94.7	96.9	2.3	88.2	83.5	93.1	9.7
16-19	75.9	69.6	82.5	12.9	82.9	78.9	86.8	7.9	54.4	45.2	66.8	21.6
20-24	29.8	25.8	33.8	8.0	37.3	33.5	40.9	7.4	6.2	5.1	7.6	2.4
25-29	5.6	4.7	6.5	1.8	7.2	6.1	8.3	2.2	2.0	1.8	2.2	0.4
Бүгд	56.9	54.4	59.4	5.1	58.9	57.1	60.7	3.5	52.2	48.6	56.3	7.7
<b>2000</b>												
7	29.4	27.2	31.7	4.5	41.0	38.1	43.9	5.8	16.6	15.2	17.9	2.7
8	84.8	83.3	86.3	3.0	91.7	90.6	92.8	2.2	76.4	74.3	78.4	4.1
9	93.8	92.5	94.2	1.7	96.8	96.4	97.2	0.8	88.8	87.5	90.2	2.7
10	93.4	92.4	94.5	2.1	97.2	96.8	97.6	0.8	88.4	86.5	90.3	3.8
11	91.8	89.9	93.6	3.7	96.8	95.9	97.7	1.8	85.0	81.9	88.2	6.3
12	88.4	85.4	91.6	6.2	95.8	94.5	97.1	2.6	78.8	73.5	84.4	10.9
13	84.8	80.5	89.0	8.5	94.5	92.8	96.1	3.3	72.3	65.2	79.7	14.5
14	80.1	74.5	85.8	11.3	92.1	89.2	94.9	5.7	64.8	56.2	73.7	17.5
15	72.8	65.7	80.0	14.3	87.6	83.5	91.5	8.0	53.5	44.2	64.0	19.8
16-19	40.0	33.2	47.0	13.8	57.0	49.6	63.9	14.3	15.5	11.8	19.8	8.0
20-24	15.6	12.3	19.0	6.7	26.0	20.9	30.8	9.9	1.7	1.5	1.9	0.4
25-29	5.1	4.0	6.2	2.2	8.3	6.6	10.0	3.4	0.7	0.7	0.7	0.0
Бүгд	47.8	44.5	51.1	6.6	56.6	53.6	59.5	5.9	35.9	32.8	39.3	6.5

Тайлбар: \* эмэгтэй-эрэгтэй

Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогын үед ЕБС-ийн 1 дүгээр ангид элсэх нас 7 байв. Улсын хэмжээнд уг насны хүүхдийн сургуульд хамрагдалт 29.4 хувь, хотод 41.0 хувь, хөдөөд 16.6 хувь байжээ. Хөвгүүдийн сургуульд хамрагдалт ерөнхий дүнгээрээ 27.2 хувь, хотод 38.1 хувь, хөдөөд 15.2 хувь байсан бол 2010 онд харгалзан 97.7, 98.3, 96.7 хувь болж өсөв. Харин охидын сургуульд хамрагдалт бага хэмжээгээр нэмэгджээ.


Боловсролын салбарт шинэчлэл хийж, 12 жилийн боловсрол эзэмшүүлэх болсонтой холбоотойгоор 2010 онд ЕБС-ийн 1 дүгээр ангид элсэх нас 6 болсон. 2010 оны тооллогоор 6 насны 42.1 мянган хүүхэд тоологдсоны 93.6 хувь, түүний дотор хөвгүүдийн 93.0 хувь, охидын 94.3 хувь нь сургуульд хамрагдав. Хот, хөдөөгийн сургуульд хамрагдалтыг харьцуулахад энэ үзүүлэлт хотод илүү юм.

Сургуульд суралцаж буй хүн амын хүйсийн ялгаа 11 наснаас эхлэн насны бүлэг нэмэгдэх тусам ихсэж байгаа бөгөөд 15-19 насны бүлэгт хүйсийн ялгаа хамгийн өндөр байна. Нас ахих тутам сургуульд хамрагдалт буурч байгаа энэ хандлага эрэгтэйчүүдийн хувьд эмэгтэйчүүдээс нэлээд илүү байна.

Монгол Улсын “Бага, дунд боловсролын тухай” хуульд бага боловсролыг 6, суурь боловсролыг 9, бүрэн дунд боловсролыг 12 жилд тус тус эзэмшүүлнэ гэж заасны дагуу сургуульд хамрагдалтыг бага, суурь боловсролын шатлалаар авч үзлээ.


2010 онд бага сургуульд суралцаж байгаа 6-11 насны 230.3 мянган хүүхэд тоологдсоны 50.9 хувь нь хөвгүүд, 49.1 хувь нь охид байна. Бага сургуульд суралцдаг охид, хөвгүүд 6-11 насны нийт суурин хүн амын 85.7 хувь юм.

### ЗУРАГ 5.3. ЗУРГААГААС АРВАН НЭГЭН НАСНЫ ХҮҮХДИЙН СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010 ОН



Бага сургуульд суралцаж байгаа хүүхдийн хамрагдалт нас бүрт 90-ээс дээш хувьтай байна. Сургуульд хамрагдаж байгаа охид, хөвгүүдийн тоо 7 наснаас эхлэн нэмэгдсээр 10 настай хөвгүүд, охидын хувьд сургуульд хамрагдалт хамгийн өндөр байснаа 11 наснаас буурах хандлагатай болжээ.

ЗУРАГ 5.4. ЗУРГААГААС АРВАН НЭГЭН НАСНЫ ХҮҮХДИЙН СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ, ХҮЙС, ХУВИАР, 2010 ОН




Хотод тоологдсон 6-11 насны хөвгүүдийн бага сургуульд хамрагдалтын хувь охидынхоос 0.5 пунктээр, харин хөдөөд охидын хамрагдалтын хувь хөвгүүдийнхээс 0.4 пунктээр илүү байна.

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоор суурь боловсролд хамрагдаж байгаа 168.5 мянган хүүхэд тоологдсон бөгөөд хүйсийн харьцаа тэнцүү байна.

Боловсролын шатлал ахихад сургуульд хамрагдаж байгаа хөвгүүдийн тоо цөөрч, охид давамгайлах хандлагатай болж байна. Энэ хандлага хот, хөдөөд ижил байна.

ЗУРАГ 5.5. АРВАН ХОЁРООС АРВАН ТАВАН НАСНЫ ХҮН АМЫН СУУРЬ БОЛОВСРОЛД ХАМРАГДАЛТ, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010 ОН




2010 оны тооллогоор бүрэн дунд сургууль болон МСҮТ-д суралцаж байгаа 112.8 мянган хүн тоологдсоны 49.0 хувь эрэгтэй, 51.0 хувь нь эмэгтэйчүүд байна. Энэ харьцаа хотод ижил, харин хөдөөд эрэгтэйчүүдийн хувь 47.0, эмэгтэйчүүдийнх 53.0 хувь байна.

## СУРГУУЛЬ ЗАВСАРДАЛТ

Хүн амын, ялангуяа 6-15 насны охид, хөвгүүдийн сургуульд хамрагдалтын байдлыг илэрхийлдэг өөр нэг үзүүлэлт нь сургуулийн гадна байгаа буюу сургууль завсардсан<sup>8</sup> хүүхдийн тоо юм.

Тооллогын дүнгээр 6-15 насны сургууль завсардсан 16.6 мянган хүүхэд тоологдсоны 63.0 хувь нь хөвгүүд, 37.0 хувь нь охид байна. Сургууль завсардсан хүүхдийн бараг тал хувь нь 13-15 насныхан юм. Мөн зургаан настнуудын завсардалт ч бусад насны бүлэгтэй харьцуулахад өндөр бөгөөд нийт завсардагчдын 16.0 хувийг эзэлж байна. Тэр дундаа 6 настай хөвгүүдийн 18.5 хувь, охидын 19.2 хувь сургууль завсарджээ.


ЗУРАГ 5.6. СУРГУУЛЬ ЗАВСАРДСАН ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2010 ОН



Сургууль завсардсан 6-15 насны хүүхдийн 28.9 хувь нь Хангайн бүсэд, 26.0 хувь нь Баруун бүсэд тоологджээ. Зүүн бүсэд сургууль завсардалт хамгийн бага буюу нийт завсардсан хүүхдийн 7.2 хувь амьдарч байна. Завсардагчдын дотор хөвгүүдийн эзлэх хувь аль ч бүсэд охидоос өндөр юм.

<sup>8</sup> Сургуульд суралцаж байгаад завсардсан болон сургуульд огт суралцаагүй бүх хүүхэд

ЗУРАГ 5.7. СУРГУУЛЬ ЗАВСАРДСАН 6-15 НАСНЫ ХҮН АМЫН ТОО, ХҮЙС, БҮСЭЭР, 2010 ОН



Сургууль завсардсан 6 настай хүүхдийн дийлэнх нь Улаанбаатар хот, Баян-Өлгий аймагт тоологджээ. Баруун бүсэд Баян-Өлгий, Хангайн бүсэд Хөвсгөл, Төвийн бүсэд Төв, Зүүн бүсэд Сүхбаатар аймаг сургууль завсардалтаараа бусдаасаа өндөр байна. Сургууль завсардсан хөвгүүдийн тоо нас харгалзахгүйгээр бүх аймагт охидынхоос олон юм. ҮСХ-ноос гаргасан мэдээлэлд 6-15 насны охид, хөвгүүд ажил эрхлэх, сурах дургүй, өвчин, амьдралын гачигдал зэрэг шалтгаанаар сургууль завсардаж байгаа<sup>9</sup> гэж тодорхойлжээ.

<sup>9</sup> ҮСХ, “Боловсрол, соёл, шинжлэх ухааны статистик 2010” танилцуулга, 2011 он

ХҮСНЭГТ 5.9. ЗУРГААГААС АРВАН ТАВАН НАСНЫ ХҮН АМЫН СУРГУУЛЬ ЗАВСАРДАЛТ,  
НАС, ХҮЙС, БҮС, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2010 ОН

Аймаг, нийслэл	Бүгд			6-11 нас			12-15 нас		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
<b>БҮГД</b>	<b>16 553</b>	<b>10 435</b>	<b>6 118</b>	<b>6 983</b>	<b>4 000</b>	<b>2 983</b>	<b>9 570</b>	<b>6 435</b>	<b>3 135</b>
<b>БАРУУН БҮС</b>									
Бүгд	4 296	2 688	1 608	2 148	1 224	924	2 148	1 464	684
Баян-Өлгий	1 764	1 021	743	1 147	631	516	617	390	227
Говь-Алтай	361	241	120	124	71	53	237	170	67
Завхан	465	307	158	168	101	67	297	206	91
Увс	981	665	316	412	258	154	569	407	162
Ховд	725	454	271	297	163	134	428	291	137
<b>ХАНГАЙН БҮС</b>									
Бүгд	4 790	3 172	1 618	1 675	985	690	3 115	2 187	928
Архангай	915	613	302	309	187	122	606	426	180
Баянхонгор	777	503	274	265	156	109	512	347	165
Булган	324	221	103	132	78	54	192	143	49
Орхон	298	186	112	119	56	63	179	130	49
Өвөрхангай	1 172	793	379	421	262	159	751	531	220
Хөвсгөл	1 304	856	448	429	246	183	875	610	265
<b>ТӨВИЙН БҮС</b>									
Бүгд	2 294	1 474	820	920	539	381	1 374	935	439
Говьсүмбэр	53	35	18	24	15	9	29	20	9
Дархан-Уул	336	205	131	143	78	65	193	127	66
Дорноговь	294	186	108	116	69	47	178	117	61
Дундговь	239	149	90	83	47	36	156	102	54
Өмнөговь	303	194	109	104	62	42	199	132	67
Сэлэнгэ	523	329	194	228	133	95	295	196	99
Төв	546	376	170	222	135	87	324	241	83
<b>ЗҮҮН БҮС</b>									
Бүгд	1 191	795	396	391	233	158	800	562	238
Дорнод	344	223	121	122	70	52	222	153	69
Сүхбаатар	499	335	164	141	86	55	358	249	109
Хэнтий	348	237	111	128	77	51	220	160	60
<b>УЛААНБААТАР</b>									
Улаанбаатар	3 982	2 306	1 676	1 849	1 019	830	2 133	1 287	846

## БОЛОВСРОЛТОЙ ХҮН АМЫН ХҮЙСИЙН ЯЛГААТАЙ БАЙДАЛ

Монгол Улсын “Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай” хуульд “мэргэжлийн боловсрол” гэж тодорхой мэргэжлийн үйл ажиллагааг гүйцэтгэх хэрэгцээнд нийцүүлж, зохион байгуулалттай сургалтаар эзэмшүүлсэн мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хөдөлмөрийн болон харилцааны соёлын төлөвшлийг; “мэргэжил” гэж тодорхой ажил, хөдөлмөр эрхлэхэд шаардагдах мэдлэг, чадвар, дадлын цогцыг хэлнэ гэж тодорхойлсон. “Дээд боловсролын тухай” хуульд манай улсын дээд боловсролын зорилго нь төрөөс боловсролын талаар баримтлах бодлогод тулгуурлан боловсролын үндсэн зарчим, олон улсын нийтлэг жишиг, хандлагад нийцүүлэн иргэнд дээд боловсрол олгоход оршино гэж заажээ.

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогоор 10, түүнээс дээш насны 2.1 сая хүн тоологдсоны 92.5 хувь нь ямар нэг боловсролтой хүн ам байна. Тэдний 49.0 хувь нь эрэгтэй, 51.0 хувь нь эмэгтэйчүүд юм.

Өмнөх 2000 оны тооллогын дүнгээр 15-19 насанд хүйсийн ялгаа их байснаа 20-44 насанд багасч, 45 наснаас эрс нэмэгдэж байсан бол 2010 онд 25-29 наснаас буурч, 55 наснаас өсч байна (Хүснэгт 5.10). 2000 онд 45 наснаас эхлэн боловсролтой эрэгтэйчүүд давамгайлж байсан бол 2010 онд 10 насаар ухарч, 55 болжээ.


### ХҮСНЭГТ 5.10. АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ БОЛОВСРОЛТОЙ ХҮН АМЫН ЭЗЛЭХ ХУВЬ, ХҮЙС, НАСНЫ БҮЛГЭЭР, 2000, 2010 ОН

Насны бүлэг	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй		Хүйсийн ялгаа*	
	2000	2010	2000	2010	2000	2010	2000	2010
10-14	59.0	67.0	57.3	66.0	60.7	68.1	3.4	2.0
15-19	92.3	96.6	90.1	95.5	94.7	97.7	4.6	2.2
20-24	97.3	96.0	96.5	94.7	98.1	97.3	1.6	2.5
25-29	98.1	93.9	97.8	92.3	98.5	95.6	0.7	3.2
30-34	97.8	96.3	97.5	95.3	98.1	97.4	0.6	2.0
35-39	97.3	97.9	97.2	97.5	97.5	98.3	0.3	0.8
40-44	97.7	97.5	97.7	97.2	97.7	97.8	-	0.6
45-49	97.2	96.9	97.6	96.7	96.7	97.0	-0.9	0.4
50-54	96.3	96.9	97.2	96.9	95.4	96.9	-1.8	0.0
55-59	92.2	96.3	94.9	96.5	89.5	96.1	-5.4	-0.4
60-64	86.9	95.4	91.2	96.5	82.8	94.5	-8.4	-2.0
65-69	80.2	91.6	86.4	94.1	75.1	89.5	-11.3	-4.7
70, түүнээс дээш	58.0	81.0	72.7	87.3	48.6	76.3	-24.1	-11.0

Тайлбар: \* эмэгтэй-эрэгтэй


Арван тав, түүнээс дээш насны хүн амын 35.0 хувь нь бүрэн дунд боловсролтой хүмүүс байна. Хүйсээр авч үзвэл боловсролтой эрэгтэйчүүдийн 15.0 хувь, эмэгтэйчүүдийн 21.0 хувь нь дээд боловсролтой ажээ.

ЗУРАГ 5.8. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХҮЙС, ХУВИАР, 2010 ОН



Арав, түүнээс дээш насны хүн амын боловсролын түвшинг судалж үзвэл сүүлчийн 11 жилийн хугацаанд нэлээд өөрчлөгджээ. Тухайлбал, бага боловсролтой хүн амын эзлэх хувь 2010 онд 2000 оныхоос 9.6, суурь боловсролтой хүн амынх 9.1, тусгай мэргэжлийн дунд боловсролтой хүн амынх 2.4 пунктээр буурав. Харин бүрэн дунд боловсролтой хүн амын хувийн жин 10.9 пунктээр, дээд боловсролтой хүн амынх хамгийн их буюу 2.3 дахин өсчээ. Дээд боловсролтой эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдийнхээс өндөр байна.


ЗУРАГ 5.9. ДЭЭД БОЛОН ТУСГАЙ МЭРГЭЖЛИЙН ДУНД БОЛОВСРОЛТОЙ ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2000, 2010 ОН



Эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээсээ өндөр боловсролтой байх нь төрөлт буурах, бие даасан, эрэгтэйчүүдээс салангид байх эрмэлзлийг улам нэмэгдүүлэхэд нөлөөлж болох юм. 55, түүнээс дээш насанд дээд боловсрол эзэмшсэн эрэгтэйчүүдийн эзлэх хувь өндөр байна.

Арван тав, түүнээс дээш насны хүн амын дотор тусгай мэргэжлийн дундаас дээш боловсролтой хүн амын байдал онцлог байгаа юм. 2000 оны тооллогын дүнгээр тусгай мэргэжлийн дундаас дээш боловсролтой 40-44 насны эмэгтэйчүүд, 50-54 насны эрэгтэйчүүд хамгийн их хувийн жинтэй байсан бол 2010 онд 25-29 насны эмэгтэйчүүд, 60, түүнээс дээш насны эрэгтэйчүүд хамгийн их хувийн жин эзэлдэг болов.

**ЗУРАГ 5.10. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ТУСГАЙ МЭРГЭЖЛИЙН ДУНДААС ДЭЭШ БОЛОВСРОЛТОЙ ХҮН АМ, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ХУВИАР, 2000, 2010 ОН**



ЕБС-д суралцагчдын хүйсийн харьцаа бага, дунд боловсролын түвшинд харьцангуй тэнцвэртэй, харин ахлах ангиас эхлэн ялгаа нь нэмэгдэж байна. Ялангуяа, дээд боловсролын түвшинд хамгийн их байгааг дээрх зургаас харж болно.


## БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН БОЛОВСОН ХҮЧНИЙ ХҮЙСИЙН ЯЛГААТАЙ БАЙДАЛ

Сургуульд суралцагчдын хүйсийн харьцаанд тодорхой хэмжээгээр нөлөөлдөг хүчин зүйлсийн нэг бол боловсролын салбарт ажиллагсад, тэр дундаа багшлах боловсон хүчний хүйсийн харьцаа юм.

Боловсролын салбарт ажилладаг 10 багш тутмын 8 нь эмэгтэйчүүд байна. Байршлын хувьд энэ харьцаа үндсэндээ ижил юм. Гэвч боловсролын шатлалаар авч үзвэл цэцэрлэг, яслийн багшийн 98 хувь, бага боловсролынхны 93 хувь, бүрэн дунд боловсролд 76 хувь, мэргэжлийн боловсролд 61.3 хувь буюу хамгийн бага, дээд сургуулийн багшийн 67 хувь нь эмэгтэйчүүд ажээ. Энэ бүхнээс харахад мэргэжлийн болон дээд боловсролын байгууллагад эрэгтэйчүүд бусад шатлалтай харьцуулахад хамгийн олноороо ажиллаж байна.

Эрэгтэй багш боловсролын шатлал ахих тутам нэмэгдэж байгаа нь уг салбарын цалингийн шатлалтай холбоотой байж болох юм. Нөгөө талаар сургуулийн өмнөх болон бага боловсролд эмэгтэйчүүд ажиллах нь илүү тохиромжтой, эх хүний үндсэн үүргийн нэг нь хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, асран халамжлах гэсэн нийгэмд тогтсон уламжлалт сэтгэлгээтэй холбоотойгоор уг шатлалын байгууллагад эмэгтэйчүүд багшилж байгаа болов уу. Тиймээс боловсролын салбарын нэг хүйс давамгайлсан бүтэц суралцагчдын хүйсийн харьцаанд нөлөөлж байгаа эсэхийг судлах нь тулгамдаж буй асуудлыг шийдэх нэг гарц байхыг үгүйсгэхгүй юм.

ЗУРАГ 5.11. БАГШИЙН АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМ, БОЛОВСРОЛЫН ШАТЛАЛ, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010 ОН



Багш нарын хүйсийн харьцаа нас ахих тутам нэмэгдэх хандлагатай байгаа ч 30-39 насны эрэгтэйчүүд багшийн ажил эрхлэх нь бусад насныхантай харьцуулахад хамгийн бага юм. Энэ хандлага боловсролын аль ч шатлалд ажиглагдаж байна. Бүрэн дундаас дээш түвшний боловсрол олгох байгууллагад 55-аас дээш насны эрэгтэй багш эмэгтэйчүүдээс олон ажиллаж байгааг хүснэгтээс харж болно.

ХҮСНЭГТ 5.11. БАГШИЙН АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМЫН ХҮЙСИЙН ХАРЬЦАА,  
НАСНЫ БҮЛЭГ, БОЛОВСРОЛЫН ШАТЛАЛААР, 2010 ОН

Насны бүлэг	Бүгд	Сургуулийн өмнөх боловсрол	Бага боловсрол	Бүрэн дунд боловсрол	Мэргэжлийн боловсрол	Дээд боловсрол
<b>БҮГД</b>	<b>27.9</b>	<b>2.3</b>	<b>7.1</b>	<b>31.7</b>	<b>63.0</b>	<b>49.4</b>
25 хүртэл	35.2	4.6	10.1	37.6	63.8	57.2
25-29	31.4	2.7	8.6	35.7	66.4	44.0
30-34	21.7	1.5	4.6	23.1	50.6	39.0
35-39	17.5	1.7	4.4	23.2	42.2	34.6
40-44	21.7	2.2	8.1	30.4	55.9	41.2
45-49	22.9	1.7	6.1	27.7	60.8	38.2
50-54	30.9	2.9	9.9	30.8	73.2	53.8
55-59	89.0	9.7	20.0	102.0	153.8	108.1
60, түүнээс дээш	235.4	30.0	35.0	145.2	333.3	371.7

Энэ бүхнээс харахад бүх шатны сургуульд суралцагч төдийгүй боловсролын салбарын ажиллагчдын хувьд ч хүйсийн ялгаа их байна.

## ДҮГНЭЛТ


Монгол Улсын хүн амын боловсролын түвшин, бичиг үсгийн мэдлэг дээшилж, ялангуяа хотын хүн ам бараг бичигтэн болсон зэрэг олон дэвшил гарсан ч эрэгтэйчүүдийн боловсрол эзэмшиж буй байдал эмэгтэйчүүдтэй харьцуулахад учир дутагдалтай болж, тэдний боловсролын түвшин буурах хандлага ажиглагдах болов. Энэ нь гэр бүлд болон нийгмийн амьдралын бүхий л хүрээнд нөлөөлж байна.

Монгол Улс 1990-ээд оны эхээр ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжих үеэс сургууль завсардах явдал эрс нэмэгдэж, хичээлийн жилд сургуулиас завсардсан хүүхдийн тоо нийт сурагчдын бараг 10 хувийг эзэлж байв. Өнөөдөр уг үзүүлэлт буурсан ч хөвгүүд сургуулиас завсардах явдал байсаар байна. Эрэгтэй хүүхэд сургуулиас завсардаж байгаа нь сургууль, сургалтын орчин нөхцөл сайн бус, сургалтын чанар, ялангуяа хөдөө орон нутагт тааруу, багшийн харилцаа, хичээлээс гадуур зохиогдох чөлөөт цагийн үйл ажиллагаа хангалтгүй зэрэг боловсролын салбарын дотоод үйл ажиллагаатай ч холбоотой байж болох юм.

Боловсролын салбар дахь эмэгтэйчүүд давамгайлсан энэхүү өвөрмөц үзэгдэлд монгол гэр бүлийн охид, хөвгүүддээ хандах уламжлалт үзэл хандлага нөлөөлж байна. Тухайлбал, эцэг эхчүүд хөвгүүдээс илүү охидоо сургуульд суралцуулахыг эрхэмлэдэг, сургууль завсардсан эрэгтэй хүүхэд өрхийн орлогод хувь нэмэр болох, мал маллах, ногоо тарих зэрэг аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж, хөдөлмөрийн зах зээлд харьцангуй эрт хөл тавьдаг.

Боловсролын шат ахих тутам нэмэгдэж буй хүйсийн нэг тийш хэлбийсэн байдалд нийгмийн сөрөг үзэгдэл гэж хандахаас илүү түүний шалтгаан, нийгэмд үзүүлэх хор нөлөөлөл, үр дагаврыг судалгааны үндэслэлтэй тодорхойлох шаардлагатай.

## ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ



## ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ

Хүн амын хүйсийн харьцаа 50-иас хойших насанд эрс буурав. Эрэгтэйчүүдийн нас баралт сүүлчийн 2 тооллогын хугацаанд 12.2 хувиар өсч, 2010 оны байдлаар нас барах үеийн хүйсийн харьцаа 143 болжээ. Үүний шалтгааныг цаашид нарийвчлан судалж, архи, тамхины хэрэглээ, буруу зан үйлээс үүдэлтэй сөрөг үр дагавар болон үйлдвэрлэлийн осол гэмтэлийг бууруулах арга авах шаардлагатай юм.

Эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйчүүдээс 19.6 мянгаар илүү байна. 2000 онд 25-аас дээш насанд эмэгтэйчүүд давамгайлж байснаа 2010 онд 10 насаар ухарч, 35 болсон нь эмэгтэйчүүд гадаадад суралцах, ажиллахаар явсантай холбоотой.

Хотын 100 эрэгтэй тутамд 6 эмэгтэй илүү байхад хөдөөд эсрэгээрээ 100 эмэгтэйд 8 эрэгтэй илүү байна. Энэ бол хөдөөнөөс хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөний нөлөө бөгөөд 20-24 насны эмэгтэйчүүд сурах, хөдөлмөр эрхлэхээр хот руу шилжиж байна.

Өмнөговь аймгийн 100 эмэгтэй тутамд 34 эрэгтэй илүү ногдох болж, өмнөх тооллогын дүнгээс 33 пунктээр нэмэгдлээ. Ялангуяа, хөдөлмөрийн болон нөхөн үржихүйн хамгийн идэвхтэй үе болох 20-44 насны эрэгтэйчүүд тус аймагт хамгийн олон байна. Уул уурхайн бүтээн байгуулалтыг дагасан хүн ам зүйн энэхүү сөрөг үр дагаврыг цаашид нарийвчлан судалж, тус аймгийн хүн амын хүйсийн харьцааг ердийн түвшинд байлгах бодлого, зохицуулалт авч хэрэгжүүлэх шаардлагатай болжээ.

## ӨРХ, ГЭР БҮЛ

Монгол Улсын өрхийн тоо 2010 онд 713.8 мянга болов. Үүний 560.2 мянган өрх эрэгтэй тэргүүлэгчтэй, 153.6 мянга нь эмэгтэй тэргүүлэгчтэй өрх юм. Эрэгтэй тэргүүлэгчтэй өрх өмнөх тооллогын үеийнхээс 23.8 хувиар, эмэгтэй тэргүүлэгчтэй өрх 73.6 хувиар нэмэгдлээ.

Ганц бие эмэгтэйчүүд нэмэгдсэн нь эмэгтэй тэргүүлэгчтэй өрх нэмэгдэхэд голлон нөлөөлөв. Энэ нь салалттай холбоотой бөгөөд 45-54 насны хүмүүсийн дунд салалт бараг 4 дахин нэмэгджээ.

Улсын нэг өрх дунджаар 3.6 ам бүлтэй байгаа бол эрэгтэй тэргүүлэгчтэй өрх 3.8 ам бүлтэй, эмэгтэй тэргүүлэгчтэй өрх цөөхүүлээ буюу 2.9 ам бүлтэй амьдарч байна.

Өрхийн түвшинд эхнэр, нөхрийн боловсролын ялгаа 2000 онтой харьцуулахад улам нэмэгдлээ. Нөхрийн боловсролын түвшин доогуур, эхнэрийнх өндөр байх хандлагатай болжээ.

Эхнэрийн боловсролын түвшин өндөр байгаа боловч хөдөлмөр эрхлэлтийг нөхөртэй нь харьцуулахад буурчээ.

Эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн 18.3 хувь, эрэгтэй тэргүүлэгчтэй өрхийн 11.9 хувь бусдын сууцанд амьдарч байна.

Өрх толгойлсон эцэг, эхийн тоо 83.9 мянга байгаагийн 17.6 хувь эрэгтэйчүүд, 82.4 хувь эмэгтэйчүүд юм. Өрх толгойлсон эхийн тоо 2000 оноос 31 хувиар өссөн бол өрх толгойлсон эцгийн тоо 5.9 хувиар буурлаа. Эцэгтэйгээ амьдардаг хүүхдийн дундаж тоо 1.7 байхад эхчүүдийн хувьд 1.8 байна.

Өрх толгойлсон эхчүүд олон хүүхэд тэжээж байгаагаас гадна хөдөлмөр эрхлэхгүй байна. Тиймээс нийгмийн халамжийн бодлогыг илүү зорилтот бүлэгт чиглүүлэх, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах нь зүйтэй юм.

Эхчүүдийн хөдөлмөр эрхлэхгүй байгаа шалтгааныг авч үзэхэд хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнээ асардаг, гэрийн ажилтай гэж хариулсан хүмүүс их байна. Ажлын байр шинээр бий болгох нь хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх үндсэн арга зам хэдий ч эмэгтэйчүүдийн ажлын цагт уян хатан зохицуулалт хийх боломжийг судлах, өндөр настан, хүүхэд асрах газар, ясли цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зэрэг нь өрх, гэр бүл, хөдөлмөр эрхлэлтэд жендерийн тэгш байдлыг хангах чухал арга хэмжээ болно.

## ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

Төрснөөс хойших шилжих хөдөлгөөнд эрэгтэйчүүд давамгайлж оролцож байгаагийн зэрэгцээ эмэгтэйчүүдийн шилжилт нэмэгдэж байна.

Хүн амын хамгийн сүүлчийн шилжих хөдөлгөөний байдлаас үзэхэд эмэгтэйчүүд хот руу, эрэгтэйчүүд хөдөө рүү чиглэсэн урсгал бий болжээ.

Шилжих хөдөлгөөний нөлөө аймаг, нийслэлийн хүн амын насны бүтэц, түүнчлэн эрэгтэй, эмэгтэйчүүдийн гэрлэлт, боловсрол, ажил эрхлэлт зэрэг нийгэм, эдийн засгийн үндсэн шинж байдалд нөлөөлж байна.

Эмэгтэйчүүд шилжих хөдөлгөөнд оролцсоны дараагаар хөдөлмөр эрхлэх боломж эрэгтэйчүүдтэй харьцуулахад бага байна. Шилжих хөдөлгөөнд оролцсоноор эмэгтэйчүүд ХАА-н ажлаас худалдаа үйлчилгээний болон бусад мэргэшсэн ажил үүрэг гүйцэтгэх хандлагатай болов.

Шилжих хөдөлгөөнд оролцсон өрхийн тэргүүлэгчийн хүйсээс хамаараад өрхийн сууцны нөхцөл ялгаатай байна. Эмэгтэй тэргүүлэгчтэй шилжээд удаагүй байгаа өрх түрээсийн сууцанд амьдрах хандлага давамгайлж байна.

## БОЛОВСРОЛ

Эрэгтэйчүүдийн боловсрол эмэгтэйчүүдийнхээс доогуур түвшинд байх хандлагатай болов. Энэ нь гэр бүл болон нийгмийн амьдралын бүхий л хүрээнд сөргөөр нөлөөлж байна.


Боловсролын салбарт эмэгтэйчүүд давамгайлахад монгол гэр бүлийн охид, хөвгүүддээ хандах уламжлалт үзэл хандлага нөлөөлж байна.

Хөвгүүд сургуулиас завсардах явдал байсаар байна. Эрэгтэй хүүхэд сургуулиас завсардаж байгаа нь сургууль, сургалтын орчин нөхцөл сайн бус, хүрэлцээ муу, сургалтын чанар тааруу, багшийн харилцаа, хичээлээс гадуур зохиогдох чөлөөт цагийн үйл ажиллагаа хангалтгүй зэрэг боловсролын салбарын дотоод үйл ажиллагаатай ч холбоотой байж болох юм.

Боловсролын шат ахих тутам нэмэгдэж буй хүйсийн нэг тийш хэлбийсэн байдалд нийгмийн сөрөг үзэгдэл гэж хандахаас илүү түүний шалтгаан, нийгэмд үзүүлэх хор нөлөөлөл, үр дагаврыг үндэслэлтэй тодорхойлох шаардлага гарчээ.



## ХАВСРАЛТ



ХҮСНЭГТ 1. ӨРХИЙН ТОО, ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН НАСНЫ БҮЛЭГ, ӨРХИЙН ХЭЛБЭР,  
ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010 ОН

Насны бүлэг	Бүгд			Ганц бие			Ам бүлгээрээ			Нийлмэл			Холлимог		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
<b>УЛСЫН ДҮН-БҮГД</b>	<b>713 780</b>	<b>560 224</b>	<b>153 556</b>	<b>75 917</b>	<b>42 278</b>	<b>33 639</b>	<b>445 048</b>	<b>380 296</b>	<b>64 752</b>	<b>177 898</b>	<b>127 071</b>	<b>50 827</b>	<b>14 917</b>	<b>10 579</b>	<b>4 338</b>
15-19	6 808	4 412	2 396	1 338	1 038	300	520	415	105	3 430	2 356	1 074	482	303	179
20-24	45 627	37 301	8 326	7 690	5 207	2 483	20 971	19 261	1 710	14 875	11 366	3 509	2 091	1 467	624
25-29	83 810	73 254	10 556	7 449	5 430	2 019	55 634	50 913	4 721	18 905	15 458	3 447	1 822	1 453	369
30-34	96 018	83 094	12 924	6 347	4 829	1 518	69 490	61 746	7 744	18 374	15 081	3 293	1 807	1 438	369
35-39	96 273	80 788	15 485	4 586	3 451	1 135	61 719	55 524	6 195	16 759	13 178	3 581	1 729	1 305	424
40-44	91 511	73 964	17 547	6 235	4 375	1 860	67 398	56 524	10 874	16 092	11 825	4 267	1 786	1 240	546
45-49	85 982	67 121	18 861	6 960	4 200	2 760	57 306	47 526	9 780	20 001	14 228	5 773	1 715	1 167	548
50-54	69 061	51 902	17 159	6 295	3 216	3 079	40 818	33 547	7 271	20 581	14 207	6 374	1 367	932	435
55-59	42 687	30 252	12 435	5 049	2 142	2 907	22 441	18 163	4 278	14 466	9 478	4 988	731	469	262
60-64	30 564	20 317	10 247	4 522	1 628	2 894	14 301	11 479	2 822	11 294	6 926	4 368	447	284	163
65-69	25 087	15 779	9 308	4 904	1 619	3 285	10 574	8 493	2 081	9 245	5 451	3 794	364	216	148
70-74	19 689	11 792	7 897	4 977	1 694	3 283	7 537	5 981	1 556	6 905	3 954	2 951	270	163	107
75, түүнээс дээш	20 663	10 248	10 415	7 183	2 014	5 169	6 203	4 529	1 674	6 971	3 563	3 408	306	142	164
<b>ХОТ-БҮГД</b>	<b>479 503</b>	<b>364 270</b>	<b>115 233</b>	<b>47 246</b>	<b>26 290</b>	<b>20 956</b>	<b>275 599</b>	<b>228 391</b>	<b>47 208</b>	<b>145 232</b>	<b>101 764</b>	<b>43 468</b>	<b>11 426</b>	<b>7 825</b>	<b>3 601</b>
15-19	5 768	3 554	2 214	1 985	1 035	950	378	301	77	2 939	1 929	1 010	466	289	177
20-24	33 159	25 951	7 208	5 322	3 259	2 063	13 238	12 008	1 230	12 711	9 383	3 328	1 888	1 301	587
25-29	55 291	46 742	8 549	4 892	3 255	1 637	33 201	29 808	3 393	15 785	12 582	3 203	1 413	1 097	316
30-34	62 907	52 457	10 450	4 184	2 920	1 264	42 196	36 380	5 816	15 200	12 153	3 047	1 327	1 004	323
35-39	63 997	51 524	12 473	4 007	2 958	1 049	44 856	37 006	7 850	13 891	10 663	3 228	1 243	897	346
40-44	61 028	47 282	13 746	4 101	2 832	1 269	42 394	34 103	8 291	13 212	9 481	3 731	1 321	866	455
45-49	58 844	44 298	14 546	4 578	2 767	1 811	36 681	29 354	7 327	16 282	11 312	4 970	1 303	865	438
50-54	46 767	34 109	12 658	4 026	2 093	1 933	25 375	20 294	5 081	16 392	11 081	5 311	974	641	333
55-59	28 885	20 029	8 856	3 074	1 385	1 689	13 758	10 892	2 866	11 535	7 429	4 106	518	323	195
60-64	21 033	13 828	7 205	2 611	1 009	1 602	8 949	7 072	1 877	9 168	5 558	3 610	305	189	116
65-69	16 482	10 380	6 102	2 588	935	1 653	6 371	5 016	1 355	7 267	4 282	2 985	256	147	109
70-74	12 536	7 555	4 981	2 486	867	1 619	4 471	3 478	993	5 399	3 108	2 291	180	102	78
75, түүнээс дээш	12 806	6 561	6 245	3 392	975	2 417	3 731	2 679	1 052	5 451	2 803	2 648	232	104	128
<b>ХӨДӨӨ-БҮГД</b>	<b>234 277</b>	<b>195 954</b>	<b>38 323</b>	<b>28 671</b>	<b>15 988</b>	<b>12 683</b>	<b>169 449</b>	<b>151 905</b>	<b>17 544</b>	<b>32 666</b>	<b>25 307</b>	<b>7 359</b>	<b>3 491</b>	<b>2 754</b>	<b>737</b>
15-19	1 040	858	182	391	303	88	142	114	28	491	427	64	16	14	2
20-24	12 468	11 350	1 118	2 368	1 948	420	7 733	7 253	480	2 164	1 983	181	203	166	37
25-29	28 519	26 512	2 007	2 557	2 175	382	22 433	21 105	1 328	3 120	2 876	244	409	356	53
30-34	33 111	30 637	2 474	2 163	1 909	254	27 294	25 366	1 928	3 174	2 928	246	480	434	46
35-39	32 276	29 264	3 012	1 923	1 628	295	26 999	24 713	2 286	2 868	2 515	353	486	408	78
40-44	30 483	26 682	3 801	2 134	1 543	591	25 004	22 421	2 583	2 880	2 344	536	465	374	91
45-49	27 138	22 823	4 315	2 382	1 433	949	20 625	18 172	2 453	3 719	2 916	803	412	302	110
50-54	22 294	17 793	4 501	2 269	1 123	1 146	15 443	13 253	2 190	4 189	3 126	1 063	393	291	102
55-59	13 802	10 223	3 579	1 975	757	1 218	8 683	7 271	1 412	2 931	2 049	882	213	146	67
60-64	9 531	6 489	3 042	1 911	619	1 292	5 352	4 407	945	2 126	1 368	758	142	95	47
65-69	8 605	5 399	3 206	2 316	684	1 632	4 203	3 477	726	1 978	1 169	809	108	69	39
70-74	7 153	4 237	2 916	2 491	827	1 664	3 066	2 503	563	1 506	846	660	90	61	29
75, түүнээс дээш	7 857	3 687	4 170	3 791	1 039	2 752	2 472	1 850	622	1 520	760	760	74	38	36

## ХҮСНЭГТ 2. ӨРХИЙН ТОО, АМ БҮЛИЙН ТОО, ӨРХИЙН ХЭЛБЭР, ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010 ОН

Насны бүлэг	Бүгд			Ганц бие			Ам бүлээрээ			Нийлмэл			Холимог		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
<b>УЛСЫН ДҮН-БҮГД</b>	<b>713 780</b>	<b>560 224</b>	<b>153 556</b>	<b>75 917</b>	<b>42 278</b>	<b>33 639</b>	<b>445 048</b>	<b>380 296</b>	<b>64 752</b>	<b>177 898</b>	<b>127 071</b>	<b>50 827</b>	<b>14 917</b>	<b>10 579</b>	<b>4 338</b>
1	75 917	42 278	33 639	75 917	42 278	33 639	-	-	-	-	-	-	-	-	-
2	114 642	73 890	40 752	-	-	-	91 952	61 108	30 844	20 802	11 632	9 170	1 888	1 150	738
3	165 873	130 941	34 932	-	-	-	132 768	111 659	21 109	30 347	17 551	12 796	2 758	1 731	1 027
4	171 733	150 640	21 093	-	-	-	129 298	120 752	8 546	39 200	27 647	11 553	3 235	2 241	994
5	103 933	92 214	11 719	-	-	-	61 931	58 989	2 942	39 027	30 917	8 110	2 975	2 308	667
6	50 085	43 708	6 377	-	-	-	21 186	20 209	977	26 606	21 696	4 910	2 293	1 803	490
7	18 601	16 027	2 574	-	-	-	5 830	5 595	235	11 963	9 788	2 175	808	644	164
8	7 693	6 408	1 285	-	-	-	1 585	1 516	69	5 595	4 490	1 105	513	402	111
9	2 941	2 313	628	-	-	-	371	351	20	2 359	1 828	531	211	134	77
10, түүнээс дээш	2 362	1 805	557	-	-	-	127	117	10	1 999	1 522	477	236	166	70
<b>ХОТ-БҮГД</b>	<b>479 503</b>	<b>364 270</b>	<b>115 233</b>	<b>47 246</b>	<b>26 290</b>	<b>20 956</b>	<b>275 599</b>	<b>228 391</b>	<b>47 208</b>	<b>145 232</b>	<b>101 764</b>	<b>43 468</b>	<b>11 426</b>	<b>7 825</b>	<b>3 601</b>
1	47 246	26 290	20 956	47 246	26 290	20 956	-	-	-	-	-	-	-	-	-
2	76 707	46 385	30 322	-	-	-	59 730	37 337	22 393	15 600	8 226	7 374	1 377	822	555
3	113 592	86 188	27 404	-	-	-	87 450	71 660	15 790	24 011	13 243	10 768	2 131	1 285	846
4	116 121	99 236	16 885	-	-	-	81 359	75 250	6 109	32 279	22 351	9 928	2 483	1 635	848
5	68 560	58 880	9 680	-	-	-	33 836	31 822	2 014	32 497	25 379	7 118	2 227	1 679	548
6	33 714	28 259	5 455	-	-	-	9 913	9 245	668	22 074	17 710	4 364	1 727	1 304	423
7	13 197	10 924	2 273	-	-	-	2 444	2 281	163	10 103	8 139	1 964	650	504	146
8	5 867	4 710	1 157	-	-	-	642	594	48	4 793	3 784	1 009	432	332	100
9	2 403	1 824	579	-	-	-	168	152	16	2 046	1 556	490	189	116	73
10, түүнээс дээш	2 096	1 574	522	-	-	-	57	50	7	1 829	1 376	453	210	148	62
<b>ХӨДӨӨ-БҮГД</b>	<b>234 277</b>	<b>195 954</b>	<b>38 323</b>	<b>28 671</b>	<b>15 988</b>	<b>12 683</b>	<b>169 449</b>	<b>151 905</b>	<b>17 544</b>	<b>32 666</b>	<b>25 307</b>	<b>7 359</b>	<b>3 491</b>	<b>2 754</b>	<b>737</b>
1	28 671	15 988	12 683	28 671	15 988	12 683	-	-	-	-	-	-	-	-	-
2	37 935	27 505	10 430	-	-	-	32 222	23 771	8 451	5 202	3 406	1 796	511	328	183
3	52 281	44 753	7 528	-	-	-	45 318	39 999	5 319	6 336	4 308	2 028	627	446	181
4	55 612	51 404	4 208	-	-	-	47 939	45 502	2 437	6 921	5 296	1 625	752	606	146
5	35 373	33 334	2 039	-	-	-	28 095	27 167	928	6 530	5 538	992	748	629	119
6	16 371	15 449	922	-	-	-	11 273	10 964	309	4 532	3 986	546	566	499	67
7	5 404	5 103	301	-	-	-	3 386	3 314	72	1 860	1 649	211	158	140	18
8	1 826	1 698	128	-	-	-	943	922	21	802	706	96	81	70	11
9	538	489	49	-	-	-	203	199	4	313	272	41	22	18	4
10, түүнээс дээш	266	231	35	-	-	-	70	67	3	170	146	24	26	18	8

### ХҮСНЭГТ 3. ӨРХИЙН ТОО, ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН НАСНЫ БҮЛЭГ, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ, ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010 ОН

Насны бүлэг	Бүгд		Огт гэр бүл болоогүй		Баллуусан гэр бүлгүй		Батлуулаагүй гэр бүлгүй		Тусгаарласан		Цуцлсан		Бэлбэсэн								
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй							
<b>УЛСЫН ДҮҮН-БҮГД</b>	<b>713 780</b>	<b>560 224</b>	<b>153 556</b>	<b>69 016</b>	<b>39 530</b>	<b>29 486</b>	<b>464 942</b>	<b>436 742</b>	<b>28 200</b>	<b>67 777</b>	<b>54 645</b>	<b>13 132</b>	<b>14 130</b>	<b>5 354</b>	<b>8 776</b>	<b>21 169</b>	<b>7 456</b>	<b>13 713</b>	<b>76 746</b>	<b>16 497</b>	<b>60 249</b>
15-19	6 808	4 412	2 396	6 011	3 818	2 258	292	249	43	426	340	86	10	4	6	3	1	2	1	-	1
20-24	45 627	37 301	8 326	17 191	11 293	5 898	21 581	20 423	1 158	6 153	5 365	788	390	140	250	191	69	122	121	11	110
25-29	83 810	73 254	10 556	12 709	8 025	4 684	59 683	57 110	2 573	8 619	7 211	1 408	1 204	431	773	1 089	393	696	506	84	422
30-34	96 018	83 094	12 924	9 071	5 298	3 773	71 380	68 093	3 287	10 076	8 041	2 035	1 884	663	1 221	2 292	795	1 497	1 315	204	1 111
35-39	96 273	80 788	15 485	7 098	3 824	3 274	68 285	64 807	3 478	12 139	9 710	2 429	2 398	856	1 542	3 547	1 171	2 376	2 806	420	2 386
40-44	91 511	73 964	17 547	5 370	2 615	2 755	62 354	58 753	3 601	11 488	9 310	2 178	2 668	956	1 712	4 459	1 514	2 945	5 172	816	4 356
45-49	85 982	67 121	18 861	4 468	1 997	2 471	58 127	54 532	3 595	8 565	6 805	1 760	2 387	915	1 472	4 298	1 487	2 811	8 137	1 385	6 752
50-54	69 061	51 902	17 159	2 804	1 051	1 753	46 571	43 516	3 055	4 844	3 700	1 144	1 612	648	964	2 885	1 008	1 877	10 345	1 979	8 366
55-59	42 687	30 252	12 435	1 537	590	947	27 296	25 284	2 012	2 295	1 762	533	753	332	421	1 311	510	801	9 495	1 774	7 721
60-64	30 564	20 317	10 247	860	316	544	18 375	16 747	1 628	1 242	975	267	366	168	198	545	238	307	9 176	1 873	7 303
65-69	25 087	15 779	9 308	748	297	451	13 702	12 315	1 387	879	681	198	203	94	109	295	136	159	9 260	2 256	7 004
70-74	19 689	11 792	7 897	567	224	343	9 699	8 589	1 110	534	405	129	140	83	57	162	93	69	8 587	2 398	6 189
75, түүнээс дээш	20 663	10 248	10 415	517	182	335	7 597	6 324	1 273	517	340	177	115	64	51	92	41	51	11 825	3 297	8 528
<b>ХОТ-БҮГД</b>	<b>479 503</b>	<b>364 270</b>	<b>115 233</b>	<b>48 091</b>	<b>26 308</b>	<b>21 783</b>	<b>300 536</b>	<b>276 235</b>	<b>24 301</b>	<b>54 176</b>	<b>42 893</b>	<b>11 283</b>	<b>10 771</b>	<b>3 630</b>	<b>7 141</b>	<b>16 983</b>	<b>5 406</b>	<b>11 577</b>	<b>48 946</b>	<b>9 798</b>	<b>39 148</b>
15-19	5 768	3 554	2 214	5 186	3 090	2 096	211	176	35	361	286	75	8	2	6	1	-	1	-	-	-
20-24	33 159	25 951	7 208	13 454	8 236	5 218	14 241	13 279	962	4 998	4 304	694	266	78	188	139	49	90	61	5	56
25-29	55 291	46 742	8 549	9 006	5 152	3 854	37 444	35 274	2 170	6 999	5 798	1 201	823	245	578	750	240	510	269	33	236
30-34	62 907	52 457	10 450	6 183	3 245	2 938	44 573	41 694	2 879	8 256	6 484	1 772	1 402	432	970	1 725	514	1 211	768	88	680
35-39	63 997	51 524	12 473	4 801	2 492	2 399	42 772	39 696	3 076	9 918	7 789	2 129	1 839	571	1 268	2 845	830	2 015	1 822	236	1 586
40-44	61 028	47 282	13 746	3 475	1 613	1 862	39 415	36 236	3 179	9 085	7 202	1 883	2 071	649	1 422	3 583	1 086	2 497	3 399	496	2 903
45-49	58 844	44 298	14 546	2 658	1 193	1 465	38 506	35 338	3 168	6 679	5 164	1 515	1 892	642	1 250	3 575	1 123	2 452	5 534	838	4 696
50-54	46 767	34 109	12 658	1 463	544	919	31 043	28 369	2 674	3 757	2 782	975	1 273	475	798	2 401	776	1 625	6 830	1 163	5 667
55-59	28 885	20 029	8 856	781	343	438	18 402	16 650	1 752	1 765	1 320	445	595	251	344	1 100	402	698	6 242	1 063	5 179
60-64	21 033	13 828	7 205	385	160	225	12 829	11 434	1 395	956	736	220	289	128	161	458	195	263	6 116	1 175	4 941
65-69	16 482	10 380	6 102	306	154	152	9 317	8 186	1 131	647	497	150	150	68	82	226	94	132	5 836	1 381	4 455
70-74	12 536	7 555	4 981	208	94	114	6 541	5 635	906	378	286	92	90	53	37	115	69	46	5 204	1 418	3 786
75, түүнээс дээш	12 806	6 561	6 245	185	82	103	5 242	4 268	974	377	245	132	73	36	37	65	28	37	6 864	1 902	4 962
<b>Хөдөө-бүгд</b>	<b>234 277</b>	<b>195 954</b>	<b>38 323</b>	<b>20 925</b>	<b>13 222</b>	<b>7 703</b>	<b>164 406</b>	<b>160 507</b>	<b>3 899</b>	<b>13 601</b>	<b>11 752</b>	<b>1 849</b>	<b>3 359</b>	<b>1 724</b>	<b>1 635</b>	<b>4 186</b>	<b>2 050</b>	<b>2 136</b>	<b>27 800</b>	<b>6 699</b>	<b>21 101</b>
15-19	1 040	858	182	890	728	162	81	73	8	65	54	11	2	2	2	2	1	1	-	-	-
20-24	12 468	11 350	1 118	3 737	3 057	680	7 340	7 144	196	1 155	1 061	94	124	62	62	52	20	32	60	6	54
25-29	28 519	26 512	2 007	3 703	2 873	830	22 239	21 836	403	1 620	1 413	207	381	186	195	339	153	286	237	51	186
30-34	33 111	30 637	2 474	2 888	2 053	835	26 807	26 399	408	1 820	1 557	263	482	231	251	567	281	286	547	116	431
35-39	32 276	29 264	3 012	2 297	1 422	875	25 513	25 111	402	2 221	1 921	300	559	285	274	702	341	361	984	184	800
40-44	30 483	26 682	3 801	1 895	1 002	893	22 939	22 517	422	2 403	2 108	295	597	307	290	876	428	448	1 773	320	1 453
45-49	27 138	22 823	4 315	1 810	804	1 006	19 621	19 194	427	1 886	1 641	245	495	273	222	723	364	359	2 603	547	2 056
50-54	22 294	17 793	4 501	1 341	507	834	15 528	15 147	381	1 087	918	169	339	173	166	484	232	252	3 515	816	2 699
55-59	13 802	10 223	3 579	756	247	509	8 894	8 634	260	530	442	88	158	81	77	211	108	103	3 253	711	2 542
60-64	9 531	6 489	3 042	475	156	319	5 546	5 313	233	286	239	47	77	40	37	87	43	44	3 060	698	2 362
65-69	8 605	5 399	3 206	442	143	299	4 385	4 129	256	232	184	48	53	26	27	69	42	27	3 424	875	2 549
70-74	7 153	4 237	2 916	359	130	229	3 158	2 954	204	156	119	37	50	30	20	47	24	23	3 383	980	2 403
75, түүнээс дээш	7 587	3 687	4 170	332	100	232	2 355	2 056	299	140	95	45	42	28	14	27	13	14	4 961	1 395	3 566

ХҮСНЭГТ 4. ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭЦЭГ, ЭХИЙН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ГЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010 ОН

Насны бүлэг	Бүгд		Эх		Эцэг		Огт гэр бүл болоогүй		Тусгаарласан		Цуцлсан		Бэлбэсэн		
	Бүгд	Эцэг	Эх	Бүгд	Эцэг	Эх	Бүгд	Эцэг	Бүгд	Эцэг	Бүгд	Эцэг	Бүгд	Эцэг	
<b>УЛСЫН ДҮН-БҮГД</b>	<b>83 929</b>	<b>14 771</b>	<b>69 158</b>	<b>12 862</b>	<b>1 023</b>	<b>11 839</b>	<b>9 170</b>	<b>1 822</b>	<b>7 348</b>	<b>13 393</b>	<b>2 223</b>	<b>11 170</b>	<b>48 504</b>	<b>9 703</b>	<b>38 801</b>
15-19	78	11	67	71	11	60	5	-	5	11	-	1	1	-	1
20-24	1 144	144	1 000	699	93	606	222	27	195	111	16	95	112	8	104
25-29	3 600	385	3 215	1 690	128	1 562	770	95	675	684	98	586	456	64	392
30-34	6 295	750	5 545	2 141	162	1 979	1 315	199	1 116	1 588	213	1 375	1 251	176	1 075
35-39	9 151	1 200	7 951	2 254	155	2 099	1 739	321	1 418	2 513	368	2 145	2 645	356	2 289
40-44	11 478	1 650	9 828	1 954	147	1 807	1 862	356	1 506	3 030	491	2 559	4 612	656	3 956
45-49	12 692	1 986	10 706	1 676	136	1 540	1 550	346	1 204	2 666	443	2 223	6 800	1 061	5 739
50-54	11 654	2 037	9 617	1 116	81	1 035	970	237	733	1 676	308	1 368	7 892	1 411	6 481
55-59	8 035	1 444	6 591	562	46	516	391	114	277	654	142	512	6 428	1 142	5 286
60-64	6 159	1 235	4 924	260	25	235	168	55	113	250	66	184	5 481	1 089	4 392
65-69	5 190	1 304	3 886	212	18	194	97	33	64	113	35	78	4 768	1 218	3 550
70-74	4 005	1 162	2 843	139	11	128	46	20	26	55	29	26	3 765	1 102	2 663
75, түүнээс дээш	4 448	1 463	2 985	88	10	78	35	19	16	32	14	18	4 293	1 420	2 873
<b>ХОТ-БҮГД</b>	<b>60 381</b>	<b>9 942</b>	<b>50 439</b>	<b>8 199</b>	<b>712</b>	<b>7 487</b>	<b>7 404</b>	<b>1 340</b>	<b>6 064</b>	<b>11 275</b>	<b>1 738</b>	<b>9 537</b>	<b>33 503</b>	<b>6 152</b>	<b>27 351</b>
15-19	55	7	48	49	7	42	5	-	5	-	-	-	1	-	1
20-24	776	102	674	481	69	412	161	17	144	78	12	66	56	4	52
25-29	2 468	246	2 222	1 173	92	1 081	560	60	500	497	71	426	238	23	215
30-34	4 487	473	4 014	1 484	121	1 363	1 018	132	886	1 254	146	1 108	731	74	657
35-39	6 766	815	5 951	1 548	114	1 434	1 403	230	1 173	2 092	271	1 821	1 723	200	1 523
40-44	8 489	1 163	7 326	1 297	109	1 188	1 540	265	1 275	2 584	387	2 197	3 068	402	2 666
45-49	9 397	1 356	8 041	1 005	88	917	1 289	247	1 042	2 348	365	1 983	4 755	656	4 099
50-54	8 278	1 350	6 928	592	53	539	818	197	621	1 462	251	1 211	5 406	849	4 557
55-59	5 670	944	4 726	271	22	249	325	91	234	569	116	453	4 505	715	3 790
60-64	4 462	846	3 616	109	14	95	143	46	97	222	56	166	3 988	730	3 258
65-69	3 649	868	2 781	94	9	85	82	29	53	99	27	72	3 374	803	2 571
70-74	2 798	788	2 010	56	4	52	34	14	20	42	24	18	2 666	746	1 920
75, түүнээс дээш	3 086	984	2 102	40	10	30	26	12	14	28	12	16	2 992	950	2 042
<b>ХӨДӨӨ-БҮГД</b>	<b>23 548</b>	<b>4 829</b>	<b>18 719</b>	<b>4 663</b>	<b>311</b>	<b>4 352</b>	<b>1 766</b>	<b>482</b>	<b>1 284</b>	<b>2 118</b>	<b>485</b>	<b>1 633</b>	<b>15 001</b>	<b>3 551</b>	<b>11 450</b>
15-19	23	4	19	22	4	18	-	-	-	1	-	1	-	-	-
20-24	368	42	326	218	24	194	61	10	51	33	4	29	56	4	52
25-29	1 132	139	993	517	36	481	210	35	175	187	27	160	218	41	177
30-34	1 808	277	1 531	657	41	1 616	297	67	230	334	67	267	520	102	418
35-39	2 385	385	2 000	706	41	665	336	91	245	421	97	324	922	156	766
40-44	2 989	487	2 502	657	38	619	322	91	231	466	104	362	1 544	254	1 290
45-49	3 295	630	2 665	671	48	623	261	99	162	318	78	240	2 045	405	1 640
50-54	3 376	687	2 689	524	28	496	152	40	112	214	57	157	2 486	562	1 924
55-59	2 365	500	1 865	291	24	267	66	23	43	85	26	59	1 923	427	1 496
60-64	1 697	389	1 308	151	11	140	25	9	16	28	10	18	1 493	359	1 134
65-69	1 541	436	1 105	118	9	109	15	4	11	14	8	6	1 394	415	979
70-74	1 207	374	833	83	7	76	12	6	6	13	5	8	1 099	356	743
75, түүнээс дээш	1 362	479	883	48	-	48	9	7	2	4	2	2	1 301	470	831

ХҮСНЭГТ 5. ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭЦЭГ, ЭХИЙН ТОО, НАСНЫ БҮЛЭГ,  
ӨРХИЙН ХЭЛБЭР, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010 ОН

Насны бүлэг	Бүгд			Ам бүлээрээ			Нийлмэл			Холимог		
	Бүгд	Эцэг	Эх	Бүгд	Эцэг	Эх	Бүгд	Эцэг	Эх	Бүгд	Эцэг	Эх
<b>УЛСЫН ДҮН-БҮГД</b>	<b>83 929</b>	<b>14 771</b>	<b>69 158</b>	<b>52 281</b>	<b>9 058</b>	<b>43 223</b>	<b>29 727</b>	<b>5 411</b>	<b>24 316</b>	<b>1 921</b>	<b>302</b>	<b>1 619</b>
15-19	78	11	67	47	1	46	30	9	21	1	1	-
20-24	1 144	144	1 000	760	44	716	348	87	261	36	13	23
25-29	3 600	385	3 215	2 632	231	2 401	882	140	742	86	14	72
30-34	6 295	750	5 545	4 730	528	4 202	1 394	198	1 196	171	24	147
35-39	9 151	1 200	7 951	6 928	893	6 035	1 971	288	1 683	252	19	233
40-44	11 478	1 650	9 828	8 458	1 252	7 206	2 676	345	2 331	344	53	291
45-49	12 692	1 986	10 706	8 471	1 462	7 009	3 874	479	3 395	347	45	302
50-54	11 654	2 037	9 617	6 851	1 352	5 499	4 536	640	3 896	267	45	222
55-59	8 035	1 444	6 591	4 292	893	3 399	3 593	524	3 069	150	27	123
60-64	6 159	1 235	4 924	2 976	681	2 295	3 107	538	2 569	76	16	60
65-69	5 190	1 304	3 886	2 311	591	1 720	2 805	699	2 106	74	14	60
70-74	4 005	1 162	2 843	1 828	540	1 288	2 129	611	1 518	48	11	37
75, түүнээс дээш	4 448	1 463	2 985	1 997	590	1 407	2 382	853	1 529	69	20	49
<b>ХОТ-БҮГД</b>	<b>60 381</b>	<b>9 942</b>	<b>50 439</b>	<b>34 501</b>	<b>5 437</b>	<b>29 064</b>	<b>24 364</b>	<b>4 265</b>	<b>20 099</b>	<b>1 516</b>	<b>240</b>	<b>1 276</b>
15-19	55	7	48	32	-	32	22	6	16	1	1	-
20-24	776	102	674	471	26	445	274	65	209	31	11	20
25-29	2 468	246	2 222	1 659	126	1 533	745	108	637	64	12	52
30-34	4 487	473	4 014	3 129	297	2 832	1 219	157	1 062	139	19	120
35-39	6 766	815	5 951	4 871	561	4 310	1 698	238	1 460	197	16	181
40-44	8 489	1 163	7 326	5 928	823	5 105	2 274	295	1 979	287	45	242
45-49	9 397	1 356	8 041	5 877	926	4 951	3 242	393	2 849	278	37	241
50-54	8 278	1 350	6 928	4 395	811	3 584	3 677	506	3 171	206	33	173
55-59	5 670	944	4 726	2 665	520	2 145	2 897	403	2 494	108	21	87
60-64	4 462	846	3 616	1 835	393	1 442	2 571	438	2 133	56	15	41
65-69	3 649	868	2 781	1 403	335	1 068	2 185	522	1 663	61	11	50
70-74	2 798	788	2 010	1 071	296	775	1 691	487	1 204	36	5	31
75, түүнээс дээш	3 086	984	2 102	1 165	323	842	1 869	647	1 222	52	14	38
<b>ХӨДӨӨ-БҮГД</b>	<b>23 548</b>	<b>4 829</b>	<b>18 719</b>	<b>17 780</b>	<b>3 621</b>	<b>14 159</b>	<b>5 363</b>	<b>1 146</b>	<b>4 217</b>	<b>405</b>	<b>62</b>	<b>343</b>
15-19	23	4	19	15	1	14	8	3	5	-	-	-
20-24	368	42	326	289	18	271	74	22	52	5	2	3
25-29	1 132	139	993	973	105	868	137	32	105	22	2	20
30-34	1 808	277	1 531	1 601	231	1 370	175	41	134	32	5	27
35-39	2 385	385	2 000	2 057	332	1 725	273	50	223	55	3	52
40-44	2 989	487	2 502	2 530	429	2 101	402	50	352	57	8	49
45-49	3 295	630	2 665	2 594	536	2 058	632	86	546	69	8	61
50-54	3 376	687	2 689	2 456	541	1 915	859	134	725	61	12	49
55-59	2 365	500	1 865	1 627	373	1 254	696	121	575	42	6	36
60-64	1 697	389	1 308	1 141	288	853	536	100	436	20	1	19
65-69	1 541	436	1 105	908	256	652	620	177	443	13	3	10
70-74	1 207	374	833	757	244	513	438	124	314	12	6	6
75, түүнээс дээш	1 362	479	883	832	267	565	513	206	307	17	6	11

### ХҮСНЭГТ 6. ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭЦЭГ, ЭХИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ӨРХИЙН ХЭЛБЭРЭЭР, 2010 ОН

Насны бүлэг	Бүгд			Ам бүлээрээ			Нийлмэл			Холимог		
	Бүгд	Эцэг	Эх	Бүгд	Эцэг	Эх	Бүгд	Эцэг	Эх	Бүгд	Эцэг	Эх
<b>БҮГД</b>	<b>83 929</b>	<b>14 771</b>	<b>69 158</b>	<b>52 281</b>	<b>9 058</b>	<b>43 223</b>	<b>29 727</b>	<b>5 411</b>	<b>24 316</b>	<b>1 921</b>	<b>302</b>	<b>1 619</b>
Архангай	2 420	558	1 862	1 950	444	1 506	442	111	331	28	3	25
Баян-Өлгий	2 299	657	1 642	1 712	451	1 261	580	204	376	7	2	5
Баянхонгор	2 942	573	2 369	2 063	406	1 657	807	160	647	72	7	65
Булган	1 280	356	924	930	255	675	318	92	226	32	9	23
Говь-Алтай	1 465	266	1 199	1 087	209	878	366	57	309	12	-	12
Дорноговь	1 610	263	1 347	1 103	174	929	456	81	375	51	8	43
Дорнод	2 311	366	1 945	1 398	221	1 177	816	132	684	97	13	84
Дундговь	962	188	774	643	119	524	294	64	230	25	5	20
Завхан	1 682	333	1 349	1 240	246	994	415	83	332	27	4	23
Өвөрхангай	2 842	616	2 226	1 901	390	1 511	894	219	675	47	7	40
Өмнөговь	1 622	213	1 409	1 091	137	954	483	70	413	48	6	42
Сүхбаатар	1 287	295	992	853	195	658	403	96	307	31	4	27
Сэлэнгэ	3 028	511	2 517	2 025	345	1 680	931	153	778	72	13	59
Төв	2 426	504	1 922	1 776	369	1 407	608	128	480	42	7	35
Увс	1 926	369	1 557	1 517	295	1 222	377	68	309	32	6	26
Ховд	1 853	329	1 524	1 370	242	1 128	451	83	368	32	4	28
Хөвсгөл	4 501	726	3 775	3 344	541	2 803	1 065	170	895	92	15	77
Хэнтий	2 179	341	1 838	1 545	249	1 296	573	82	491	61	10	51
Дархан-Уул	3 167	540	2 627	1 908	306	1 602	1 196	220	976	63	14	49
Улаанбаатар	38 510	6 155	32 355	20 681	3 096	17 585	16 864	2 904	13 960	965	155	810
Орхон	3 194	533	2 661	1 845	312	1 533	1 269	211	1 058	80	10	70
Говьсүмбэр	423	79	344	299	56	243	119	23	96	5	-	5

### ХҮСНЭГТ 7. ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭЦЭГ, ЭХИЙН ТОО, ХҮҮХДИЙН ТОО, ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГ ЭСЭХ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010 ОН

Насны бүлэг	Бүгд			Хөдөлмөр эрхэлдэг			Хөдөлмөр эрхэлдэггүй		
	Бүгд	Эцэг	Эх	Бүгд	Эцэг	Эх	Бүгд	Эцэг	Эх
